



**ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ СЕНДАЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ БАРИМТ БИЧГИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ДУНД ХУГАЦААНЫ МОНГОЛ
УЛСЫН ТАЙЛАН**

Улаанбаатар хот

2022 он

Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийн хэрэгжилтийн Монгол Улсын дунд хугацааны тайлан

Эмхэтгэн боловсруулсан:



Онцгой байдлын ерөнхий газар (ОБЕГ)

Онцгой байдлын ерөнхий газар
Улаанбаатар хот-14250
Сүхбаатар дүүрэг
Партизаны гудамж-6
Вэбсайт: nema.gov.mn
Имэйл: riskmanagement@nema.gov.mn

Энэхүү тайланд 2015-2022 онд гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр Монгол Улсад хэрэгжүүлсэн арга хэмжээнээс шинэлэг, цар хүрээ өргөнтэй, олон улсад туршлага болохуйц байдал, мөн хүндрэл бэрхшээлийг тодорхойлохдоо нэн тэргүүнд тулгамдаж буй байдлыг харгалзаж тус тус сонгож оруулсан тул уншигч таны хүссэн мэдээлэл багтаагүй бол хүлцэл эрье.

Тайланд орсон мэдээллийг ашиглахдаа эх сурвалжийг дурдана уу.

АГУУЛГА

Товчилсон үг	5
Хүснэгтийн жагсаалт	6
Зургийн жагсаалт	6
ТАЛАРХАЛ	7
УДИРТГАЛ	8
1. ТАНИЛЦУУЛГА	9
1.1. Зорилго	9
1.2. Монголын тухай товчхон: Үндэсний онцлог	9
1.2.1. Газарзүйн байрлал, хүн ам, уур амьсгал	9
1.2.2. Аюулт үзэгдэл, ослын нөхцөл байдал.....	9
1.3. Арга зүй	11
2. МОНГОЛ УЛСАД 2015-2022 ОНД ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТОЙМ	13
2.1. Гамшгийн эрсдэлийн үнэлгээ, мэдээлэл, ойлголтыг нэмэгдүүлэх хүрээнд гарсан ахиц дэвшил	13
2.1.1. Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх үйл ажиллагаанд гарсан ахиц дэвшил	13
2.1.2. Гамшгийн мэдээллийн сангийн хөгжүүлэлт	20
2.1.3 Гамшгийн эрсдэлийг бууруулах мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх хүрээнд гарсан ахиц дэвшил.....	22
2.1.4. Цаашид.....	26
2.2. Гамшгийн эрсдэлийг бууруулах засаглал, удирдлага, зохион байгуулалтад гарсан ахиц дэвшил	27
2.2.1. Бодлогын орчин	27
2.2.2. Эрх зүйн орчин.....	34
2.2.3. Институцийн механизм.....	36
2.2.4. Цаашид.....	41
2.3. Гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгийг тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтад гарсан ахиц дэвшил	41
2.3.1. Хөрөнгө оруулалт	41
2.3.2. Малын индексжүүлсэн даатгалын явц	43
2.3.3. Цаашид.....	44
2.4. Гамшгийн бэлэн байдал, хор уршгийг арилгах, сайжруулан сэргээн босгох ажиллагаанд гарсан ахиц дэвшил	45
2.4.1. Гамшгаас хамгаалах төлөвлөгөө.....	45
2.4.2. Барилгын норм дүрэм шинэчлэгдсэн	46

2.4.3. Өндөр ууланд эрэн хайх, аврах ажиллагаа явуулах арга техник сайжирсан	47
2.4.4. “Говийн чоно” гамшгийн хор уршгийг арилгах олон улсын дадлага сургууль.....	48
2.4.5. Гамшгийн үед ашиглагдах Улаанбаатар хотод байрлах түр цугларах талбай, нүүлгэн шилжүүлэх байршил, түр байр.....	49
2.4.6. Эрт зарлан мэдээлэх систем	52
2.4.7. Хөвсгөл нууранд живсэн хөлөг онгоцыг татан гаргах ажиллагаа.....	52
2.4.8. Цаашид.....	54
3. ТҮНШЛЭЛ, ХАМТЫН АЖИЛЛАГАА	56
3.1. Гадаад хамтын ажиллагаа	56
3.2. Дотоод хамтын ажиллагаа, түншлэл	57
3.3. Төсөл хөтөлбөр	58
4. СЕНДАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ БАРИМТ БИЧГИЙН ЗОРИЛТЫГ ХАНГАХАД ГАРСАН АХИЦ ДЭВШИЛ, ӨӨРЧЛӨЛТ	60
5. НӨХЦӨЛ БАЙДЛЫН ӨӨРЧЛӨЛТ, ШИНЭ БОЛОН ДАХИН СЭРГЭЖ БУЙ АСУУДАЛ, ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛ	62
5.1. Уур амьсгалын өөрчлөлт ба гэнэтийн аюулт үзэгдэл.....	62
5.2. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын нөхцөл байдал, хариу арга хэмжээ	65
6. ДҮГНЭЛТ	68
ХАВСРАЛТ.....	70

Товчилсон үг

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
АБТСХ	“Аврагч” Биеийн тамир, спортын хороо
БСШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
ГАБТХ	Галын аюулгүй байдлын тухай хууль
ГХТХ	Гамшгаас хамгаалах тухай хууль
ГХА	Гамшгаас хамгаалах алба
ДССЗТ	Давтан сургалт, сэргээн заслын төв
ДХИС	Дотоод хэргийн их сургууль
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
МСҮТ	Мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төв
МУЗН	Монголын Улаан загалмай нийгэмлэг
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
УИХ	Улсын Их хурал
УОК	Улсын Онцгой комисс
УАӨ	Уур амьсгалын өөрчлөлт
ҮАБ	Үндэсний аврах бригад
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ШУА	Шинжлэх ухааны академи

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 Гамшгийн эрсдэлийн зэрэглэл (гамшгийн төрлөөр)	16
Хүснэгт 2 Гамшгийн мэдээ бүртгэх загварын хэсгүүдийн агуулгын харьцуулалт	20
Хүснэгт 3 Гамшгийн мэдээ бүртгэх загвар дахь үзүүлэлтийн тооны харьцуулалт	20
Хүснэгт 4 Тэргүүлэх чиглэлийг харьцуулсан байдал	28
Хүснэгт 5 Төлөвлөгөөний хэрэгжилт (Тэргүүлэх чиглэл тус бүрээр)	28
Хүснэгт 6 Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийн I, II үе шатны арга хэмжээний тоо	29
Хүснэгт 7 Бодлогын баримт бичгүүдийн уялдаа	30
Хүснэгт 8 Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний стратеги, Тогтвортой хөгжлийн зорилгын уялдаа	30
Хүснэгт 9 SWOT-АНР шинжилгээнд сонгон авсан шинжилгээ хийх хүчин зүйлс	31
Хүснэгт 10 Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай хуулиуд дахь оролцогч талуудын зохицуулалтанд хийгдсэн шинэчлэлийн харьцуулалт	35
Хүснэгт 11 Гамшгаас хамгаалах улсын албад	40
Хүснэгт 12 Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны санхүүжилтийн эрх зүйн зохицуулалтын харьцуулалт, Гамшгаас хамгаалах тухай хууль 2003, 201	42
Хүснэгт 13 Малын индексжүүлсэн даатгалд хамрагдсан байдал	44
Хүснэгт 14 Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний бүтэц	45
Хүснэгт 15 Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх системийн нөхцөл байдал	52
Хүснэгт 16 Монгол орон дахь УАӨ-ийн нөлөөлөл, түүнээс үүдсэн гамшгийн эрсдэл, эмзэг байдлын өөрчлөлт	63
Хүснэгт 17 Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, гамшгийн эрсдэлийг бууруулах асуудал үндэсний хөгжлийн бодлогын баримт бичигт туссан байдал	64

Зургийн жагсаалт

Зураг 1 Гамшиг, аюулт үзэгдэл, ослын тохиолдлын тоо (2015-2021 он)	9
Зураг 2 Амь насаа алдсан хүний эзлэх хувь 2015-2021 оны дундаж (гамшгийн төрлөөр)	10
Зураг 3 Амь насаа алдсан хүний тоо, аймгаар (2015-2021 оны дундаж)	10
Зураг 4 Амь насаа алдсан хүний эзлэх хувь, хүйсээр (2015-2021 оны дундаж)	10
Зураг 5 Гамшиг, аюулт үзэгдэл, ослын улмаас учирсан хохирол	11
Зураг 6 Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн түвшинд гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийсэн байдал	16
Зураг 7 Сургууль, цэцэрлэгийн хэмжээнд гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийгдсэн байдал	17
Зураг 8 Улаанбаатар төмөр замын 1-р гол хэсгийн усанд автаж болзошгүй цэгүүд	18
Зураг 9 Зудын эрсдэлийн зураглал (2022 оны 10 дугаар сар)	18
Зураг 10 Гамшгийн эрсдэлийн үнэлгээний мэргэжлийн зөвлөлөөр олгосон нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн тоо	19
Зураг 11 Эрдэм шинжилгээ судалгааны ажлын тоо, 2005-2022 он	25
Зураг 12 Лабораторид туршсан сорилтын тоо, 2005-2022 он	25
Зураг 13 Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны стратегийг тодорхойлох график	32
Зураг 14 Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны тогтолцоо	38
Зураг 15 Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны төсвийн хэмжээ	42
Зураг 16 Нийслэлийн хэмжээнд байгаа түр цугларах талбайн байршил	50
Зураг 17 Сургуулийн байршил	51
Зураг 18 Живсэн хөлөг онгоцыг байршуулах үе	54
Зураг 19 Монгол Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах чиглэлээр хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн хамрах хүрээ (байрлалаар)	59
Зураг 20. Амь насаа алдсан хүний тоо (2005-2014, 2015-2021 оны дунджаар)	60
Зураг 21 Улсын хэмжээнд ковид-19-ын эсрэг вакцинд хамрагдсан хүний тоо, насны бүлэг, хүйсээр (2022.10.14-ний байдлаар)	66

ТАЛАРХАЛ

Онцгой байдлын ерөнхий газраас гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийн дунд хугацааны Монгол Улсын тайланг олон холбогдох талуудтай хамтран боловсрууллаа.

Тус тайланг боловсруулсан ОБЕГ-ын ажлын хэсгийн ахлагч (Д.Баасансүрэн), ажлын хэсгийн гишүүд (Д.Базаррагчаа, доктор (PhD) П.Чимидцэрэн, доктор (PhD) В.Батсайхан, Б.Амаржаргал, М.Батмөнх, Г.Мөнхзул, Ц.Бямбацогт, С.Лхагвадулам, Г.Энхцолмон, Ц.Батзаяа, Н.Ананда, Б.Батбаяр)-д талархал илэрхийлье.

Мөн дэмжлэг үзүүлэн оролцсон Тежас Патнайк /НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах газар/, Билл Хо /Азийн гамшгийн бэлэн байдлын төв/, Н.Мөнхцэцэг /Байгаль орчин аялал жуулчлалын яам/, Н.Пүрэвням /Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам/, Г.Наранчулуун /Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам/, Н.Мөнхтуяа /Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам/, Б.Мөнхчулуун /Эрчим хүчний яам/, Н.Отгон /Цахим хөгжил, харилцаа холбооны яам/, Д.Жаргал /Мэргэжлийн хяналтын ерөнхий газар/, доктор (PhD) Б.Саранцэцэг /ДХИС/, доктор (PhD) Ц.Ганчимэг /ДХИС/, А.Билэгт /Халдварт өвчин судлалын үндэсний төв/, Н.Өлзиймаа /Дэлхийн зөн Монгол ОУБ/, С.Батбаяр /Дэлхийн зөн Монгол ОУБ/ нарт гүн талархал илэрхийлье.

УДИРТГАЛ

Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд авч хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичиг (цаашид “Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичиг” гэх)-ийг дэлхий дахинаа хэрэгжүүлээд зорилтот хугацааныхаа дунд үед хүрээд байна.

Энэ хугацаанд Монгол Улс гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр авсан улс төрийн үүрэг амлалтаа хэрэгжүүлж, томоохон өөрчлөлт, ололт амжилтад хүрсэн.

- Эрхзүйн хувьд 2017 онд Гамшгаас хамгаалах тухай хуулийг шинэчилсэн бөгөөд энэ шинэчлэл нь гамшгаас эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд ихээхэн өөрчлөлт, дэвшил авчирсан.

- Бодлогын хувьд үндэсний хэмжээнд “Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр”, “Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги”-ийг Монгол Улсын хөгжлийн баримт бичиг болох “Алсын хараа 2050”, “Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр”-тэй уялдуулан хэрэгжүүлж байна. Үүний үр дүнд гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр олон нийт, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, алслагдмал нутгийн иргэдийн гамшгийг даван туулах чадавхыг бий болгоход чиглэсэн арга хэмжээ мэдэгдэхүйц өссөн.

- Орон нутгийн түвшинд, гамшгийн эрсдэлийн үнэлгээний үр дүнд суурилж Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг 21 аймаг, нийслэл буюу бүх орон нутаг шинэчилж, Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийн “е” зорилтыг хангасан.

Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийг хэрэгжүүлэхдээ бид өнөөгийн эрсдэлийг бууруулах, шинэ эрсдэл үүсэхээс сэргийлэхийг гол зорилго болгон ажиллаж байгаа ч олон шинэ сорилттой тулгарч байна.

Энэхүү тайланд Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийн хэрэгжилтийн эхний хагасын хугацаанд олсон ололт амжилт, тулгарч буй сорил, хүндрэл бэрхшээлийг дүгнэн хэлэлцэж, тулгарч буй асуудлыг цаашид хэрхэн шийдвэрлэх талаар хэлэлцэн тусгалаа.

Нэгдсэн Үндэсний Байгууллага (НҮБ)-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах газраас улс орнуудыг гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны дунд хугацааны тайлан боловсруулах заавар гаргасан бөгөөд тус зааврын дагуу энэхүү тайлангийн бүтэц гаргасан.

Тайланд 2015-2022 онд гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр Монгол Улсад хэрэгжүүлсэн арга хэмжээнээс шинэлэг, цар хүрээ өргөнтэй, олон улсад туршлага болохуйц байдал, мөн хүндрэл бэрхшээлийг тодорхойлохдоо нэн тэргүүнд тулгамдаж буй асуудлыг дэлхийн хэмжээнд дэвшүүлсэн 7 зорилт, тэргүүлэх 4 чиглэлийн хүрээнд тус тус сонгож оруулсан болно.

Эх дэлхий аюулгүй, амгалан тайван байх болтугай.

1. ТАНИЛЦУУЛГА

1.1. Зорилго

Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийн дунд хугацааны Монгол Улсын тайлан нь 2015-2022 онд гамшигын эрсдэлийг бууруулах чиглэлээр Монгол Улсад олсон ололт амжилт, учирсан хүндрэл бэрхшээл, сорилтыг дүгнэн, тулгарч буй асуудлыг цаашид үндэсний болон бүс нутаг, олон улсын хэмжээнд хэрхэн шийдвэрлэж болох арга зам, сайжруулах үйл ажиллагааг тодорхойлох зорилготой.

1.2. Монголын тухай товчхон: Үндэсний онцлог

1.2.1. Газарзүйн байрлал, хүн ам, уур амьсгал


Монгол Улс нь Ази тивд оршдог бөгөөд хойд талаараа Оросын Холбооны Улс, урд талаараа Бүгд Найрамдах Хятад Ард Улстай хиллэдэг, далайд гарцгүй улс юм. Монгол Улс нь нийт 1,564,116 хавтгай дөрвөлжин км газар нутагтай, газар нутгийн хэмжээгээр дэлхийд 19 дүгээрт эрэмбэлэгдэнэ. Нутгийн баруун болон хойд хэсгээр уул нуруу, өмнөд хэсгээр говь цөлөрхөг.

Хүн ам цөөн бөгөөд 2021 оны байдлаар нийт 3,409,939 хүн амтай, үүний 49 хувь (1,674,058) эрэгтэй, 51 хувь (1,735,881) эмэгтэй. Нийт хүн амын 36 хувь (1,229,620) нь 1-17 насны хүүхдүүд эзэлж байна. Хүн амын 69,4 хувь (2,367,635) нь төв суурин газар, 30,5 хувь (1,042,304) хөдөө орон нутагт амьдран суудаг. Улсын хэмжээнд 2018 оны байдлаар 105,730 хөгжлийн бэршээлтэй иргэд /59,691эр, 46,039 эм/ Нийслэл хот нь Улаанбаатар бөгөөд нийт хүн амын 48,07 хувь (1,639,172) оршин сууж байна¹.

Жилийн дөрвөн улиралтай. Эх газрын уур амьсгалтай. Сүүлийн 80 шахам жилийн дотор Монгол орны нутаг дэвсгэр дээрх жилийн дундаж агаарын температур 2.14⁰C-аар дулаарчээ. Агаарын дулаан, хүйтний хувьд илт мэдэгдэж байгаа нэг онцлог өөрчлөлт бол халуун өдрийн тоо (30⁰C, 33⁰C) огцом нэмэгдэж байгаа явдал юм².

1.2.2. Аюулт үзэгдэл, ослын нөхцөл байдал

Монгол оронд тохиолдож буй аюулт үзэгдэл, ослын тохиолдол 2015 онтой харьцуулахад бодитой буурахгүй байна (Зураг 1). Нэн ялангуяа уур амьсгалын гаралтай аюулт үзэгдэл 2.9 дахин нэмэгдсэн байна.



Зураг 1 Гамшиг, аюулт үзэгдэл, ослын тохиолдлын тоо (2015-2021 он)


Монгол Улсын хэмжээнд 2015-2021 онд тохиолдсон гамшиг, аюулт үзэгдэл,

¹ Үндэсний статистикийн хороо, 2021, www.1212.mn


² П.Гомболүүдэв, Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох асуудлыг гамшигын эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа, тогтвортой хөгжлийн зорилттой уялдуулах нь илтгэл, 2019

осол (КОВИД-19 халдварын дата мэдээг оролцуулсан)-ын улмаас нийт 3501 хүн амь насаа алдсан байна. 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар КОВИД-19 цар тахлын улмаас 1987 хүн амь насаа алдсан.


Гамшиг, аюулт үзэгдэл, ослын улмаас амь насаа алдсан хүнийг гамшгийн төрлөөр нь авч үзвэл усны осол 55%, объектын гал түймэр 28%-ийг эзэлж байна (Зураг 2). Улаанбаатар хотод амь насаа алдсан хүний тоо хамгийн их бүртгэгдсэн байна (Зураг 3). Учирсан хохирлын хувьд 2016, 2017, 2018 онд хамгийн өндөр үзүүлэлттэй байна (Зураг 5).




Зураг 2 Амь насаа алдсан хүний эзлэх хувь 2015-2021 оны дундаж (гамшгийн төрлөөр)



Зураг 3 Амь насаа алдсан хүний тоо, аймгаар (2015-2021 оны дундаж)



Зураг 4 Амь насаа алдсан хүний эзлэх хувь, хүйсээр (2015-2021 оны дундаж)



Зураг 5 Гамшиг, аюулт үзэгдэл, ослын улмаас учирсан хохирол (2015-2021 он, КОВИД-19 цар тахлаас учирсан хохирол ороогүй, тэрбум төгрөгөөр)

1.3. Арга зүй

Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийн дунд хугацааны Монгол Улсын тайлангийн бүтцийн хувьд НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах газраас гишүүн орнуудад зориулан гаргасан дунд хугацааны тайлангийн зааврын дагуу боловсруулсан³.

Агуулгыг гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний стратеги, хөтөлбөр, холбогдох баримт бичиг, журам, заавар, тэдгээрийн хэрэгжилтийн тайлан, үр дүн, эрдэм шинжилгээ, судалгааны ажил, ОБЕГ-ын даргын 2022 оны А/212 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн хэлэлцүүлэг, ярилцлага, гамшгийн эрсдэлийг бууруулах холбогдох талуудын уулзалт болон бусад холбогдох мэдээлэл, материалд суурилан боловсруулсан.

Тодруулбал, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2022 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн батлагдсан удирдамжийн дагуу холбогдох талуудын 30 орчим төлөөллөөс бүрдсэн явцын үндэсний хэмжээний хэлэлцүүлэг уулзалтыг 9 дүгээр сарын 06-ны өдөр зохион байгуулсан. Тус үндэсний хэмжээний хэлэлцүүлэг уулзалтаар загвар зөвлөмж, асуумжийн хүрээнд оролцогчид 2 бүлэгт хуваагдан хэлэлцэн, боловсруулсан тайлангийн төсөлд сайжруулалт хийсэн. Хэлэлцүүлэгт үндэсний хэмжээнд гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд чухал үүрэг бүхий яам, агентлаг, олон улсын байгууллага тухайлбал, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Барилга, хот байгуулалтын яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Эрчим хүчний яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар, Гамшиг судлалын үндэсний хүрээлэн, Халдварт өвчин судлалын үндэсний төв болон Дэлхийн зөн Монгол Олон улсын байгууллагын төлөөлөл оролцсон юм. Мөн хэлэлцүүлгийн үеэр НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах газрын Ази, Номхон далайн бүсийн төвийн ажилтан Тежас Патнайк, Азийн гамшгийн бэлэн байдлын төвийн захирал Билл Хо нар байлцаж зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн.

Энэхүү дунд хугацааны хэрэгжилтийн тайланг боловсруулахад дүн шинжилгээ, харьцуулалт, бичиг баримтын шинжилгээ, бүлгийн ярилцлага, SWOT-АHP,

³ United Nations Office for Disaster Risk Reduction, Guidance for UN Member States, the Midterm Review of the Implementation of the Sendai Framework for Disaster Risk Reduction 2015-2030, National Consultations and Reporting, 2022

хамаарал, нөлөөлөл тодорхойлох, нэгтгэн дүгнэх зэрэг шинжлэх ухааны аргуудыг ашигласан.

Тус тайланд Монгол Улсын хэмжээнд мөрдөгдөн хэрэгжиж буй холбогдох баримт бичиг, журам, заавар, тэдгээрийн хэрэгжилтийн тайлан, үр дүн, энэ чиглэлээр хийгдсэн эрдэм шинжилгээ, судалгааны тайлан, ном, гарын авлага болон бусад холбогдох материалыг эх сурвалж болгон боловсруулсан болно.

2. МОНГОЛ УЛСАД 2015-2022 ОНД ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТОЙМ

Үр дүн, зорилгод хүрэх ахиц дэвшил

Гамшгийн эрсдэлийг бууруулах Дэлхийн III бага хурлаас 2015 онд батлан гаргасан “Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд авч хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичиг”-т 2030 он гэхэд дараах үр дүн, зорилгод хүрнэ гэж тодорхойлсон. Үүнд:

Хүрэх үр дүн: Гамшгийн эрсдэл, түүний улмаас хүний амь нас, эрүүл мэнд, амьжиргаа, ард иргэд, бизнес, олон нийт, улс орны эдийн засаг, нийгэм, биет болон соёлын үнэт зүйл, хүрээлэн буй орчинд учрах хохирлын хэмжээг бодитой бууруулах.

Зорилго: Аюулд өртөх байдал, гамшигт эмзэг байдлаас урьдчилан сэргийлэх, бууруулах, гамшгийн хор уршгийг арилгах, сэргээн босгох бэлэн байдлыг сайжруулж, гамшигтай тэмцэх чадавхыг бэхжүүлэх эдийн засгийн, бүтцийн, хууль, эрх зүйн, нийгмийн, эрүүл мэндийн, соёлын, боловсролын, байгаль орчны, технологийн, улс төрийн болон институцийн нэгдмэл, харилцан уялдаатай арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх замаар гамшгийн эрсдэлийг бууруулах, шинэ эрсдэл үүсэхээс сэргийлэх⁴.

Олон улсын түвшинд дэвшүүлсэн зорилго, үр дүнд хүрэхийн тулд улс орнууд өөр өөрийн зорилго, зорилтыг дэвшүүлэн, хүчин чармайлтаа гарган ажиллаж байна. Монгол Улсын гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний стратеги болох Засгийн газрын 2017 оны 355 дугаар тогтоолоор батлагдсан “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги”-ийн зорилгыг “Гамшгийн аюул, өртөнгө, эмзэг байдлыг бууруулах, гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, гамшгийн хор уршгийг арилгах, сэргээн босгох үйл ажиллагааг сайжруулж, гамшигтай тэмцэх чадавхыг бэхжүүлэх замаар гамшгийн эрсдэлийг бууруулж, шинэ эрсдэл үүсэхээс сэргийлэх” гэж тодорхойлсон.

Энэхүү зорилгын хүрээнд 2015-2022 оны хугацаанд Монгол Улсад хэрэгжүүлсэн томоохон арга хэмжээ, тулгарч буй хүндрэл бэрхшээл, олсон ололт амжилт, ахиц дэвшил, цаашид Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийн II хагаст авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний саналыг танилцуулъя. Үүнд:

2.1. Гамшгийн эрсдэлийн үнэлгээ, мэдээлэл, ойлголтыг нэмэгдүүлэх хүрээнд гарсан ахиц дэвшил

2.1.1. Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх үйл ажиллагаанд гарсан ахиц дэвшил

Гамшгийн эрсдэлийн үнэлгээний эрх зүйн орчин

⁴ United Nations, Sendai Framework for disaster Risk Reduction 2015-2030 (17, 20 дахь тал), 2015

Гамшгийн эрсдэлийн үнэлгээний эрх зүйн орчинг сайжруулах, улсын болон орон нутгийн түвшинд гамшгийн эрсдэлийг тодорхойлох үйл ажиллагаанд томоохон өөрчлөлт гарсан.

Гамшгийн эрсдэлийн үнэлгээний эрх зүйн орчны хувьд 2017 онд шинэчлэн найруулан батлагдсан Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлд гамшгийн эрсдэлийн үнэлгээний зохицуулалтыг тусгасан. Тус эрх зүйн зохицуулалтыг хангах хүрээнд дараах баримт бичгийг боловсруулан баталгаажуулж, гамшгийн эрсдэлийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээг улс, орон нутаг, байгууллага, олон нийт, объектын түвшинд гүйцэтгэн ажиллаж байна.

- “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам” Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 63 дугаар тогтоолоор батлуулж, Гамшгаас хамгаалах тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу Засгийн газрын 2020 оны 190 дүгээр тогтоолоор шинэчлэн найруулсан. Тус журамд гамшгийн эрсдэлийн үнэлгээг ерөнхий болон нарийвчилсан байдлаар засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, хуулийн этгээд, стратегийн болон онц чухал объектын түвшинд 3 жил тутамд, эсхүл нөхцөл байдлаас хамааран тухай бүр хийнэ гэж заасан.
- “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх заавар”-ыг Монгол Улсад зонхилон тохиолддог гамшгийн 10 төрлөөр “MNS ISO 31000:2020 Эрсдэлийн менежмент: Удирдамж” стандарт, гамшгийн эрсдэлийн үнэлгээнд баримтлах зарчим, хамаарах асуудал, тооцох шаардлагатай үзүүлэлтэд суурилан боловсруулж, Шадар сайдын тушаалаар (Өмнөх хувилбар: Шадар сайдын 2018 оны 125, 2019 оны 100, 125, 2020 оны 160 дугаар тушаал; Шинэчлэн найруулсан хувилбар: 2021 оны 68 дугаар тушаал)-аар батлуулсан. Үүнд:



Гамшгийн эрсдэлийн үнэлгээний нийтлэг заавар



Ган, зудын эрсдэлийн үнэлгээ хийх заавар



Барилга, байгууламжийн гал түймрийн эрсдэлийн үнэлгээ хийх аргачилсан заавар



Ой, хээрийн гал түймрийн эрсдэлийн үнэлгээ хийх заавар



Хуулийн этгээдийн газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээ хийх заавар



Үерийн эрсдэлийн үнэлгээ хийх заавар



Химийн ослын эрсдэлийн үнэлгээ хийх заавар



Цацрагийн ослын эрсдэлийн үнэлгээ хийх заавар



Мал, амьтны гоц халдварт, зооноз өвчний эрсдэлийн үнэлгээ хийх заавар



Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн түвшинд газар хөдлөлтийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийх заавар



Ил, далд уурхай, баяжуулах үйлдвэрийн гамшгийн эрсдэлийн үнэлгээний нийтлэг заавар

- Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгад гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээг тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд гүйцэтгэхээр тусгасан нь гамшгаас хамгаалах салбарт төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлэх нэгэн шинэ алхам болсон. 2003 онд батлагдсан Гамшгаас хамгаалах тухай хуулийн анхны хувилбарт “Гамшгийн эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын томилсон ажлын хэсэг хийнэ” гэж заасны дагуу ОБЕГ, Гамшиг судлалын үндэсний хүрээлэн, бусад төрийн болон төрийн бус байгууллагын алба хаагчдаас бүрдсэн ажлын хэсэг гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийж байсан боловч үнэлгээний ажлын цар хүрээ хязгаарлагдмал байв. Хуулийн этгээдэд Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох харилцааг зохицуулах Гамшгийн эрсдэлийн үнэлгээний мэргэжлийн зөвлөлийг байгуулж, ажиллах журмыг Шадар сайдын 2018 оны 45 дугаар тушаалаар батлуулж, 2021 оны 100 дугаар тушаалаар шинэчлэн найруулсан.


Мэргэжлийн зөвлөлийг ОБЕГ-ын дарга тэргүүлж, ОБЕГ, ОБЕГ-ын дэргэдэх Гамшиг судлалын үндэсний хүрээлэн, Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургууль, Байгаль орчин, аялал жуулчлал, Барилга, хот байгуулалт, Соёл, Зам, тээврийн хөгжил, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр, Эрүүл мэндийн зэрэг яамд, иргэний нийгмийн төлөөллөөс бүрдсэн 17 гишүүнтэй. Тус зөвлөлийн хуралдааны шийдвэрээр 2019-2022 оны хугацаанд нийт 33 хуулийн этгээдэд гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл олгосон.

- ОБЕГ-ын даргын тушаалаар “Гамшгийн эрсдэлийн үнэлгээний тайланд тавигдах шалгуур үзүүлэлт” (*анхны хувилбар*: 2018 оны А/188; *Шинэчлэн найруулсан хувилбар*: 2021 оны 255 дугаар тушаал), “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл хүсэхэд ашиглагдах загвар” (2018 оны А/192), “Гамшгийн эрсдэлийн үнэлгээний мэргэшүүлэх сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам” (2019 оны А/145)-ыг шинээр боловсруулан албажуулснаар гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх эрх зүйн орчин бүрдсэн.

Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ

Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг богино хугацаанд гамшгийн эрсдэлийг тойм байдлаар тодорхойлох, гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, хор уршгийг арилгах арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх зорилгоор хийнэ. Ерөнхий үнэлгээг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага холбогдох салбар, эрдэмтэн, судлаач, иргэд, олон нийтийн төлөөлөл хийж байна. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн түвшинд гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ, төрийн өмчийн цэцэрлэг сургуулийн гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ, авто болон төмөр замын үерийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ, ган зудын гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг онцольё.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн түвшинд гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг 2016 оны байдлаар зөвхөн 8 хувьд хийсэн байсан бол эрх зүйн орчин бүрдсэнээр 2019 онд 71 хувь, 2020 онд 100 хувь хийж гүйцэтгэсэн (Зураг 6).



Зураг 6 Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн түвшинд гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийсэн байдал

Эдгээр ерөнхий үнэлгээг “Индикаторын аргачлал”, “Олон нийтэд суурилсан гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээний аргачлал”-ыг ашиглан гүйцэтгэсэн. Ерөнхий үнэлгээ хийх ажлын хэсэгт төрийн байгууллага, төрийн бус байгууллага, бизнесийн байгууллага, өндөр настан иргэд, тухайн орон нутагтаа удаан жил оршин сууж буй иргэд, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн төлөөллийг, хүйсийн хувьд эрэгтэй эмэгтэй хүмүүсийг ойролцоо тоотой оролцуулахыг хичээсэн. Сумдын үнэлгээний дунджаар аймгийнх, аймаг, нийслэлийн үнэлгээний дунджаар улсын хэмжээнд эрсдэлийн зэргийг тодорхойлоход улсын хэмжээнд эрсдэлийн зэрэглэл ДУНД дүгнэгдсэн бол, ган “өндөр (60-аас дээш оноо)”, хүчтэй салхи шуурга, мал, амьтны гоц халдварт өвчин, газар хөдлөлт, үер зэрэг бусад гамшиг, аюулт үзэгдлийн эрсдэл “дунд (30-59 оноо)” гэж дүгнэгдсэн (Хүснэгт 1).


Хүснэгт 1 Гамшгийн эрсдэлийн зэрэглэл (гамшгийн төрлөөр)

Ган	Зуд	Хүчтэй салхи	Мал, амьтны халдварт өвчин	Объектын гал түймэр	Үер	Ой, хээрийн түймэр	Усны осол	Газар хөдлөлт
Өндөр 62	Дунд 50	Дунд 50	Дунд 51	Дунд 48.2	Дунд 46	Дунд 39,6	Дунд 39	Дунд 36

ОБЕГ-т хэрэгжиж буй Ядуурлыг бууруулах Японы сангийн санхүүжилтээр “ТА-9880 MON: Гамшгийн эрсдэлийн үнэлгээ, төлөвлөлт болон эрсдэлийг шилжүүлэх


чадавхыг бэхжүүлэх төслийн хүрээнд гамшгийн 10 төрлөөр үндэсний хэмжээний гамшгийн аюул, өртөх байдал, эмзэг байдлыг үнэлж, зураглал боловсруулж байна. Үнэлгээний үр дүнг удахгүй олон нийтэд хүртээмжтэйгээр хүргэнэ.

Улсын хэмжээнд сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургууль, их, дээд сургууль, сургуулийн дотуур байранд гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг хийхэд анхааран ажиллаж байна. Хүүхэд өдрийн ихэнх цагийг цэцэрлэг, сургууль дээр өнгөрөөдөг, аливаа гамшгийн үед нэмэлт тусламж шаардлагатай эмзэг бүлэгт хамаарах тул сургууль, цэцэрлэгийн аюулгүй байдлыг хангах, эрсдэлийг бууруулах, багш сурагчдын мэдлэг ойлголт, гамшгаас хамгаалах чадавхыг нэмэгдүүлэх нь нэн чухал асуудал юм. Иймд 2019-2022 онд сургууль, цэцэрлэгийн багш, сурагч, эцэг эхийн оролцоотойгоор аймгийн хэмжээнд төрийн өмчийн сургууль, цэцэрлэгийн 76 хувь, нийслэлийн бүх сургуульд 100 хувь буюу улсын хэмжээнд 85 хувьд гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг хийж гүйцэтгэсэн байна (Зураг 7). Гамшгийн эрсдэлийг тоймлон тодорхойлоход цэцэрлэг, сургууль харьцангуй өөр өөр үр дүнтэй байгаа боловч улсын дунджаар тооцоолоход **газар хөдлөлтийн эрсдэл өндөр, объектын гал түймэр, хүчтэй салхи шуурга, үерийн гамшгийн эрсдэл дунд** гэж дүгнэгдэж байна.




Зураг 7 Сургууль, цэцэрлэгийн хэмжээнд гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийгдсэн байдал

Зам, тээврийн салбарын түвшинд олон улс, улсын чанартай авто болон төмөр замд учирч болзошгүй үерийн гамшгийн ерөнхий үнэлгээг аюул, түүнд өртөх магадлал, эмзэг байдал, үерийн аюулыг даван туулах чадавхын үзүүлэлтээр 2020 онд Зам, тээврийн хөгжлийн яам, Онцгой байдлын ерөнхий газрын хамтарсан ажлын хэсэг хийсэн. Үнэлгээний зураглалаас харахад улсын хэмжээнд авто замд үерийн усанд өртөж болзошгүй 1250 цэг, 1115 км төмөр зам дагуу 52 цэг байгааг тодорхойлсон байна.



Зураг 8 Улаанбаатар төмөр замын 1-р гол хэсгийн усанд автаж болзошгүй цэгүүд

Ган, зудын гамшгийн эрсдэлийг орон нутгийн түвшинд урт хугацаанд тоймлон гаргахаас гадна тухайн зун гантай байгаа нутаг, ирэх өвөл нь зуд тохиолдож болзошгүй байдлыг Улсын онцгой комисс (УОК)-ын даргын шийдвэрээр Шуурхай бүлэг байгуулагдан жил бүр үнэлдэг. Шуурхай бүлгийн бүрэлдэхүүнд ОБЕГ, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Ус, цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн болон бусад холбогдох төрийн байгууллагын төлөөлөл багтана.



Зураг 9 Зудын эрсдэлийн зураглал (2022 оны 10 дугаар сар)

Уур амьсгалын өөрчлөлт, хотжилт, үйлдвэрлэл зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан Монгол Улсад тохиолдож болзошгүй гамшгийн эрсдэл, аюулт үзэгдэл, осол нэмэгдэж, хавсарсан нийлмэл, ар араасаа цуварсан шинж чанартай нөлөөллийг дагуулах магадлал өндөр байна. Тухайлбал, уур амьсгалын өөрчлөлтөөс улбаатай гангийн эрсдэл нэмэгдэх, гантай жил ой, хээрийн түймэр, дараа жил өвөл зуд болох магадлал нэмэгдэх, зудын дараа малын сэг зэмээс халдварт өвчин, гэнэтийн үерийн дараа нь гэдэсний халдварт өвчин нэмэгдэх гэх мэт. Энэ чиглэлээр хийх судалгаа, шинжилгээний ажлыг нэмэгдүүлэх шаардлагатай.


Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ

Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээг гамшгийн эрсдэлийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр мэргэжлийн түвшинд нарийвчлан тодорхойлох, болзошгүй хохирлын хэмжээг тооцох, түүнээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, аврах, хор уршгийг арилгах арга хэмжээг төлөвлөх зорилгоор хийж байна. Гамшгийн эрсдэлийн үнэлгээний мэргэжлийн зөвлөлийн шийдвэрээр нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрлийг 2019 онд 6, 2020 онд 20, 2021 онд 4, 2022 онд 3, нийт **33** хуулийн этгээдэд олгосон (Зураг 10). Эдгээр тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдүүд 2019 онд 10, 2020 онд 125, 2021 онд 147, 2022 онд 116 буюу нийт **398** аж ахуйн нэгж, байгууллагад гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийж гүйцэтгэсэн.



Зураг 10 Гамшгийн эрсдэлийн үнэлгээний мэргэжлийн зөвлөлөөр олгосон нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн тоо

Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийх сонирхол бүхий этгээдэд ОБЕГ-ын дэргэдэх Гамшиг судлалын үндэсний хүрээлэн “Гамшгийн эрсдэлийн үнэлгээний мэргэшүүлэх сургалт”-ыг зохион байгуулдаг. Тус хүрээлэнгээс 2019, 2020, 2022 онуудад 3 удаагийн сургалт зохион байгуулсан. Сургалтад нийт 115 хүн хамрагдаж, танхимын сургалт 80 цаг, дадлага ажил 30 цаг нийт 110 цагийн хичээлийг батлагдсан хөтөлбөрийн дагуу судалсан.



115 хүн



110 цаг

Ийнхүү гамшгийн эрсдэлийн үнэлгээний хууль эрх зүйн орчныг шинэчлэн бүрдүүлж, үйл ажиллагааг хэрэгжүүлснээр Монгол Улс гамшгийн эрсдэлийн

үнэлгээ, нотолгоонд суурилсан төлөвлөлт хийх, холбогдох шийдвэр гаргах боломжийг бий болгосон ахиц дэвшилтэй байна.

Хэдийгээр гамшгийн эрсдэлийн үнэлгээний эрх зүй, бодлогын орчин бий болж байгаа боловч гамшгийн эрсдэлийг иргэд олон нийтэд ойлгуулах, шинэ технологи, арга аргачлал нэвтрүүлэх, ашиглах, үнэлгээний үр дүнд шинжилгээ хийх, шийдвэр гаргагч, бодлого боловсруулагчдад хүргэх, түгээх, аюулын зураглалыг боловсруулж олон нийтэд хүртээмжтэй хялбар аргаар хүргэх, үнэлгээний дараах хяналт мониторинг хийх үйл ажиллагаа хүндрэлтэй хэвээр байна.

Олон нийтэд суурилсан гамшгийн эрсдэлийн үнэлгээ, хүүхэд төвтэй гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх, үнэлгээ хийхэд нутгийн уугуул иргэд, ахмад настан, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог нэмэгдүүлэх замаар гамшгийн эрсдэлийн тухай ойлголт, мэдлэгийг олгох үйл ажиллагааг тасралтгүй өргөжүүлэх шаардлагатай.

2.1.2. Гамшгийн мэдээллийн сангийн хөгжүүлэлт

Гамшгийн мэдээллийн сангийн хувьд гамшгийн мэдээллийг 2010 онд 6 хэсэгт хамаарах 21 үзүүлэлтээр гаргаж байсан бол 2020 онд ойролцоогоор (аюулын төрлөөс хамаарч бага зэрэг ялгаатай байна) 16 хэсэгт хамаарах 300 үзүүлэлтээр гаргах болсон.

Мэдээллийн санд бүртгэх хэсгийн агуулга 62%, эдгээр хэсэгт хамаарах үзүүлэлтүүд 14 дахин нэмэгдсэн байна.

Хүснэгт 2 Гамшгийн мэдээ бүртгэх загварын хэсгүүдийн агуулгын харьцуулалт⁵

2010 он	2015 он	2020 он
1. Байршил	1. Байршил	1. Аюулын төрөл
2. Хугацаа	2. Хугацаа	2. Голомтын байршил
3. Хор уршгийн мэдээлэл	3. Өртсөн хүн	3. Мэдээлэл өгсөн хүний мэдээлэл
4. Учирсан хохирол	4. Өртсөн мал, амьтан	4. Мэдээлэл ирүүлсэн эх сурвалж
5. Хор уршгийг арилгахад ажилласан хүч хэрэгсэл	5. Өртсөн эд зүйлс	5. Мэдээллийг хүлээн авсан суваг
6. Зарцуулсан зардал ⁶	6. Аварсан хүн, эд зүйл	6. Мэдээллийн товч утга
	7. Ажилласан хүн	7. Хугацаа
	8. Ажилласан техник	8. Нөхцөл байдал
	9. Учирсан хохирол	9. Аюулын шалтгаан
	10. Зарцуулсан зардлын мэдээлэл	10. Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, ашигласан техник, багаж хэрэгсэл
	11. Хандив тусламж ⁷	11. Үүссэн нөхцөл байдлыг гамшгийн орон зайн мэдээллийн системд оруулсан байдал
		12. Нэрвэгдсэн хүн амын үндсэн үзүүлэлт
		13. Аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд ажилласан хүч хэрэгсэл, зарцуулсан зардал
		14. Учирсан бодит хохирол
		15. Хэрэгцээний тойм
		16. Гамшиг болсон эсэх ⁸
6 хэсэг	11 хэсэг	16 хэсэг

Хүснэгт 3 Гамшгийн мэдээ бүртгэх загвар дахь үзүүлэлтийн тооны харьцуулалт

⁵ Гамшгаас хамгаалах төрийн бодлого, хөтөлбөрт хийсэн шинжилгээ, Гамшиг судлалын үндэсний хүрээлэн, 2020, х44.

⁶ Гамшиг судлалын хүрээлэн (2010) Аюул, ослын мэдээ гаргах арга зүйн судалгаа”

⁷ ADPC, UNISDR (2015) санхүүжилттэй “Монгол Улсын Гамшгийн хохирлын мэдээллийн санг бүрдүүлэх, дүн шинжилгээ хийх чадавхыг сайжруулах төсөл”-ийн тайлан

⁸ Монгол Улсын Шадар Сайдын 2020 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн “Маягт, заавар батлах тухай” 22 дугаар тушаал

	Газар хөдлөлт	Биологийн гаралтай аюулт үзэгдэл	Ус цаг уурын гаралтай аюулт үзэгдэл	Гал түймэр	Хүний үйл ажиллагаатай холбоотой осол	Дундаж
2011*	15	19	20-25	45	14-21	21
2015 **	58	29	34-46	46	25-37	43
2020 ***	288	290	312	305	307	300
Өсөлт 2011 ба 2020 он						14,3 дахин

Тайлбар: * Гамшиг судлалын хүрээлэн (2010) Аюул, ослын мэдээ гаргах арга зүйн судалгаа” сэдэвт судалгааны ажлын тайлан. Онцгой байдлын байгууллагад мөрдөж байсан Маягт ГМ-1 ээс ГМ-19 маягтын мэдээлэл

** Гамшиг судлалын хүрээлэнгээс НҮБ-ын DesInventar вэб хуудсанд оруулсан мэдээллийн үзүүлэлт.

*** Монгол Улсын Шадар Сайдын 2020 оны 22 дугаар тушаалаар батлагдсан “Маягт, заавар батлах тухай”

Гамшгаас учирсан хохирлыг шуурхай, бодитой тооцож, нэрвэгдсэн хүн амын хэрэгцээ, нөөцийн бэлэн байдал, гамшгийн үеийн яаралтай тусламж болон хүмүүнлэгийн тусламжийн зохицуулалт, хойшлуулшгүй сэргээн босголт болон хөгжлийн төлөвлөлтийг тодорхойлох, гамшгийн хохирлын статистик мэдээ гаргахад гамшгийн тохиолдол бүрт хохирлын үнэлгээ хийх үйл ажиллагаа их чухал юм. “Гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээ хийх журам”-ыг Засгийн газрын 2019 оны 01 дүгээр тогтоолоор шинээр батлуулсан. Хохирол, хэрэгцээний үнэлгээг 3 үе шаттай, тодорхой хугацаанд, хэн хийх талаарх асуудлыг нарийн тусгаж өгсөн. Үүнд:

- i) Шуурхай үнэлгээг 48 цагийн дотор,
- ii) Гамшгийн хор уршгийг арилгах үед хийгдэх нөхцөл байдлын үнэлгээг 30 хоногийн дотор,
- iii) Хойшлуулшгүй сэргээн босгох үеийн үнэлгээг 2-12 сарын хугацаанд хийж гүйцэтгэнэ. Гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээний маягт, заавар шинээр боловсруулах хэрэгцээ шаардлага үүссэн.

Иймд ОБЕГ, Үндэсний статистикийн хорооны хамтарсан ажлын хэсэг гамшиг, аюулт үзэгдэл, ослын бүртгэлийн маягт, зааврыг ашиглаж байсан гамшгийн мэдээллийн маягт, Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичигтэй уялдуулан шинэчлэн боловсруулж, Шадар сайдын 2020 оны 22 дугаар тушаалаар батлуулсан. Эдгээр маягт зааварт геологийн гаралтай, биологийн гаралтай, ус, цаг агаарын гаралтай аюулт үзэгдэл, гал түймэр, хүний үйл ажиллагаатай холбоотой осол гэсэн гамшгийн 5 ангилал тус бүрийг бүртгэх маягт, гамшгийн улмаас учирсан бодит хохирол, хэрэгцээний тойм, гамшиг болсон эсэхийг тодорхойлох маягт, заавар багтсан юм.

Гамшгийн хохирлын ангилсан мэдээллийн хувьд үзүүлэлт нэмэгдсэн хэдий ч гамшигт амь насаа алдсан, нэрвэгдсэн иргэдийг хөгжлийн бэрхшээл, орлогын байдлаар нь ангилсан мэдээлэл цуглуулж амжихгүй хэвээр байна.

“Гамшгийн зэрэглэл тогтоох журам”, “Гамшгийг тодорхойлох шалгуур үзүүлэлт” Засгийн газрын 2018 оны 327 дугаар тогтоолоор батлагдсан. Журмын 3.2.-т зааснаар гамшгийг тодорхойлох шалгуур үзүүлэлтийг ашиглан гаргасан мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн тухайн шатны онцгой комисс гамшгийн зэрэглэлийг тогтооно. 2022 оны байдлаар тус баримт бичгийн дагуу аюулт үзэгдэл, ослын улмаас үүссэн гамшгийг тодорхойлох, гамшгийн зэрэглэлийг албан ёсоор тогтоож эхлээгүй байна. Иймд бүртгэгдсэн аюулт үзэгдэл, ослын тохиолдол бүрийг

Монгол Улсад тохиолдсон гамшиг гэж үзэх үндэслэлгүй юм. Зарим тохиолдол гамшгийг тодорхойлох шалгуур үзүүлэлтэд хүрсэн, зарим нь хүрээгүй. НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах газрын цахим хуудаст байршуулсан Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийн явцын хяналтын тайланг өгөгдсөн аргачлалын дагуу боловсруулахдаа бид Монгол Улсад тохиолдсон нийт аюулт үзэгдэл, ослын бүртгэлд суурилсан. Нэг үгээр хэлэхэд гамшгийн зэрэглэлд хүрсэн, хүрээгүй бүх аюулт үзэгдэл, ослын мэдээллийг оруулсан. Цаашид тухайн тохиолдлыг албан ёсоор “гамшиг эсвэл гамшиг биш аюулт үзэгдэл, осол” гэж ялган тодорхойлох шаардлагатай.

Гамшгийн мэдээллийн сан, гамшгийн орон зайн мэдээллийн систем, гамшгийн эрсдэлийн үнэлгээний үр дүнг олон нийтэд нээлттэй хүргэх зорилгоор гамшгийн эрсдэлийн мэдээллийн сан (www.risk.nema.gov.mn)-ийн хөгжүүлэлтийг хийж байна.

Гамшгийн мэдээллийн сан, эрсдэлийн сангийн бүрдүүлэлт буюу мэдээллийг цуглуулах загвараа олон улсын жишигт нийцүүлж, улсын хэмжээнд нэгдсэн стандартад оруулж чадсан боловч тус загварын дагуу статистик мэдээллийг цуглуулах, боловсруулах, шинжлэхэд хүний нөөц дутмаг, олон нийтэд хүргэх арга зам хязгаарлагдмал, энэ чиглэлээр хүний нөөцийг сургах, техник хангамжийг нэмэгдүүлэх, системийн хөгжүүлэлт хийхэд хөрөнгө оруулалт дутагдалтай байна.

2.1.3 Гамшгийн эрсдэлийг бууруулах мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх хүрээнд гарсан ахиц дэвшил

Олон нийтийн гамшгийн эрсдэлийг бууруулах мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд Засгийн газрын 2015 оны 303 дугаар тогтоолоор батлагдсан **“Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр”** ихээхэн үүрэг гүйцэтгэж байна. Тус үндэсний хөтөлбөрийг *“гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, сургалт, сурталчилгаа, үйл ажиллагаанд иргэдийг оролцуулан, тэдний мэдлэг, чадварыг дээшлүүлэх, аюулгүй амьдрах ухамсарт соёл болон болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхыг бэхжүүлэх замаар гамшгийн эрсдэлийг бууруулах”* зорилгын дор 2015-2025 оны хугацаанд 2 үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Энэхүү үндэсний хөтөлбөрийн I үе шатны хэрэгжилт 2020 онд 91.2 хувьтай дүгнэгдсэн байна.

Гамшгаас хамгаалах сургалт

Монгол Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах сургалтыг дараах ангиллаар зохион байгуулж байна. Үүнд:

- удирдах албан тушаалтны,
- онцгой байдлын байгууллагын,
- оюутан, сурагч, сургуульд элсэхийн өмнөх насны хүүхдийн,
- төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн албан тушаалтан, ажилтны,
- гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн
- иргэний.

Олон нийтэд чиглэсэн сургалт зохион байгуулсан тоо 2015 онтой харьцуулахад 2021 онд **30** хувь нэмэгдсэн байна. Сургалтад хамрагдсан хүний тоо нэмэгдсэн ч сүүлийн 2 жилд харьцангуй буурсан үзүүлэлттэй байгаа нь КОВИД-19 цар тахлын үед гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжиж, нийтийг хамруулсан арга хэмжээг хязгаарласантай холбоотой байна. 2015-2022 онд зохион байгуулагдсан ангиллын сургалтын төрөл, хамрагдсан хүний тоог **Хавсралт 1**-д үзүүлэв.

Гамшгаас хамгаалах иж бүрэн болон команд штабын сургууль, дадлага зохион байгуулах зааврыг ОБЕГ-ын даргын 2017 оны А/323 дугаар тушаалаар батлуулан эдгээр сургалтыг жилд ОБЕГ-аас удирдан 2-3 аймагт, аймаг, нийслэлийн Онцгой байдлын газраас удирдан 2-3 сум, дүүрэгт зохион байгуулж хэвшсэн. Гамшгийн үед иргэдийг нүүлгэн шилжүүлэх дадлага сургууль эдгээр сургууль дадлагын хөтөлбөрт ордог.

Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуульд аймаг, нийслэл, сум, дүүргийн онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсэг, хүмүүнлэгийн байгууллага, хуулийн этгээд, иргэд олон нийт буюу онцгой байдлын байгууллага, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн албан тушаалтан, ажилтан, иргэд оролцдог. 2017-2022 онд улс, орон нутгийн хэмжээнд нийт 187 удаа зохион байгуулагдаж, 755,000 орчим хүн хамрагдсан байна.

Команд штабын сургууль буюу удирдах ажилтны сургалтад аймаг, нийслэл, сум, дүүргийн онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсэг, хүмүүнлэгийн байгууллага, хуулийн этгээдийн удирдлагыг хэсэгчлэн хамруулдаг. Онцгой байдлын байгууллагын команд штабын сургуулийг 2015-2022 онуудад 459 удаа зохион байгуулж, нийт 81220 төв, орон нутгийн засаг захиргааны байгууллагын удирдах бүрэлдэхүүн, иргэд олон нийт хамрагдсан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг 2016 онд Монгол Улсын Их хурлаас батлан хэрэгжүүлж байна. Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр бүх нийтийн мэдлэг ойлголтыг хэнийг ч орхигдуулалгүйгээр тэгш, хүртээмжтэй байдлаар хүргэх зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй иргэд, олон нийтийг оролцуулсан сургалт, сурталчилгаа, дадлага сургуулийг жил бүр тогтмол зохион байгуулж байна. Харааны болон хөдөлгөөний хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг гамшгийн үед хэрхэн аврах дасгал сургуулийг нийслэл хотод жил бүр зохион байгуулдаг.

Түүнчлэн хүүхэд багачууд, сурагч, оюутан залуусын гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, тэдний мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор Онцгой байдлын ерөнхий газар, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн “Монгол Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх” төслийн хүрээнд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт хэрэгжүүлэх “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийг боловсруулж, БСШУС-ын сайдын 2018 оны А/181 дүгээр тушаалаар батлуулсан. “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийг 2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн ЕБС, цэцэрлэгийн хичээлийн хөтөлбөрт оруулан хэрэгжүүлж байна.

Их дээд сургууль, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн оюутнуудад Боловсролын сайдын тушаалаар Гамшгаас хамгаалах менежментийн 1 кредит цагийн хичээлийг заавал судлах сургалтын хөтөлбөрт оруулсан нь гамшгийн эрсдэлийг бууруулах мэдлэг ойлголтыг олгох, цаашлаад салбарын бодлого, хөтөлбөр, гамшгийн үед бизнесийн байгууллагын тасралтгүй үйл ажиллагааг хангах суурь ойлголтыг нэмэгдүүлнэ гэж үзэж байна.

Гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төв

Иргэдийн гамшгийг даван туулах чадавхыг бий болгох хүрээнд нийслэл Улаанбаатар хотод “Гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төв”-ийг нийслэлийн 4,5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар барьж 2016 оны 6 дугаар сарын 20-ны өдөр үүд хаалгаа нээсэн.

Тус төв нь Гамшгаас хамгаалах анхан шатны мэдлэг дадлагыг иргэд, олон нийтэд олгох, олон нийтийн оролцоотой гамшгийн эрсдэлийг бууруулахад дэмжлэг үзүүлэх зорилготой.

150 хүний суудалтай 3D дүрс, хурлын танхим, объектын гал түймрийн үед утаат орчноос өөрийгөө болон бусдыг аврах сургалт, дадлагын танхим, өндрөөс аврах ажиллагааны танхим, газар хөдлөлтийн 4-12 баллын чичирхийллийг мэдрүүлэх танхим, гал унтраах сургалтын танхим, анхны тусламжийн танхим, бага насны хүүхдийн танхим зэрэг 6 танхимтай. Танхимын зургийг *Хавсралт 2-т* үзүүлэв.

2016-2022 оны байдлаар нийт 101,200 гаруй иргэд, олон нийт, төрийн албан хаагч, ажилтан, оюутан залууст мэдлэг дадлага олгосон байна.

Гамшгаас хамгаалах тэмдэглэлт өдрүүд

Иргэд, олон нийтийн гамшгийн эрсдэлийг бууруулах мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх хүрээнд дараах өдрийг жил бүр тэмдэглэн өнгөрүүлдэг уламжлал бий болгосон. Үүнд:

- Олон улсын иргэний хамгаалалтын өдөр жил бүрийн 3 дугаар сарын 01. Энэ өдөр Онцгой байдлын байгууллагаас гамшгийн тухай мэдээлэл, түүнээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр мэдээ, мэдээлэл, ялангуяа гамшгийн үед хэрхэн амь насаа хамгаалах, өөрийн чадавхаа хэрхэн бэхжүүлэх тухай мэдээллийг хүргэж ажилладаг.

- Гамшгаас хамгаалах эрт зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага, сургуулийг гамшиг тохиолдсон нөхцөлд бэлэн байх дадалд иргэд олон нийтийг сургах зорилгоор зохион байгуулж, орон даяар 2012 оноос эхлэн жил бүрийн 3 дугаар сарын 4 дэх долоо хоногийн Пүрэв гарагийн 16:00 цагаас газар хөдлөлтийн зарлан мэдээллийн дохио дуугарна. Дохио дуугарахад иргэд олон нийт “Суу, нуугд, хүлээ”, “Гүйхгүй, эргэж буцахгүй, түлхэхгүй” дүрмийг биелүүлж, иргэд олон нийт өөрийн байрлалын ойролцоох “Цугларах цэг”-т цугларах дадлага сургуульд биечлэн оролцдог. Тус өдрийн өмнөх өдөр буюу жил бүрийн 3 дугаар сарын 4 дэх долоо хоногийн Лхагва гарагийг “Газар хөдлөлтийн гамшгийн аюулыг таниулах өдөр” болгон 2017 оноос хойш тэмдэглэж байгаа нь улсын хэмжээнд олон бүх

байгууллага, иргэд иргэд олон нийтэд газар хөдлөлтийн аюул, эрсдэлийн тухай ойлголт мэдлэг, дадлага олгох ажлыг илүү үр дүнтэй болгож, дадлага сургуульд оролцогчийн идэвх нэмэгдүүлж байна.

- Гамшгийн эрсдэлийг бууруулах олон улсын өдрийг жил бүрийн 10 дугаар сарын 13. Олон улсад дэвшүүлсэн сэдэв, уриан дор иргэд олон нийтэд чиглэсэн сургалт, сурталчилгааны ажил, эрдэм шинжилгээний хурлыг энэ өдрийг тохиолдуулан орон даяар зохион байгуулж хэвшсэн.

Эрдэм шинжилгээ, судалгаа

Онцгой байдлын байгууллагын дэргэдэх Гамшиг судлалын үндэсний хүрээлэн шинжлэх ухаанд суурилсан гамшгийн эрсдэлийг бууруулах чиг хандлагыг бэхжүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулан ажиллаж байна. Тус хүрээлэнгийн үйл ажиллагааны цар хүрээг өргөжүүлэн Засгийн газрын 2022 оны 65 дугаар тогтоолоор **“Гамшиг судлалын үндэсний хүрээлэн”** болгосон.

2015-2022 онд 53 суурь болон хавсарга судалгаа хийж гамшгаас хамгаалах үйл ажиллагааг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлсэн байна (Зураг 11). Тайлан, судалгааны бүтээлүүд нь энэхүү дунд хугацааны стратегийн хэрэгжилтийн тайланг боловсруулахад гол эх сурвалжууд болсон юм.




Зураг 11 Эрдэм шинжилгээ судалгааны ажлын тоо, 2005-2022 он

Мөн аж ахуйн нэгж, байгууллага, иргэний галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн 1316 хүсэлтийн дагуу 2190 барилгын болон бусад материалд туршилт шинжилгээ хийж, галын лабораторийн сорилтын 2190 дүгнэлт гаргасан (Зураг 12).



Зураг 12 Лабораторид туршсан сорилтын тоо, 2005-2022 он



Тус хүрээлэнгээс 2019 оноос эхлэн “Гамшиг судлал, инновац” сэтгүүлийг шинээр эрхлэн гаргаж эхэлсэн нь гамшиг судлалын бүтээлүүдийг олон нийтэд хүргэх хүртээмж нэмэгдсэн гэж үзэж байна. Нийт 9 дугаар хэвлэгдэн гаргаад байна.

Гамшгаас хамгаалах судалгаа, шинжилгээний олон арга хэмжээг санаачилан зохион байгуулдаг. 2015 оноос хойш нийт 16 удаагийн онол, практикийн бага хурал, эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулсан байна.

Нэмэлт дэлгэрэнгүй мэдээллийг дараах цахим хуудаст нэвтэрч <https://www.nidr.nema.gov.mn> хүлээн авна уу.

Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургууль, Гамшиг судлалын төв, Удирдлагын академийн үйл ажиллагаа нь аюулгүй байдал, гамшигтай тэмцэх салбарт тулгамдсан асуудлыг шийдвэрлэх чиглэлээр эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажил гүйцэтгэх, үр дүнг салбарын үйл ажиллагаанд нэвтрүүлэх арга хэмжээг зохион байгуулахад чиглэгдэнэ. Эдгээр сургуулиуд нь Дипломын дараах магистр, докторын судалгааны ажил, эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл зэрэг эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлийн үр дүн, ололтоор гамшигийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийг хэрэгжилтийг хангахад тодорхой хувь нэмэр оруулж байна.

2.1.4. Цаашид

Нэн тэргүүнд анхаарах асуудал

- Иргэд, олон нийтийг гамшигийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ, гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгааны ажилд оролцуулах, гамшгаас хамгаалах уламжлал мэдлэг ойлголтыг түгээх замаар гамшигийн эрсдэлийг бууруулах мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, гамшигийн эрсдэлийг бууруулахад хэнийг ч орхигдуулахгүй хамруулах.
- Иргэд олон нийтийн гамшигийн бэлэн байдлын чиглэлээр судалгааны ажлыг өргөтгөх.
- Эрсдэлийн мэдээлэлд суурилсан шийдвэр гаргах, төлөвлөх, санхүүжүүлэх, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгаас учирч болзошгүй хохирлыг бууруулахад гамшигийн эрсдэлийн үнэлгээний үр дүнг чиглүүлэх,
- Гамшигийн ангилсан дата мэдээлэл боловсруулах, түүний ач холбогдлын талаар оролцогч талуудын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх,
- Гамшигийн мэдээллийг боловсруулахад дэвшилтэт технологи нэвтрүүлэх, мэдээллийг иргэд олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй хүргэх.
- Гамшигийн эрсдэлийн мэдээллийн санг хөгжүүлэх, гамшигийн төрөл бүрээр хийгдэж буй үндэсний хэмжээний аюулын зураглалыг дуусгах.

2.2. Гамшгийн эрсдэлийг бууруулах засаглал, удирдлага, зохион байгуулалтад гарсан ахиц дэвшил

2.2.1. Бодлогын орчин

Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний стратеги, хөтөлбөр

Монгол Улсад өнөөдөр гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр дараах бодлогын баримт бичгийг хэгэжүүлж байна.

“Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр (2015-2025)”: Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөрийн төслийг боловсруулж байх үед НҮБ-аас Япон Улсын Сендай хотноо зохион байгуулсан Гамшгийн эрсдэлийг бууруулах дэлхийн III бага хурлаас Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт батлагдсан юм. Тиймээс үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх Арга хэмжээний төлөвлөгөөг Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийн агуулгатай нийцүүлэхийг хичээсэн болно. Тус үндэсний хөтөлбөр нь хүн-төвтэй, хүүхдэд ээлтэй, жендэрийн мэдрэмжтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гамшгийн эрсдэлийг бууруулах асуудлыг багтаасан гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэхийг зорьсон. Тус хөтөлбөрийн зорилго, үе шатыг энэхүү тайлангийн 2.1.3 дахь хэсгээс дэлгэрүүлэн үзнэ үү.

“Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги 2017-2030”: Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийг өөрийн улсын онцлог, чадавх, нөөц бололцоонд тулгуурлан хэрэгжүүлэхээр гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний стратегийг боловсруулж, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 355 дугаар тогтоолоор “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги” нэртэйгээр батлуулсан. Энэхүү дунд хугацааны стратегийг 1 зорилго, 9 зорилт, үйл ажиллагааны 4 тэргүүлэх чиглэлийн хүрээнд 2017-2020, 2021-2025, 2026-2030 он хүртэл 3 үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Дунд хугацааны стратегийн хураангуйг **Хавсралт 3-т** үзүүлэв.

Хүснэгт 4 Тэргүүлэх чиглэлийг харьцуулсан байдал

Тэргүүлэх чиглэл	Гамшгийн эрсдэлийг бууруулах Дэлхийн III бага хурал: Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичиг	Монгол Улс: Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги
Тэргүүлэх чиглэл 1	Гамшгийн эрсдэлийг ойлгох	Гамшгийн эрсдэлийг бууруулах бүх нийтийн ойлголтыг гүнзгийрүүлэх, мэдлэг олгох
Тэргүүлэх чиглэл 2	Гамшгийн эрсдэлийг удирдах засаглалыг бэхжүүлэх	Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны удирдлагын засаглалыг бэхжүүлэх
Тэргүүлэх чиглэл 3	Гамшигтай тэмцэх чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд хөрөнгө оруулах	Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх
Тэргүүлэх чиглэл 4	Гамшгийн хор уршгийг арилгах үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд бэлэн байдлыг хангах, гамшгийн дараах сэргээн босгох, нөхөн сэргээх үе шатанд “Сайжруулан барих” үйл ажиллагааг хэрэгжүүлэх	Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах, гамшгийн дараах сэргээн босгох, нөхөн сэргээх, шинээр барьж байгуулах үйл ажиллагааг урт хугацаанд төлөвлөн хэрэгжүүлэх

Тус стратегийн эхний үе шат (2017-2020)-ыг төрийн захиргааны болон орон нутгийн байгууллага, шинжлэх ухаан, иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшил, иргэд, олон нийт, олон улсын байгууллагуудын түншлэл, хамтын ажиллагаанд суурилж хэрэгжүүлэхээр Шадар сайдын 2018 оны 23 дугаар тушаалаар нийт 38 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилт **94.2** хувьтай дүгнэгдсэн байна. Үүнд:

Хүснэгт 5 Төлөвлөгөөний хэрэгжилт (Тэргүүлэх чиглэл тус бүрээр)

Тэргүүлэх чиглэл	Хэрэгжилт /хувиар/
Тэргүүлэх чиглэл 1: Гамшгийн эрсдэлийг бууруулах бүх нийтийн ойлголтыг гүнзгийрүүлэх, мэдлэг олгох	100%
Тэргүүлэх чиглэл 2: Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны удирдлагын засаглалыг бэхжүүлэх	100%
Тэргүүлэх чиглэл 3: Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх	83%
Тэргүүлэх чиглэл 4: Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах, гамшгийн дараах сэргээн босгох, нөхөн сэргээх, шинээр барьж байгуулах үйл ажиллагааг урт хугацаанд төлөвлөн хэрэгжүүлэх	93%
Нийт	94.2%

Дээрх арга хэмжээний төлөвлөгөөнд хангалтгүй дүгнэгдсэн арга хэмжээнээс “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги”-ийг хэрэгжүүлэх II үе шат /2021-2025 он/-ны

арга хэмжээний төлөвлөгөөнд тусгаж, Шадар сайдын 2021 оны 51 дүгээр тушаалаар батлуулсан. Тус төлөвлөгөөнд тусгагдсан 56 арга хэмжээг хэрэгжүүлж байна. II үе шатны арга хэмжээ нь стратегийн хэрэгжилтийн гол хэсэг байх бөгөөд I үе шатны арга хэмжээнээс 33 хувиар илүү арга хэмжээг төлөвлөсөн. III үе шатанд стратегийг хэрэгжүүлэхэд олсон ололт амжилтаа бататгах, дараагийн урт хугацаанд хэрэгжүүлэх стратегийн агуулгыг боловсруулахад чиглэгдэнэ гэж үзэж байна.

Хүснэгт 6 Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийн I, II үе шатны арга хэмжээний тоо

Тэргүүлэх чиглэл	Зорилт	I үе шатны арга хэмжээний тоо	II үе шатны арга хэмжээний тоо
Тэргүүлэх чиглэл 1	Зорилт 1	6	9
	Зорилт 2	5	7
Тэргүүлэх чиглэл 2	Зорилт 1	4	3
	Зорилт 2	4	3
	Зорилт 3	3	2
Тэргүүлэх чиглэл 3	Зорилт 1	4	6
	Зорилт 2	3	3
Тэргүүлэх чиглэл 4	Зорилт 1	6	18
	Зорилт 2	3	5
Нийт		38	56

Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичиг батлагдахаас өмнө Монгол Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах чиглэлийн нэг томоохон баримт бичиг байсан нь Улсын Их хурлын 2011 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан “Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого” юм. Энэхүү баримт бичиг нь 2011-2020 он хүртэл 10 жилийн хугацаанд хэрэгжиж 97.3 хувьтай хэрэгжсэн байна.

Гамшгийн эрсдэлийг бууруулах Монгол Улсын бодлогын баримт бичиг нь тогтвортой хөгжлийн үзэл хөтөлбөр, улс орны хөгжлийн баримт бичигтэй уялдсан болохыг судалгааны дүнгээс харж болно (Хүснэгт 7). Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги нь Тогтвортой хөгжлийн 17 зорилгын 8 зорилготой хүчтэй, 5 зорилготой сул, 4 зорилготой уялдаагүй байна⁹ (Хүснэгт 7). Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Алсын хараа-2050, Засгийн газрын мөрийн хөтөлбөр (2020-2024)-тэй 4-6 зорилтын хүрээнд уялдсан байна¹⁰.

⁹ ГСХ, Гамшгаас хамгаалах бодлого, стратеги, 2020

¹⁰ Б.Баянмөнх, Гамшгаас хамгаалах бодлогын өнөөгийн байдал, 2020

Хүснэгт 7 Бодлогын баримт бичгүүдийн уялдаа

№	Бодлого, хөтөлбөр	Бодлогын баримт бичиг хөгжлийн бодлоготой уялдаж буй байдал			Бодлого, хөтөлбөрийн хоорондын уялдаа, холбоо
		Үндэсний аюулгүй байдлын үзэл, баримтлал	Алсын хараа 2050	Засгийн газрын мөрийн хөтөлбөр 2020-2024	
1	Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах хөтөлбөр /5 зорилт/	4 зорилт	4 зорилт	3 зорилт	2-т заасан хөтөлбөртэй 4 зорилт 3-т заасан стратегитай 5 зорилт
2	Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр /6 зорилт/	3 зорилт	4 зорилт	2 зорилт	1-т заасан бодлоготой 4 зорилт 3-т заасан стратегитай 5 зорилт
3	Сендайн үйл ажиллагааг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги /9 зорилт/	6 зорилт	5 зорилт	4 зорилт	1-т заасан бодлоготой 8 зорилт 2-т заасан хөтөлбөртэй 7 зорилт

Хүснэгт 8 Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний стратеги, Тогтвортой хөгжлийн зорилгын уялдаа

Уялдсан байдал	Тогтвортой хөгжлийн зорилго 2030
Хүчтэй	1, 3,4,9,11,13,15,17 (8)
Сул /зарим	2,5,6,10,12 (5)
Огт уялдаагүй	7,8,14,16 (4)

Ийнхүү манай улс дэлхий нийтийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэн үндэсний гамшгийг даван туулах чадвараа бэхжүүлж, гамшгийн эрсдэлийг бууруулснаар Тогтвортой хөгжлийн зорилтуудад хүрэх амлалтаа хэрэгжүүлэх боломжтой болоод байна.

Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийн дунд хугацааны хэрэгжилтийн тайланг боловсруулах хүрээнд зохион байгуулсан үндэсний хэмжээний хэлэлцүүлэг уулзалтаар оролцогчид гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны хууль эрх зүй, бодлогын орчин 2015 онтой харьцуулахад боловсронгуй болж, салбар дундын, байгууллага хоорондын зохицуулалт, хамтын ажиллагаа сайжирч, олон нийтийн оролцоо нэмэгдэж, эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг уялдуулан боловсруулах заавар зэргийг боловсруулан батлуулсан зэрэг нь үндэсний болон орон нутгийн түвшинд эрсдэлийн мэдээлэлд суурилсан гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг

авч хэрэгжүүлэхэд ихээхэн үр дүнтэй болсон гэж дүгнэсэн байна. Хэдий тийм ч гэсэн салбарын түвшинд эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд хүний нөөц, хөрөнгө оруулалтын асуудал, салбар хоорондын хамтын ажиллагааны зарим дутмаг байдал нь ихээхэн хүндрэл учруулсан хэвээр байна.

“Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны бодлого, стратеги” судалгаа

ОБЕГ-ын дэргэдэх Гамшиг судлалын хүрээлэн 2020 онд “Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны бодлого, стратеги” суурь судалгаа гүйцэтгэсэн. Тус судалгаа нь гамшгаас хамгаалах бодлогын өнөөгийн байдалд тулгуурлан гамшгаас хамгаалах салбарын цаашдын стратегийг тодорхойлсон.


Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа нь өөр хоорондоо уялдаа холбоо бүхий элементүүдээс бүрддэг цогц үйл ажиллагаа тул гамшгаас хамгаалах богино, дунд, урт хугацааны стратегийн зорилтыг SWOT-АНР шинжилгээний аргаар тодорхойлсон. Хүснэгт 9-д SWOT-АНР шинжилгээнд сонгон авсан шинжилгээ хийх хүчин зүйлсийг үзүүлэв.

Хүснэгт 9 SWOT-АНР шинжилгээнд сонгон авсан шинжилгээ хийх хүчин зүйлс

А.Дотоод хүчин зүйлс		Б.Гадаад хүчин зүйлс	
Давуу тал (S)	Сул тал (W)	Таатай нөхцөл (O)	Таагүй нөхцөл (T)
I. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны эрх зүйн орчин	IV. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа бүх нийтийн үйл хэрэг болж чадсан байдал	I. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны салбар дундын хамтын ажиллагаа	IV. Болзошгүй гамшгийн өсөлт
II. ОББ-ын гамшгаас хамгаалах чадавх	V. Орон нутаг дахь гамшгаас хамгаалах үйл ажиллагааны хүртээмж	II. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны төсөв, санхүүжилтийн хүрэлцээ	V. Газар хөдлөлтийн гамшигт эрсдэлтэй байдал
III. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцогчдын цалин урамшуулал	VI. Үндэсний болон орон нутгийн гамшгаас хамгаалах материал техникийн нөөц	III. Гамшгийн үед үзүүлэх олон улсын тусламж	VI. Иргэд байгууллагын гамшгаас хамгаалах чадавх

Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг шаардлагатай түвшинд хүргэхийн тулд нэн тэргүүнд өөрийн давуу тал, боломжуудаа ашиглаад дараах зүйлийг яаралтай хийж гүйцэтгэх шаардлагатай байгааг судалгаа харуулж байна. Үүнд:

1. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг бүх нийтийн үйл хэрэг болгох,
2. Үндэсний болон орон нутгийн гамшгаас хамгаалах материал техникийн нөөцтэй болох,
3. Иргэд байгууллагын гамшгаас хамгаалах чадавхыг бий болгох.



Зураг 13 Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны стратегийг тодорхойлох график

Судалгааны үр дүнд тодорхойлсон стратегийн зорилт:

2024 он хүртэл хэрэгжүүлэх богино хугацааны стратегийн зорилт:

1. Бүсийн төвүүд болон Орон нутаг дахь гамшгаас хамгаалах чадавхыг нэмэгдүүлэх, бэлтгэл бэлэн байдлыг хангахад чиглэсэн гамшгаас хамгаалах нөөцийг ОБЕГ-ын даргын мэдэлд байгуулах,
2. Урьдчилан сэргийлэх, бэлтгэл бэлэн байдлыг хангах нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх,
3. Гамшгаас хамгаалах чадавхыг үнэлэх шалгуур үзүүлэлт бүхий журам боловсруулж мөрдөх,
4. Дунд болон урт хугацааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг зохион байгуулж таатай нөхцөлийг бүрдүүлэх.

2024-2028 онд хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийн зорилт:

1. Өсөн нэмэгдэж байгаа болзошгүй гамшиг, ялангуяа газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах нэгдсэн төлөвлөлт бүхий арга хэмжээг зохион байгуулах,
2. Салбар дундын хамтын ажиллагааны удирдлагын шинэ тогтолцоог төлөвшүүлэх,
3. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг бүх нийтийн үйлс болгон зохион байгуулах ажлыг эрчимжүүлэхэд чиглэсэн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх,
4. Улс орны нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангаж чадахуйц улсын нөөц түүний дотор гамшгаас хамгаалах нөөц, орон нутгийн гамшгаас хамгаалах чадавхыг дээшлүүлэхэд чиглэсэн орон нутгийн нөөцийг бий болгох,
5. Орон нутаг дахь гамшгаас хамгаалах үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх,
6. Гамшгийн эрсдэлийн удирдлагыг шилмэл загварыг бий болгох,
7. Урт хугацааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэх угтвар нөхцөлийг бүрдүүлэх.

2028-2032 онд хэрэгжих урт хугацааны стратегийн зорилт:

1. Иргэд байгууллагын гамшгаас хамгаалах чадавхыг дээшлүүлэх цогц арга хэмжээ авах, иргэд, байгууллагын гамшгаас хамгаалах чадавхыг үнэлдэг шалгуур үзүүлэлт бүхий журам боловсруулж мөрдөх,
2. Болзошгүй гамшиг болон газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг мэдэгдэхүйц хэмжээнд бууруулах,
3. Гамшигтай тэмцэх үйл ажиллагаанд оролцогчдын нийгмийн асуудлыг бүрэн шийдвэрлэх.
4. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа бүх нийтийн үйл хэрэг болсон байх
5. Монгол Улсын гамшгаас хамгаалах чадавхыг өнөөгийн шалгуураар үнэлэхэд 80-аас доошгүй хувьд хүргэх¹¹.

“Аюулгүй, гамшигт тэсвэртэй хот” санаачилга Монгол Улсад

Монгол Улсын Засгийн газраас хүн ам бөөгнөрөн сууж буй хот суурин газрын гамшгийн эрсдэлийг бууруулахад анхаарч НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах газраас дэлхийн хотуудын гамшигтай тэмцэх чадавхыг бий болгох зорилгоор санаачлан хэрэгжүүлж буй “Аюулгүй, гамшигт тэсвэртэй хот”¹² санаачилгын эхний үе шатанд Монгол Улсын нийслэл Улаанбаатар болон Дархан, Эрдэнэт хотууд 2016 онд, үлдсэн 18 аймгийн төвүүд 2018 онд нэгдэн орсон. 2022 оны 11 дүгээр сард тус санаачилгын дараагийн үе шат болох “Аюулгүй, гамшигт тэсвэртэй хот-2030”-д бүртгэлээ шинэчилж, бүх хотуудаа дахин нэгтгэн орсон. “Аюулгүй, гамшигт тэсвэртэй хот-2030”-д бүртгэл баталгаажуулах арга хэмжээг цахим, танхим хосолсон хэлбэрээр Төрийн ордонд Шадар сайдын Ажлын алба, НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах Зүүн хойд Азийн газар, дэлхийн боловсрол сургалтын хүрээлэнтэй хамтран зохион байгуулсан.

“Аюулгүй, гамшигт тэсвэртэй хот” санаачилгын хүрээнд 2016-2022 онд ОБЕГ, НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах газрын Ази, Номхон далайн бүсийн төв, НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах Зүүн хойд Азийн газар, дэлхийн боловсрол сургалтын хүрээлэнтэй хамтран 16 удаагийн сургалт, семинар зохион байгуулсан. Сургалт семинар Монгол Улсын бүх хотуудыг хамарч зохион байгуулагдсан. Сургалт, семинарт онцгой байдлын байгууллагын болон бусад холбогдох талуудын шийдвэр гаргах, бодлого төлөвлөлт боловсруулах, бусад гүйцэтгэх түвшний алба хаагчдын оролцоог хангаж ажилласан.

Үүний үр дүнд хотуудын гамшгийг тэсвэрлэх чадавхыг үнэлэх онооны аргыг ашиглан бүх хотуудын чадавхыг 2018-2019, 2022 онд нийт 2 удаа үнэлсэн. Үнэлгээний дүнгээс харвал 2022 оны үнэлгээ 2018-2019 онд хийсэн үнэлгээний дүнтэй харьцуулахад улсын хэмжээнд 5.7 хувь өссөн үзүүлэлттэй байна. Гамшгийг тэсвэрлэх чадавх дунджаар 15 аймагт 10.7 хувь өсөж, 6 аймагт 5.3 хувь буурсан үзүүлэлттэй байна. Улаанбаатар хотын хувьд гамшгийг тэсвэрлэх чадавхын түвшин 2018 онд 49.4%-тай үнэлэгдэж байсан бол 2022 онд 52.2%-д хүрч, 2.8 хувь өссөн үзүүлэлттэй байна. **Хавсралт 4**-өөс дэлгэрүүлэн үзнэ үү.

¹¹ Гамшгаас хамгаалах бодлого, стратеги, ГСХ, 2020, хуудас 234-266

¹² UNDRR, Making Cities Resilient 2030, website <https://mcr2030.undrr.org/>

Мөн хотуудын гамшгийн ерөнхий эрсдэлийг эрсдэлийн түргэвчилсэн үнэлгээний арга, индикаторын аргаар 2017-2020 онд тус тус үнэлсэн.

Эдгээр үнэлгээнүүдийн үр дүнд суурилан хотуудын гамшгаас хамгаалах төлөвлөгөө (3 дугаар бүлэг. Гамгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө)-д тодотгол хийгдсэн.

2.2.2. Эрх зүйн орчин

Монгол Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх 3 гол хууль болох

- Гамшгаас хамгаалах тухай хууль (2003, 2017),
- Галын аюулгүй байдлын тухай хууль (1999, 2015),
- Улсын нөөцийн тухай хууль (2007)-ийг мөрдөн ажиллаж байгаагаас

Улсын Их хурлаар Галын аюулгүй байдлын тухай хуулийг 2015 онд, Гамшгаас хамгаалах тухай хуулийг 2017 онд тус тус шинэчлэн найруулж баталсан.

Дээрх хуулиудыг шинэчлэн баталснаар гарсан томоохон өөрчлөлт нь гамшгийн өмнө, үед, дараа авах гамшгаас хамгаалах үйл ажиллагааг тодорхойлсон, төрийн болон хувийн хэвшил, холбогдох талууд, олон нийтийн гамшгаас хамгаалах чиглэлээрх эрх үүрэг, хүлээх хариуцлага тодорхой болгосон, гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх, хүмүүнлэгийн тусламж, эрсдэлийг бууруулах хөрөнгө оруулалтыг зохицуулах эрх зүйн орчин бий болгосон, гамшгаас хамгаалах байгууллагын бүтэц тогтолцоо шинэчлэгдсэн явдал юм.

Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд холбогдох байгууллагын бүрэн эрх, чиг үүрэгт хамаарах эрх зүйн зохицуулалт, заалт нь Галын аюулгүй байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгад 24 хувь, Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгад 37 хувиар тус тус нэмэгдэж¹³, тэдний хүлээх үүрэг, хариуцлагыг илүү нарийвчлан тодорхойлж өгсөн байна (Хүснэгт 10).

¹³ Д.Сэржмядаг, П.Чимэдцэрэн, Гамшгаас хамгаалах бодлогын хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ, судалгааны тайлан, Гамшиг судлалын үндэсний хүрээлэн, 2019.

Хүснэгт 10 Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай хуулиуд дахь оролцогч талуудын зохицуулалтанд хийгдсэн шинэчлэлийн харьцуулалт

№	Оролцогч талын жагсаалт	ГХТХууль, заалтын тоо		ГАБТХууль, заалтын тоо	
		2003	2007	1999	2015
1	Монгол Улсын Их Хурлын бүрэн эрх		2		
2	Монгол Улсын Засгийн газрын бүрэн эрх	2	5		
3	Үндэсний болон орон нутгийн зөвлөлийн бүрэн эрх		5		
4	Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх	7	10		
5	Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг	15	19	19	15
6	Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын бүрэн эрх	14	19		
7	Нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх		3		
8	Засаг даргын бүрэн эрх	13	14	6	8
9	Гамшгаас хамгаалах албаны чиг үүрэг	12	15		
10	ААНБ, хуулийн этгээдийн эрх/үүрэг	0/10	2/9	0/9	3/12
11	Төрийн бус байгууллагын эрх, үүрэг		5		
12	Сайн дурын хэсэг,гэрээт албаны үүрэг		9	9	3/12
13	Иргэний эрх/ үүрэг	0/8	5/7	3/4	8/5
Нийт заалтын тоо		81	129	50	66
Өөрчлөлтийн хувь		37% нэмэгдсэн		24% нэмэгдсэн	

Өмнөх хүснэгтээс харахад гамшгаас хамгаалах харилцааг зохицуулж буй суурь хуулиудад оролцогч талуудын чиг үүрэг нэмэгдсэн төдийгүй тоо нь ч мөн нэмэгджээ. Энэ өөрчлөлт Гамшгаас хамгаалах тухай хуульд илүүтэй явагдсаныг 8 оролцогч талаас хуулийн шинэчлэлээр 13 оролцогч тал болгож нэмэгдсэн нь харуулж байна.

Гамшгаас хамгаалах институцийн тогтолцоонд оруулсан томоохон өөрчлөлт нь Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний болон орон нутгийн зөвлөлийг шинээр байгуулах эрх зүйн орчин бүрдсэн явдал юм. Тус зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагааны талаар энэхүү тайлангийн 2.2.3 дахь хэсгээс дэлгэрүүлэн үзнэ үү.

Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, эх үүсвэрийг тодорхой болгох хүрээнд Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгад гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардалд аймаг, сум, нийслэл, дүүрэг, төрийн байгууллага тухайн жилийн төсвийнхөө 1.0 хувиас доошгүйг зарцуулахаар тооцон төсөвт тусгаж, хуулийн этгээд тухайн жилийн үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг төлөвлөж зарцуулна гэж тусгасан.

Мөн түүнчлэн хоёр хуулийн хүрээнд нийтлэг байгаа томоохон өөрчлөлт нь ААНБ, иргэд дан ганц үүрэг хүлээдэг байсныг эрх, үүрэгтэй болгосон, түүнчлэн төрийн бус байгууллага, сайн дурынхныг оролцоог хангасан зохицуулалтыг бий

болгож, гамшгаас хамгаалах үйл ажиллагаа, гамшгийн эрсдэлийн удирдлагын засаглалыг бүрдүүлж өгчээ.

Эдгээр хуулиудын шинэчлэлийн хүрээнд 2022 оны 12 дугаар сарын байдлаар Засгийн газрын тогтоолоор 20, Шадар сайдын тушаалаар 28, ОБЕГ-ын даргын тушаалаар 57 дүрэм, журам, заавар, удирдамж зэрэг нийт 105 эрх зүйн баримт бичгийг шинэчлэн болон шинээр боловсруулж албажуулан мөрдөж байна.

Гамшгийн эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 2018-2020 онд орон нутгийн хэмжээнд бүх засаг захиргааны нэгжийн Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, Монгол Улс нь Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийн тав дахь зорилт (Target e) болох “үндэсний болон орон нутгийн хэмжээнд гамшгийн эрсдэлийг бууруулах стратеги, төлөвлөгөөтэй болох” гэсэн зорилтод хүрсэн.

2.2.3. Институцийн механизм

Монгол Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх оновчтой институцийн бүтэц, зохион байгуулалтыг бий болгох зорилгоор УИХ-аас 2017 онд баталсан Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгад “Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг нутаг дэвсгэр, үйлдвэрлэлийн зарчмаар засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд өмчийн хэлбэр үл харгалзан зохион байгуулна” гэж зааж гамшгаас хамгаалах удирдлагын тогтолцоог дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

- Улсын Их хурал нь гамшгаас хамгаалах бодлогын үндсийг тодорхойлохоор нэмж оруулж;
- Монгол Улсын Ерөнхий сайдын удирдлагад ажиллах гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн болон салбар дундын хамтын ажиллагаа, иргэдийн оролцоог хангах, бодлогын зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийг шинээр бий болгож;
- Гамшаас хамгаалах үйл ажиллагаанд шаардлагатай хөрөнгө шийдвэрлэх, хяналт тавих үүрэг бүхий нутгийн өөрийн удирдлага байгууллага болох Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийг удирдахаар;
- Монгол Улсын Шадар сайд чиглүүлж, гамшгаас хамгаалах төрийн бодлого, гамшгаас хамгаалах талаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, гамшгаас хамгаалах арга хэмжээг зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах чиг үүрэгтэй онцгой байдлын байгууллага байх;
- Мэргэжлийн дагуу гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй төрийн захиргааны холбогдох яам, агентлагийг түшиглэсэн гамшгаас хамгаалах орон тооны бус Улсын албадтай байх;
- Гамшгийн нөхцөл байдал үүссэн үед аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох ажлыг шуурхай зохион байгуулах чиг үүрэг бүхий Улсын онцгой комисс ажиллах;
- Бүх шатны Засаг дарга,
- Аж ахуйн нэгж, байгууллага,
- Төрийн бус байгууллага, сайн дурын хэсэг болон

- олон нийт, иргэд гэсэн оролцогч талууд хамаарч байна.

Монгол Улс Гамшгаас хамгаалах бодлого, хөтөлбөрөө 2011 онд батлуулж хэрэгжүүлж ирсэн. Уг бодлогын хэрэгжилтийн хүрээнд бий болсон гамшгаас хамгаалах үйл ажиллагааны тогтолцоог *Зураг 14*-т үзүүллээ. Бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд шинээр бий болсон талуудыг улаан хүрээгээр тэмдэглэсэн болно¹⁴. Эндээс тус бодлогын үр нөлөөгөөр гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтын иж бүрэн тогтолцоо бүх түвшинд бүрджээ гэж дүгнэлтэд хүрч байна.

Онцгой байдлын байгууллага

Онцгой байдлын байгууллага нь улс, орон нутгийн хэмжээнд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэхэд төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах, нутгийн захиргааны байгууллага болон хуулийн этгээдийн үйл ажиллагаа, иргэдийн оролцоог уялдуулан зохицуулан ажилладаг¹⁵. Гамшгаас хамгаалах тухай хуулийн дагуу (22.1.) гамшгаас хамгаалах үйл ажиллагааг нутаг дэвсгэр, үйлдвэрлэлийн зарчмаар засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд өмчийн хэлбэр үл харгалзан зохион байгуулж байна.

Монгол Улсын Их Хурлаас 2003 онд “Гамшгаас хамгаалах тухай хууль”-ийг анх баталснаар тус улсад Онцгой байдлын байгууллага байгуулах эрх зүйн орчинг бүрдүүлсэн. Засгийн газрын 2004 оны 8 дугаар тогтоолоор гамшгаас хамгаалах чиг үүрэг бүхий Улсын Иргэний хамгаалалтын газар, Галын аюулаас хамгаалах газар, Улсын нөөцийн газар гэсэн гурван агентлагаас бүрдсэн Гамшгаас хамгаалах ерөнхий газар байгуулагдсан. Засгийн газрын 2005 оны 48 дугаар тогтоолоор Гамшгаас хамгаалах ерөнхий газрыг Онцгой байдлын ерөнхий газар (ОБЕГ) болгон нэрлэсэн билээ.


ОБЕГ-ын харьяанд дараах газар, анги, салбарууд хуулиар хүлээсэн тусгайлсан чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

Бүх аймаг, нийслэлд Онцгой байдлын газар, дүүрэг, зарим сумдад Онцгой байдлын хэлтэстэй. Аймаг, нийслэл, сум дүүрэгт гал унтраах, эрэн хайх аврах анги, салбар, улсын нөөцийн салбар нэгжтэй (*Зураг 14*). Мөн Үндэсний аврах бригад, Уул уурхайн аврах анги, Гамшиг судлалын үндэсний хүрээлэн, Аврагч биеийн тамир, техник спортын хороо, улсын нөөцийн хүнс, өвс тэжээл, шатахууны салбаруудтай. Онцгой байдлын байгууллагын гамшгийн бэлтгэл, бэлэн байдлыг хангах хүрээнд Засгийн газрын тогтоолоор 2015-2022 онд шинээр Эрэлч нохойн алба (2016 онд шинээр), Давтан сургалт, сэргээн заслын төв (2017 онд шинээр), Агаараас эрэн хайх, аврах анги (2020 онд шинээр), Тусгай хувцас, хэрэгслийн туршилт үйлдвэрлэлийн төв (2020 онд шинээр), Ар талын анги.

¹⁴ Сэржмядаг.Д, Чимэдцэрэн.П, Гамшгаас хамгаалах бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээ, Гамшиг судлалын үндэсний хүрээлэн, 2021 он.

¹⁵ Гамшгаас хамгаалах тухай хууль, 2017, 22.4

Зураг 14 Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны тогтолцоо



Улсын онцгой комисс

Улсын онцгой комисс (УОК) нь бүх төрлийн гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үед гамшгаас хамгаалах үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, шийдвэр гаргах, шуурхай зохион байгуулах, хяналт тавих эрх үүрэгтэй. УОК-ыг Шадар сайд тэргүүлнэ. Аймаг, сум, нийслэл, дүүргийн онцгой комиссыг тухайн шатны Засаг дарга тэргүүлэн ажилладаг (Зураг 14).

Улсын онцгой комиссыг Монгол Улсын Шадар сайд тэргүүлэх бөгөөд өдөр тутмын үйл ажиллагааг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага буюу ОБЕГ хэрэгжүүлдэг. УОК нь гамшгийн үед Шуурхай штабыг байгуулан хор уршгийг арилгах арга хэмжээг удирдан ажилладаг.

Коронавируст халдварын цар тахал (КОВИД-19)-тай тэмцэх үед Гамшгаас хамгаалах улсын албад, холбогдох төрийн байгууллага, эрдэм шинжилгээний байгууллагын төлөөллөөс бүрдсэн УОК-ын Шуурхай штаб КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг орон даяар үр дүнтэй зохицуулж, зохион байгуулж ажилласан.

Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөл

Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний болон орон нутгийн зөвлөл нь хөгжлийн бодлого төлөвлөлтөд төр, хувийн хэвшлийн болон салбар дундын хамтын ажиллагаа, иргэдийн оролцоонд тулгуурласан гамшгийн эрсдэлийг бууруулах цогц арга хэмжээг тусгах, бодлогын зөвлөмж, чиглэл гаргах чиг үүрэгтэй, орон тооны бус зөвлөл юм¹⁶ (ГХТХ, 22.5).

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 2017 оны шинэчилсэн найруулгаар улсын хэмжээнд Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөл, аймаг, нийслэл, дүүргийн хэмжээнд Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөл байгуулах эрх зүйн орчин бүрдсэн. Засгийн газрын 2018 оны 63 дугаар тогтоолоор Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөл анх 2018 шинээр байгуулагдаж, Үндэсний зөвлөлийн ажиллах журам батлагдсан. Тус журам 2020 оны 189 дүгээр тогтоолоор шинэчлэгдсэн.



Үндэсний зөвлөлийг Монгол Улсын Ерөнхий сайд тэргүүлдэг. Энэхүү үндэсний зөвлөл нь яам, төрийн байгууллага, иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшил, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн нийт 29 хүний бүрэлдэхүүнтэй. ОБЕГ нь тус зөвлөлийн ажлын албаны үүрэг гүйцэтгэдэг.

¹⁶ ГХТХ, 22.5

Үндэсний зөвлөлийн дор аймаг, нийслэл, дүүргийн 31 орон нутгийн зөвлөл ажиллаж байна. Орон нутгийн зөвлөлийг тухайн шатны Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга тэргүүлдэг.

Гамшгаас хамгаалах улсын алба

Салбар дундын гамшгаас хамгаалах үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах, уялдуулан зохицуулах, мэдээ, мэдээлэл солилцох, хүч хэрэгсэл, нөөцийг оновчтой хуваарилах зорилгоор төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, холбогдох бусад байгууллагыг түшиглэн гамшгаас хамгаалах орон тооны бус Улсын албыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, аймаг, сум, нийслэл, дүүрэгт орон нутгийн албыг тухайн шатны Засаг даргын шийдвэрээр байгуулан ажилладаг (ГХТХ, 22.6).

Үндэсний хэмжээнд Гамшгаас хамгаалах 12 улсын алба, орон нутгийн хэмжээнд Гамшгаас хамгаалах орон нутгийн алба аймаг, нийслэл, сум, дүүрэг бүрт ажиллана.

Хүснэгт 11 Гамшгаас хамгаалах улсын албад

Гамшгаас хамгаалах улсын албад	1	Байгалийн болон химийн аюулыг үнэлж, мэдээлэх алба
	2	Барилга, хот байгуулалтын алба
	3	Зам, тээврийн алба
	4	Уул, уурхай, хүнд үйлдвэрийн алба
	5	Хүн ам, нийгмийн хамгааллын алба
	6	Хүнс, хөдөө аж ахуйн алба
	7	Түлш, эрчим хүчний алба
	8	Эрүүл мэндийн алба
	9	Мэдээлэл, харилцаа холбооны алба
	10	Мэргэжлийн болон цацрагийн хяналтын алба
	11	Хэв журам сахиулах алба
	12	Сурталчилгааны алба

Гамшгаас хамгаалах мэргэжлийн анги, сайн дурын хэсэг

Аймаг, нийслэл, сум, дүүрэг, хуулийн этгээд гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх мэргэжлийн ангитай байх бөгөөд сум, баг, хороонд нутгийн иргэдэд түшиглэн гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийг байгуулж болно гэж Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хуульд заасан.

Мэргэжлийн ангийг зориулалтаар нь ерөнхий зориулалтын болон тусгай зориулалтын, харьяалалаар нь төрийн болон хувийн хэвшлийн гэж ангилна.

Хуулийн шинэчлэлийн хүрээнд гамшгийн эрсдэлийг бууруулахад иргэдийн оролцоог хангах зохицуулалт тоо, чанарын хувьд нэмэгдсэн бөгөөд иргэд сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдэж гамшгаас хамгаалах болон гал унтраах сайн дурын хэсгийг байгуулан ажиллах боломж бүрдсэн юм.

2022 оны 8 сарын байдлаар улсын хэмжээнд нийт 21 аймаг, нийслэлийн 1 дүүрэгт 2189 хүний бүрэлдэхүүнтэй 14 бүлэг, 6 салбар, 556 сайн дурын хэсэг ажиллаж байна.

2.2.4. Цаашид

Нэн тэргүүнд анхаарах асуудал

- Олон улсын болон үндэсний хэмжээнд авсан сургамж, ололт амжилтад тулгуурлан гамшгийн эрсдэлийг бууруулах засаглалыг бэхжүүлэх,
- КОВИД-19 цар тахлын дараах сургамжид үндэслэн гамшгаас хамгаалах эрх зүйн баримт бичигт шинэчлэл хийх,
- Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний болон орон нутгийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг олон улс, бүс нутаг, үндэсний болон орон нутгийн гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд оролцох оролцоог нэмэгдүүлэх,
- Хот суурин газрын гамшгийн эрсдэлийг бууруулах асуудлыг системийн түвшинд авч үзэж, хот төлөвлөлтийн бодлого, үйл ажиллагаанд тусгах.

2.3. Гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгийг тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтад гарсан ахиц дэвшил

2.3.1. Хөрөнгө оруулалт

Монгол Улсад гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардал нь улсын болон орон нутгийн төсөв, Засгийн газрын тусгай болон нөөц сангууд, засгийн газар хоорондын хөнгөлөлтэй зээл, тусламж, Монгол Улсад гамшгийн менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй олон улсын байгууллагын санхүүжилт болон иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хандив, тусламж зэрэг эх үүсвэрээс бүрддэг.

Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хууль эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор Улсын Их хурлаас 2017 онд шинэчлсэн баталсан Гамшгаас хамгаалах тухай хуульд “гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн байгууллага тухайн жилийн төсвийн 1-ээс доошгүй хувийг, хуулийн этгээд тухайн жилийн үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг төсөвлөж зарцуулна” гэсэн заалтыг нэмж тусгасан.

Гамшгаас хамгаалах тухай хууль (2017)-д гамшгаас хамгаалах үйл ажиллагааны санхүүжилтийг гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн үеийн хор уршгийг арилгах, гамшгийн дараах сэргээн босгох үйл ажиллагаанд төсөвлөгдөхөөр тусгаж санхүүжилтэнд дараах өөрчлөлт хийгдсэн.

Гамшгаас хамгаалах тухай хууль, 2003	Гамшгаас хамгаалах тухай хууль, 2017
-	Төсвийн ерөнхийлөн захирагч нь жил бүрийн төсвийн багцдаа гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөж, зардлыг тусгана.
Гамшгийн голомтод аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг зохион байгуулахад гарах зардлыг төрийн болон төрийн өмч давамгайлсан аж ахуйн нэгж, байгууллагын хувьд төр хариуцна. Бусад аж ахуйн нэгж, байгууллагын хувьд гамшигтай холбогдсон зардлаа өөрөө хариуцна.	Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардалд аймаг, нийслэл, сум, дүүрэг, төрийн байгууллага тухайн жилийн төсвийнхөө 1.0 хувиас доошгүйг зарцуулахаар тооцон төсөвт тусгаж, хуулийн этгээд тухайн жилийн үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг төлөвлөж зарцуулна.
Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах төвлөрсөн арга хэмжээний зардлыг улсын төсвөөс, аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны гамшгаас хамгаалах арга хэмжээний зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, аж ахуйн нэгж, байгууллага зардлаа өөрөө хариуцна.	Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах төвлөрсөн арга хэмжээний зардлыг улсын төсвөөс, аймаг, нийслэл, сум, дүүргийн гамшгаас хамгаалах арга хэмжээний зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд зардлаа өөрөө хариуцна.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгаар улсын төсвийн санхүүжилттэй засаг захиргааны нэгж, аж ахуйн нэгж, байгууллага болон хуулийн этгээдийн гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээнд зарцуулах төсвийг тодорхой хувь хэмжээгээр тогтоож өгч, мөн гамшгаас урьдчилан сэргийлэх үйл



ажиллагаанд санхүүжилтийг зарцуулахыг хуульчилснаар гамшгаас хамгаалах үйл ажиллагааны санхүүжилтийн эрх зүйн орчинг сайжруулсан байна.

Энэ хүрээнд Монгол Улсын 21 аймгийн засаг захиргаа нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд зарцуулахаар тусгасан төсвийн хэмжээ 2018 онд 2.3 тэрбум төгрөг байсан бол энэ тоо 2022 онд 10.4 тэрбум төгрөг болж 4 дахин нэмэгдсэн байна¹⁸ (Зураг 15).

Зураг 15 Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны төсвийн хэмжээ

2015-2021 онд зарцуулсан хор уршгийг арилгах зардлын хувьд

- гамшиг, аюулт үзэгдэл, ослын улмаас учирсан хохирлыг арилгах,

¹⁷ Даш.П, Сэржмядаг.Д, Чимэдцэрэн.П., Гамшгаас хамгаалах бодлого, стратеги, нэг сэдэвт бүтээл, Гамшиг судлалын үндэсний хүрээлэн, 2021 он.

¹⁸ Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн тайлан, ОБЕГ, 2022

хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд Монгол Улсын Засгийн газраас төлөвлөж зарцуулсан хөрөнгө 88.4 хувиар нэмэгдсэн байна (КОВИД-19 цар тахлын хариу арга хэмжээнд зарцуулсан зардал багтсан).

- Мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх үйл ажиллагаанд болон малын нөхөн төлбөр 48 хувь буурсан,
- үер, хүчтэй аадар бороо, салхи шуурга зэрэг байгалийн аюулт үзэгдлийн улмаас учирсан хохирлыг арилгах, сэргээн босгох зардал 80.9 хувь буурсан,
- өвөлжилт, хаваржилтын хүндрэлийг даван туулах зудын хохирлыг бууруулах зорилгоор улсын нөөцөөс зарцуулсан өвс, тэжээл бүрдүүлэх зардал 9.2 хувь өссөн,
- Улсын нөөцөөс олгосон автомашин, гэр, дулаан хувцас, бусад бараа материалыг нөхөн бүрдүүлэх зардалд 89 хувь нэмэгдсэн байна¹⁹.

Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг үр дүнтэй авч хэрэгжүүлэхэд шаардлагатай гол хүчин зүйлийн нэг нь хөрөнгө оруулалт тул Монгол Улсын Засгийн газар холбогдох зардлыг улсын хэмжээнд урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтөд уялдуулан тусгах замаар хэрэгжүүлж байна. Тухайлбал, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусган, шаардагдах зардлыг Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр, жил бүрийн улсын төсөв, ирэх 3 жилийн төсвийн хүрээний мэдэгдэлд тусгасан байна.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсад батлагдан мөрдөгдөж буй гамшгийн эрсдэлийг бууруулах санхүүжилтийн стратеги байхгүй бөгөөд бусад улс орны туршлага, сургамжид үндэслэн цаашид гамшгийн эрсдэлийг бууруулах санхүүжилтийн стратеги болон гамшгийн эрсдэлийн даатгалын тухай хуулийг боловсруулж батлуулах, эрх зүйн орчинг бүрдүүлэх зорилт тавин ажиллаж байна. Дээрх стратегийг батлаж, мөрдлөг болгон ажилласнаар манай улс гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд шаардагдах төсвийн эх үүсвэр, эрсдэлийн санхүүжилтийн хуримтлал бий болж цаашлаад эрсдэлийг бууруулах арга хэмжээг амжилттай авч хэрэгжүүлэх үндэс болох юм.

Түүнчлэн гамшгийн эрсдэлийн даатгалын хуулийн төслийг боловсруулж батлуулах нь гамшгийн эрсдэлийг бууруулах, эрсдэлийг шилжүүлэх үйл ажиллагаанд оролцох хувийн хэвшлийн оролцоо, хамтын ажиллагаа нэмэгдэх давуу тал бий болно.

2.3.2. Малын индексжүүлсэн даатгалын явц

Малчдын ган, зудыг хохирол багатай даван туулах эрсдэлийг бууруулах менежментийн нэг хэсэг нь малын даатгалын асуудал юм. Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль 2014 оноос Монгол Улсад хэрэгжиж эхэлснээс 21 аймгийн

¹⁹ ОБЕГ Санхүүгийн мэдээлэл, 2022

330 сум, нийслэлийн 6 дүүргийн хэмжээнд малын индексжүүлсэн даатгалын үйлчилгээг үзүүлж байна.

“Үндэсний давхар даатгал” ХК нь улсын хэмжээнд малын индексжүүлсэн даатгал үйлчилгээг Ард даатгал ХК, Бодь даатгал ХК, МИГ даатгал ХХК, Монгол даатгал ХК, Монре даатгал ХХК, Мөнх даатгал ХХК, Практикал даатгал ХХК, Тэнгэр даатгал ХХК, Хаан даатгал ХХК зэрэг 9 оролцогчийн 2611 төлөөлөгч болон зуучлагч банк болох Төрийн банк, Хаан банкаар дамжуулан явуулж байна.

2016-2021 онд нийт малчин өрхийн 11.7-19.8 хувь буюу өссөн дүнгээр 172.2 мянган малчин өрх 39.6 сая малыг 18.8 тэрбум төгрөгөөр даатгуулан 4.7 тэрбум төгрөгийн нөхөн олговрыг авсан байна.

Хүснэгт 13 Малын индексжүүлсэн даатгалд хамрагдсан байдал

Он	Хамрагдсан малчин өрх	Нийт малчин өрхөд эзлэх хувь	Даатгагдсан малын тоо	Нийт малд эзлэх хувь	Хураамжийн орлого /тэрбум төгрөг/	Нөхөн төлбөр /сая төгрөг/
2016	18738	11.7	4.2	7.5	1.77	79.6
2017	24148	15.3	5.7	9.2	2.33	1091.9
2018	33719	19.8	7.8	11.8	3.46	323.3
2019	32337	18.8	7.4	11.2	3.85	600.9
2020	28527	16.6	7.1	10.2	3.48	2593.3
2021	34709	19.2	7.4	11.0	3.92	
Нийт	172178		39.6		18.81	4689.0

Малын индексжүүлсэн даатгалд хамрагдалт нь 2016 онтой харьцуулахад малчин өрхийн тоо 18.7-34.7 мянга болж 85.0 хувиар, борлуулалтын орлого 1.7-3.9 тэрбум болж 1.3 дахин, нөхөн олговор 79.6-2593.3 сая төгрөг болж 31.6 дахин өссөн байна. Малыг индексжүүлсэн даатгалд хамрагдсан малын тоо, хураамжийн орлого, нөхөн олговор нь жил бүр харилцан адилгүй байгаа нь тухайн жилийн зуншлага, цаг агаарын нөхцөл байдлаас ихээхэн хамааралтай болохыг харуулж байна²⁰.

2.3.3. Цаашид

Нэн тэргүүнд анхаарах асуудал

- Гамшгийн эрсдэлийг бууруулах санхүүжилтийн стратеги боловсруулан хэрэгжүүлэх,
- Гамшгийн болзошгүй хохирлыг бууруулахын тулд гамшгийн эрсдэлийг бууруулах улсын болон орон нутгийн төсвийн хэмжээг нэмэгдүүлэх,
- Гамшгийн эрсдэлийг шилжүүлэх чиглэлээр гамшгийн эрсдэлийн даатгалын хуулийн төсөл боловсруулах.

²⁰ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, 2022

2.4. Гамшгийн бэлэн байдал, хор уршгийг арилгах, сайжруулан сэргээн босгох ажиллагаанд гарсан ахиц дэвшил

Гамшгийн бэлэн байдал, хор уршгийг арилгах, сайжруулан барьж байгуулах чиглэлээр 2015-2022 онд олсон ололт амжилт, сургамжаас дараах үйл ажиллагааг онцлон түүвэрлэв.

2.4.1. Гамшгаас хамгаалах төлөвлөгөө

Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөө болох "Гамшгийн аюулаас хүн ам, эд хөрөнгө, мал, амьтныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний төлөвлөгөө" нь Засгийн газрын 2015 оны 416 дугаар тогтоолоор батлагдсан. КОВИД-19 халдварын үед энэхүү төлөвлөгөөний дагуу Эрүүл мэнд улсын алба ажилласан.

Үүнээс Шадар сайдын 2018 оны 120 дугаар тушаалаар "Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар", ОБЕГ-ын даргын 2019 оны А/388 дугаар тушаалаар батлуулсан "Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах загвар"-ыг онцолъё. Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгад засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах алба, хуулийн этгээд нь гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй байна, гамшгийн эрсдэлийн үнэлгээ нь гамшгаас хамгаалах төлөвлөгөөний үндэслэл болно гэж тусгасан.

Энэ хүрээнд i) аймаг, нийслэл, сум дүүргийн, ii) гамшгаас хамгаалах албаны, iii) байгууллага, аж ахуйн нэгжийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах зааврыг боловсруулсан. Төлөвлөгөөний бүтцийг *Хүснэгт 14*-т харуулав.

Хүснэгт 14 Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний бүтэц

	Аймаг, нийслэл, сум дүүргийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө	Гамшгаас хамгаалах албаны төлөвлөгөө	Байгууллага, аж ахуйн нэгжийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө
1.	Нийтлэг үндэслэл	Нийтлэг үндэслэл	Нийтлэг үндэслэл
2.	Танилцуулга	Танилцуулга	Танилцуулга
3.	Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө	Гамшгаас хамгаалах бэлтгэл, бэлэн байдлыг хангах төлөвлөгөө	Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө
4.	Хариу арга хэмжээний төлөвлөгөө -гамшгийн аюулт үзэгдэл, ослын төрөл бүрээр хийнэ I.Эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах төлөвлөгөө II.Гамшгаас хамгаалах дайчилгаа зохион байгуулах төлөвлөгөө III.Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө	Хор уршгийг арилгах арга хэмжээний төлөвлөгөө -гамшгийн аюулт үзэгдэл, ослын төрөл бүрээр хийнэ	Аюулт үзэгдэл, ослын үед хэрэгжүүлэх хариу арга хэмжээний төлөвлөгөө
5.	Сэргээн босгох төлөвлөгөө	Сэргээн босгох төлөвлөгөө	Аюулгүйн цэгт цугларах төлөвлөгөө
6.	Хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах төлөвлөгөө		
7.	Хавсралт	Хавсралт	Хавсралт
8.	Бүтцэд нэмэлт хэсэг оруулж болно.		

Гамшгийн эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 2018-2020 онд улсын хэмжээнд бүх засаг захиргааны нэгжийн Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэн боловсруулсан.

Засаг захиргааны нэгжийн болон гамгаас хамгаалах албадын төлөвлөгөөний тавдугаар бүлэг нь сэргээн босгох төлөвлөгөө юм. Тус төлөвлөгөөнд КОВИД-19 халдварт цар тахалтай холбогдуулан тодотгол хийгдсэн байна. Цаашид гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд заасан арга хэмжээг хэрэгжүүлэх, дадлагажуулах чиглэлээр дасгал сургууль тогтмол зохион байгуулах зүйтэй.

2.4.2. Барилгын норм дүрэм шинэчлэгдсэн

Монгол Улсын хэмжээний барилга байгууламж, зам гүүр, шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж, гал түймэр гарч болзошгүй газрын тосны барилга байгууламжийн гамшгийн төлөв байдлыг тогтоох ажлыг 2004 оноос хийж эхэлсэн.

2016 болон 2022 онд хийгдсэн тандалт судалгаагаар дээрх барилга байгууламжийн хийц, бүтээц, газар хөдлөлтийн ямар эрсдэлд байгаа, аль аймагт ямар барилга байгууламж гамшгийн эрсдэлийн ямар төлөвт байгааг тодорхойлж, гарсан дүнд үндэслэн "Барилгын тухай хууль"-д нэмэлт оруулж, Шадар сайдын 2021 оны 129 дүгээр тушаалаар "Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах журам"-ыг шинэчилж, мөрдлөг болгон ажиллаж байна.

Монгол Улсын барилга байгууламжийн норм, нормативын сангийн үйл ажиллагааны 2019 оны төлөвлөгөөний дагуу дараах норм, нормативын баримт бичгийг шинээр болон шинэчлэн боловсруулсан байна. Үүнд:

- Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм /БНБД30-01-04/,
- Ерөнхий боловсролын сургуулийн барилга байгууламжийн төлөвлөлт /БНБД/,
- Сургуулийн өмнөх боловсролын барилгын зураг төсөл төлөвлөх /БНБД/,
- Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөх /БНБД31-01-10/,
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан барилга байгууламжийн хүртээмжтэй байдал /БД31-101-04/,
- Эмнэлгийн байгууллагын барилга, өрөө тасалгааны зураг төсөл төлөвлөх /БНБД/,
- Олон нийт, иргэний барилга /БНБД31-03-03/,
- Олон төрлийн зориулалттай барилга /БНБД/,
- Үзвэр үйлчилгээ, театрын барилга байгууламжийн төлөвлөлт /БНБД/,
- Зочид буудлын барилга төлөвлөлт /БНБД/.

Гал түймэр, газар хөдлөлт, үер, хүчтэй салхи шуурга зэрэг гамшигт тэсвэртэй барилга, байгууламжийг бүтээн босгохыг бодлого болгон ажиллаж байна.

2.4.3. Өндөр ууланд эрэн хайх, аврах ажиллагаа явуулах арга техник сайжирсан

Монгол Улс хойд болон баруун талаараа уулархаг, Алтай нурууны ноён оргил Алтай таван богд уулын “Хүйтний оргил” далайн төвшнөөс 4374м, хангайн нурууны ноён оргил “Отгонтэнгэр” 3095м өндөр мөнх цастай уулс юм. Монгол Улсад 1961 онд Увс аймгийн Түргэний ууланд 10 гаруй уулчид осолдож 1 уулчин амь насаа алдаж байсан. Үүнээс хойш 2015-2022 оны хугацаанд өндөр ууланд цасан нурангид дарагдсан 2 том осол тохиолдсон.

- 2015 оны 7 дугаар сард Алтай таван богд ууланд авиралт хийж явсан уулчид осолдож, 5 уулчин амь насаа алдсан.
- 2017 оны 10 дугаар сард уулчид Отгонтэнгэр ууланд авиралт хийгээд буцахдаа цасан нурангид дарагдаж 27 уулчнаас 17 хүн амь насаа алдсан.

Энэхүү том ослын үеэр эрэн хайх, аврах ажиллагаанд ОБЕГ, Үндэсний аврах бригад, орон нутгийн Онцгой байдлын газрын алба хаагчид, нэмэлтээр Цагдаагийн байгууллага, Хилийн цэргийн дугаар анги, уулын авиралтын тамирчид зэрэг 2015 онд 25 гаруй хүн, 3 техник хэрэгсэл, 1 нисдэг тэрэгтэй, 2017 онд 254 гаруй хүн, 43 техник хэрэгсэл, 2 нисдэг тэрэг оролцсон.

Эрэн хайх, аврах баг цаг агаарын хүндрэлтэй байдлаас шалтгаалан нэлээдгүй сорилттой тулгарч байсан ч ослын эрэн хайх аврах ажиллагааг амжилттай зохион байгуулсан.

Дараалан тохиолдсон 2 том осолд ажилласан туршлага, сургамжид суурилан ОБЕГ өндөр ууланд эрэн хайх, аврах ажиллагаа явуулах чиглэлээр гадаад, дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх, эрх зүйн баримт бичгийг сайжруулах, ууланд аврах ажиллагаа явуулах аврагчдын ажиллагааны арга техникийг сайжруулах, дадлагажуулах, стандарт бүхий хувцас, багаж хэрэгслээр хангах зайлшгүй шаардлага байгааг тодорхойлсон.

Өндөр ууланд эрэн хайх, аврах ажиллагаа явуулах дадлага сургалтыг олон улсын аврагчидтай анх удаа 2018 оны 8 дугаар сард зохион байгуулсан. Сургалтад ОХУ, БНКиргиз Улс, Монгол Улсын аврагчид, Монголын уулчдын баг, Зэвсэгт хүчний дугаар анги зэрэг өргөн бүрэлдэхүүнтэй оролцсон. Үүнээс хойш хэд хэдэн дадлага сургалтыг зохион байгуулж аврагчдаа бэлтгэж байна.

Эрх зүйн баримт бичгийн хувьд ОБЕГ-ын даргын 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн А/330 дугаар тушаалаар “Өндөр уулнаас эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулах журам”-ыг батлуулсан.

Цаашид уулын спортыг сонирхож ууланд алхах, авирах хүмүүсийн тоо нэмэгдэж байгаатай холбогдуулан уулчдын аюулгүй байдлыг хангах, эрсдэлийг бууруулах ойлголт, мэдлэг илүүтэй олгох, батлагдсан журмын дагуу аврагчдад дадлага сургалт зохион байгуулах, стандартын хамгаалалтын хувцас, багаж төхөөрөмжөөр хангах хэрэгцээ, шаардлага байна.

2.4.4. “Говийн чоно” гамшгийн хор уршгийг арилгах олон улсын дадлага сургууль

Гамшгийн бэлтгэл, бэлэн байдлыг хангах, гамшгийн үед талуудын хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор гамшгийн хор уршгийг арилгах олон улсын сургалт, дадлага сургууль, туршлага солилцох үйл ажиллагааг Онцгой байдлын ерөнхий газар зохион байгуулдаг. Үүний нэг нь Монгол Улсад 2009 оноос эхлэн ОБЕГ, АНУ-ын Энэтхэг-Номхон далайн цэргийн командлал хамтран зохион байгуулж ирсэн “Говийн чоно” олон улсын сургалт, дадлага сургууль юм. 2015-2022 онд зохион байгуулсан “Говийн чоно” олон улсын сургалт, дадлага сургуулийн жагсаалт, оролцогчдын тоог **Хавсралт 5-аас** үзнэ үү. Эдгээрээс “Говийн чоно-2022” сургалт, дадлага сургуулийн мэдээллийг онцлон хүргэе.

“Говийн чоно-2022” сургалт, дадлага сургуулийг **“Газар хөдлөлтийн гамшгийн хор уршгийг арилгах, хариу арга хэмжээ”** сэдэвтэйгээр Онцгой байдлын ерөнхий газар, АНУ-ын Элчин сайдын яам, Энэтхэг-Номхон далайн цэргийн командлал, Аляскийн үндэсний гвардтай хамтран хойд, өмнөд бүсийн 7 аймгийг хамруулан Баянхонгор аймагт 2022 оны 9 дүгээр сарын 05-10-ны өдрүүдэд зохион байгуулсан.

Сургалт, дадлага сургуульд нийт 310 хүн оролцсон. Үүнээс

- Монгол Улсаас 262 оролцогч: ОБЕГ, холбогдох яам агентлаг, Баянхонгор аймгийн Онцгой комисс, Өмнөговь, Говь-Алтай, Завхан, Дундговь, Өвөрхангай, Дархан-Уул аймгуудын Онцгой байдлын газраас,
- Гадаад улс орноос 48 оролцогч АНУ, Балба, Бангладеш, Вьетнам, Их Британи, Тайланд, Шинэ Зеланд Шри Ланка улсаас оролцов.

“Говийн чоно-2022” сургалт, дадлага сургууль нь дараах 3 хэлбэрээр зохион байгуулагдсан. Үүнд:

Танхимын сургалт, хэлэлцүүлэг

- Гамшгийн хор уршгийг арилгах мэдлэг, туршлагаа солилцох зорилгоор танхимын сургалтыг зохион байгуулсан. Нийт 110 хүн оролцсон.

Команд штабын сургууль

Гамшгийн хор уршгийг арилгах олон улсын сургалт, дадлага сургуулийг дараах зорилгоор зохион байгуулж 110 хүн хамрагдсан. Үүнд:

- гамшгийн нөхцөл байдлыг үнэлэх, хариу арга хэмжээ авах, бэлтгэл бэлэн байдлыг дээшлүүлэх,
- бүсийн түвшинд тохиолдсон гамшиг, ослын цагийн байдлын үед харилцан ажиллагааг зохицуулах,
- хүч хэрэгслээ төлөвлөх, хуваарилах, гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөг турших,
- цэрэг иргэний харилцан ажиллагааг жигдрүүлэх,
- олон улсын хүмүүнлэгийн тусламж хүлээн авах зохицуулалтыг сайжруулах,

- гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд иргэний байгууллагуудын оролцоог хангах.

Дууриалган үзүүлэх дадлага сургууль

- Химийн ослын үед аврах, хор уршгийг арилгах ажиллагааны үзүүлэх дадлага сургууль: 41 хүн 8 автомашин техник хэрэгсэл оролцсон.
- Газар хөдлөлтийн гамшгийн үед аврах ажиллагааны дадлага сургууль: 81 хүн 12 автомашин, 1 нисдэг тэрэг оролцсон
- Хээрийн эмнэлгийн тусламж үзүүлэх ажиллагааны дадлага, сургууль: 41 хүн 2 автомашин, 1 нисдэг тэрэг оролцсон²¹.

КОВИД-19 цар тахлын дараа зохион байгуулагдсан тус сургалт, дадлага сургуулийн агуулга нь газар хөдлөлтийн гамшгийн үед үймээн самуун, гэмт хэрэг гарах, харилцаа холбоо тасалдах, шатахуун түгээх станцын дэлбэрэлт болох, нисэх буудалд аюултай бодис алдагдах зэрэг хавсарсан гамшгийн үед харилцан ажиллагааг зохицуулах, хүч хэрэгслийг төлөвлөх, хуваарилах, төлөвлөлтийн чадвар олгоход илүүтэй чиглэгдсэнээрээ онцлог болсон²².

Энэхүү сургалт, дадлага сургууль нь тавьсан зорилгоо биелүүлж, олон улсын оролцогчид бие биеэсээ суралцан, туршлага солилцож, гамшгийн үед хамтран ажиллах үүрэг хариуцлагыг ойлгож, хамтын ажиллагааг өргөжүүлснээрээ ач холбогдолтой байв.

2.4.5. Гамшгийн үед ашиглагдах Улаанбаатар хотод байрлах түр цугларах талбай, нүүлгэн шилжүүлэх байршил, түр байр

Газар хөдлөлтийн гамшгийн бэлэн байдлыг хангах зорилгоор Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 94, 2020 оны 17 дугаар тогтоолоор түр цугларах талбай (цэг) 192, нүүлгэн шилжүүлэх 31 байршлыг томилгоожуулсан.

Түр цугларах талбай (цэг)




192 түр цугларах талбай (цэг) нь 442,300 м² талбай газрыг эзэлж байна. Тус түр цугларах талбайд болзошгүй гамшгийн аюулт үзэгдэл, ослын үед 300,000 орчим хүнийг гаргаж аюулгүй байдлыг хангана гэж төлөвлөсөн байна.

Нийслэлийн хэмжээнд байгаа түр цугларах талбай (цэг)-н байршлыг <http://manaikhoroo.ub.gov.mn/> хүлээн авна уу.

²¹ “Говийн чоно 2022” сургалт, дадлага сургуулийн тайлан, ОБЕГ, 2022

²² “Говийн чоно” дадлага сургуулийн гамшгийн хор уршгийг арилгах чадавхыг бэхжүүлэхэд оруулсан хувь нэмэр, Б.Ууганбаяр, Д.Сэржмядаг, Д.Бат-Эрдэнэ, Гамшиг судлал, инновац сэтгүүл, 2022 №2



Зураг 16 Нийслэлийн хэмжээнд байгаа түр цугларах талбайн байршил
Эх сурвалж: <http://manaikhoroo.ub.gov.mn/>

Нүүлгэн шилжүүлэх байршил

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 94 дүгээр тогтоолоор батлагдсан 31 байршилд түр байраар ашиглах 478 түр сууцанд 5820 хүнийг байрлуулна гэж төлөвлөж байна.


Түр байр

Нийслэлийн хэмжээнд 2002 оноос хойш баригдсан газар хөдлөлтийн 7-8 баллын газар хөдлөлтөд тэсвэртэй цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үндсэн байр болон спорт заал, зочид буудлын барилга, амралт аялал жуулчлалын газар зэрэг нийт 344 барилга байгууламжийг түр байраар ашиглана гэж төлөвлөсөн²³.

Эдгээрээс ерөнхий боловсролын сургуулийн барилга байгууламжийг онцолъё. Боловсрол, шинжлэх ухааны яамны захиалгаар Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлсэн “Улаанбаатар хотын бага, дунд боловсролын сургуулийн барилга байгууламжийг сайжруулах” (The project for the Improvement of Facilities for Primary and Secondary Education in Ulaanbaatar City in Mongolia) төслийн хүрээнд Улаанбаатар хотын 2 сургуулийн барилгыг шинээр, 2 сургуулийн барилгад өргөтгөл барьсан. Жишиг сургуулийн барилгын мэдээллийг **Хавсралт 6-аас** хүлээн авна уу²⁴.

²³ ОБЕГ-ын Ажиллагааны удирдлагын газар, 2022

²⁴ Preparation Survey Report, Project for the Improvement of Facilities for Primary and Secondary Education in Ulaanbaatar City in Mongolia, 2018 https://openjicareport.jica.go.jp/pdf/12302170_01.pdf



Зураг 17 Сургуулийн байршил
Эх сурвалж: Төслийн судалгааны тайлан, 2018

Тус 4 сургуулийн барилга нь Монгол Улсад сургуулийн барилгыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй, гамшигт тэсвэртэй, гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх түр байраар ашиглах боломжтой, байгаль орчинд ээлтэй жишиг сургуулийн барилга болсон. Тус бүр 18 тонн усны нөөц сав, хүнсний болон бусад төрлийн нөөц хадгалах агуулах, цахилгааны нөөц үүсгүүртэй тул газар хөдлөлтийн гамшиг тохиолдсон үед иргэдийг байрлуулах бүрэн боломжтой.

Шинээр баригдсан сургууль:

- 2020 онд 720 хүүхдийн хүчин чадалтай Чингэлтэй дүүргийн ерөнхий боловсролын 149 дүгээр сургууль
- 2021 онд 920 хүүхдийн хүчин чадалтай Хан-Уул дүүргийн ерөнхий боловсролын 75 дугаар сургууль

Өргөтгөл баригдсан сургууль:

- 2020 онд 480 хүүхдийн хүчин чадалтай Баянзүрх дүүргийн ерөнхий боловсролын 53 дугаар сургууль
- 2020 онд 320 хүүхдийн хүчин чадалтай Налайх дүүргийн ерөнхий боловсролын 109 дүгээр сургууль

Нэгдсэн Үндэстний байгууллагын Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага, Монголын Улаан загалмай нийгэмлэгээс 75, 149 дүгээр сургуулийг гамшгийн үед түр байраар ашиглах нөөцийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажилласан.

Цаашид аймаг, сумын хэмжээнд түр байраар ашиглах боломжтой барилга байгууламжийг томилгоожуулан, шаардлагатай нөөцийг бүрдүүлэх шаардлагатай.

2.4.6. Эрт зарлан мэдээлэх систем

Гамшгийн аюулыг эрт зарлан мэдээлэх системийг хөгжүүлэхэд Монгол Улс анхаарал хандуулж ирсэн хэдий ч гамшгийн аюулыг эрт зарлан мэдээлэх системийн бэлэн байдлыг хангахад хүндрэл бэрхшээлтэй хэвээр байна.

ОБЕГ дэргэдэх Шуурхай удирдлага зарлан мэдээллийн төвийн гамшгийн аюулыг зарлан мэдээлэх систем нь 2013 онд ашиглалтад орсон. Тус систем нь газар хөдлөлт болон бусад аюулт үзэгдлийн үед ШУА-ын Одон орон геофизикийн хүрээлэн, Цаг уур орчны шинжилгээний газраас мэдээ мэдээллийг хүлээн авч Улаанбаатар хотод суурилуулсан хэт богино долгионы дахин дамжуулах 4 бааз станцаар дамжуулан дуут дохиоллын 60 ширхэг цамхаг, өргөн нэвтрүүлгийн 3 телевиз, 10 FM радиогоор гамшгийн аюулыг анхааруулах, сэрэмжлүүлэх мэдээг иргэд, олон нийтэд дамжуулахаар зохион байгуулагдсан.

Хүснэгт 15 Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх системийн нөхцөл байдал

	2013 он	2022 он
Дуут дохиоллын цамхагийн тоо	60	50
Өргөн нэвтрүүлгийн телевизийн тоо	3	2
FM Радио станцын тоо	10	6

Үүрэн холбооны оператор компаниудаар дамжуулан иргэд, олон нийтэд гамшгийн аюулын тухай багц мессеж, сэрэмжлүүлэг хүргэх үйлчилгээ технологийн дэвшил (4G, 5G)-ээс хамааран хоцрогдолтой болох нөхцөл бий болсон. Ерөнхийдөө гамшгийн аюулыг зарлан мэдээлэх системийн хөгжүүлэлтийн 2022 оны байдлыг 2015 онтой харьцуулахад буурсан үзүүлэлттэй байна (*Хүснэгт 15*).

Иймд цаашид гамшгийн аюулыг зарлан мэдээлэх системийн хөгжүүлэлтэд дараах арга хэмжээг авах нэн шаардлагатай байна. Үүнд:

- Зарлан мэдээллийн системийг олон улсын түвшинд нийцэхүйц сорс кодтой шинэ систем, технологийг нэвтрүүлэх, программ хангамжийн шинэчлэлт хийх, серверүүдийн хүчин чадлыг нэмэгдүүлэх,
- Зарлан мэдээллийн системүүдэд засвар, үзлэг, үйлчилгээ хийх санхүүжилтыг нэмэгдүүлэх,
- Иргэдэд үүрэн холбооны оператор компаниуд, телевизүүдээр дамжуулан зарлан мэдээлэл хүргэх шинэ технологи, системийг нэвтрүүлэх,
- Шуурхай удирдлага, зарлан мэдээллийн асуудал хариуцсан алба хаагчдыг сургаж, чадавхжуулах,
- Шуурхай удирдлага зарлан мэдээллийн төвийг түшиглэн үндэсний хэмжээний гамшгийн шуурхай удирдлагын төвийг байгуулах.

2.4.7. Хөвсгөл нууранд живсэн хөлөг онгоцыг татан гаргах ажиллагаа

Онцгой байдлын байгууллагад ирж буй яаралтай дуудлагын 2.5 хувийг (2015-2022 оны дундаж) усанд живсэн гэсэн ослын дуудлага эзэлж байна. Усанд

осолдсон хүн, машин, техник хэрэгслийн дуудлагаар онцгой байдлын аврагчид эрэн хайх, аврах ажиллагаа явуулдаг, мөн ослын дараах сэргээн босгох үйл ажиллагаанд оролцдог.

Сэргээн босгох ажиллагааны сайн жишээ бол Хөвсгөл нууранд живсэн “Сүхбаатар” хөлөг онгоцыг татан гаргасан явдал юм. Хөвсгөл нуур нь Монгол Улсын гадаргын цэнгэг усны 75 хувь, дэлхийн газаргын цэнгэг усны 2 орчим хувийг бүрдүүлдэг, 2 сая жилийн настай нуур юм²⁵. Иймд Хөвсгөл нуурыг хамгаалах, бохирдлыг бууруулах зорилгоор нууранд живсэн хөлөг онгоц, автомашиныг татан гаргаж цэвэрлэх ажиллагаа 2021 онд эхэлсэн. Зарим нь шатахуун тээвэрлэж явсан байна. Судалгаагаар Хөвсгөл нууранд живсэн 50 орчим машин, техник байна²⁶.

“Сүхбаатар” хөлөг онгоцыг татан гаргах ажиллагаа нь Хөвсгөл нуурын эко системийг хамгаалах, бохирдлыг бууруулах зорилгын хүрээнд хийгдсэн хамгийн том ажиллагаа гэдгээрээ онцлог. Мөн энэхүү ажиллагаа нь Монгол Улсад урьд өмнө хийгдэж байгаагүй бөгөөд усны гүнд, хөндлөн чиглэлд гүйцэтгэсэн түүхэн арга хэмжээ болсон.

ЗХУ-д 1956 онд үйлдвэрлэгдсэн “БОР-500” загварын “Сүхбаатар” хөлөг онгоц нь 1985 онд Хөвсгөл нуурын эргээс 110-120 метрийн зайд, 12-16 метрийн гүнд (хөлөг онгоцны тэнхлэгээр тооцвол хойд хэсгээрээ усны түвшнээс 9м, урд хэсгээрээ 3,2м гүнд), зүүн хойноос баруун урд чигт байрлаж, нуурын ёроолд 1,4-1,9 метр гүн шигдсэн байсан

“Сүхбаатар” хөлөг онгоцыг татан гаргах ажлын хэсэг ажиллагааг 2021 оны 10 дугаар сарын 01-нээс 11 дүгээр сарын 05-ныг хүртэл нийт 36 хоног ажилласан. Татан гаргах ажиллагаанд ОБЕГ-ын тэргүүн дэд даргаар ахлуулсан Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний жанжин штаб, түүний харьяа Зэвсэгт хүчний ... дугаар анги, ОБЕГ, түүний харьяа Үндэсний аврах бригад, Нийслэлийн болон Орхон, Хөвсгөл аймгийн Онцгой байдлын газар, Зам тээврийн хөгжлийн яамны харьяа Далайн захиргааны газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, Шинжлэх ухаан, технологийн их сургууль, Хөвсгөл аймгийн ЗДТГ, Цагдаагийн газар, Алаг-Эрдэнэ сумын Хатгал тосгоны захирагчийн ажлын алба, “Хөвсгөл усан зам” ХК-ийн нийт 120 гаруй алба хаагч, 50 нэгж техник хэрэгсэлтэйгээр амжилттай гүйцэтгэсэн.

“Сүхбаатар” хөлөг онгоцыг татан гаргах ажиллагааг дараах төлөвлөгөөний дагуу гүйцэтгэхээр төлөвлөж боловсруулсан. Үүнд:

- I. Татан гаргах ажиллагаанд бэлтгэх;
- II. Хөлөг онгоцыг татах ган татлагыг холбох, хөвүүлэх;
- III. Хөлөг онгоцыг татах ажиллагааг төлөвлөлтийн дагуу явуулах;
- IV. Хөлөг онгоцыг эрэгт байрлуулах гэсэн үе шаттайгаар явуулахаар төлөвлөж амжилттай хэрэгжүүлсэн.

Усны гүнд “Сүхбаатар” хөлөг онгоцыг татан гаргах ажиллагаанд 16 шумбагч, ажиллаж, 12-16 метрийн гүнд ган татлагыг хөлөг онгоцны урд, хойд, хажуу талд холбох, бэхлэх, салгах, бөгжлөх, тайрах, залгах, хөрөөдөх, хөлгийн сэнс, хажуу тал,

²⁵ “Хөвсгөл нуурын ёроолын геодезийн хэмжилт, зураглалын ажлын зарим асуудалд” Л.Бат-Эрдэнэ¹, Л.Базарзагд², Д. Мөнхцэцэг³
<http://5dworld.mn/post/119164>

²⁶ Хөвсгөл живсэн машин, техник, ачааны байршлын тогтоосон судалгааны таарц, Х.Дашидэндэв, 2021

урд талуудад татах хөшүүрэг хийх, боломжит өрөө, тасалгаанд дугуйны 30 ширхэг олгойг хийлэн байрлуулж, усны эзэлхүүнийг шахах, усны гүнд төмөр эд зүйлийг тасдах, гүн хэмжих, хязгаарлах хөвүүр тэмдэгтийг байрлуулах, хөлгийг дотор болон гадна талаас битүүмжлэх, усан эргүүл, аврах ажиллагааны бэлэн байдалд тус тус үүрэг гүйцэтгэж ажилласан. Таталтын ажиллагааг зохион байгуулахдаа батлагдсан технологийн карт, дарааллын дагуу Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн эрдэмтэн, багш, инженерүүд, удирдлагын бүрэлдэхүүн таталт бүрийн тооцооллыг өдөр, цаг, минутаар төлөвлөж, ажиллагааны ярилцлага бүрт нарийвчлал, тооцоог гаргаж, нийт 60 удаагийн таталтын ажиллагааг зохион байгуулсан.

1



Зураг 18 Живсэн хөлөг онгоцыг байршуулах үе

Эх сурвалж: ОБЕГ, 2021

“Сүхбаатар” хөлөг онгоцыг татан гаргах явцад 200 литр 2 торх масло шүүрч байсныг аюулгүй болгон ажиллалаа. Олон улсын жишгээр 100 литр шатахуун алдагдахад 1,1 км/куб эзэлхүүнтэй усыг бохирдуулдаг гэсэн судалгаа байдаг байна. “Хөвсгөл” нуур нь 380 м/куб эзэлхүүнтэй. Үүгээр жишээлэхэд 100 литр масло асгарахад нуурын 0,29 хувь нь бохирдох эрсдэлтэй юм²⁷.

Татан гаргасан тус хөлөг онгоцыг Хөвсгөл нуурын эрэгт аялал жуулчлалын зориулалтаар музей болгон байршуулсан.

2.4.8. Цаашид

Нэн тэргүүнд анхаарах асуудал

- Гамшгийн үед үр дүнтэй, шуурхай хариу арга хэмжээ авахын тулд Гамшгийн шуурхай удирдлагын төвийг байгуулах, техник тоног төхөөрөмжөөр хангах,
- Гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөг бүх шатанд сайжруулах, төлөвлөгөөний дагуу дадлага сургуулилт хийх,
- КОВИД-19 цар тахлын дараах сургамжид үндэслэн төр, хувийн хэвшлийн

²⁷ “Гамшгаас хамгаалах цагаан ном 2021” ОБЕГ 2022

хамтын ажиллагааг сайжруулах, гамшгийн үед бизнесийн тасралтгүй ажиллагааны төлөвлөлт хийхэд хамтран ажиллах,

- Гамшиг, аюулт үзэгдэл, ослын дараа барилга байгууламж, дэд бүтцийн гамшигт тэсвэртэй байдал, бодлого төлөвлөлтийн оновчтой байдал, хүн амын гамшгийн бэлэн байдалд хяналт хийж, сайжруулан барьж байгуулах,
- Гамшгийн үеийн нүүлгэн шилжүүлэх түр байрны зохион байгуулалтыг сайжруулах,
- Эрт зарлан мэдээллийн системийн өнөөгийн байдлыг сайжруулах, хүн бүр гамшгийн эрт зарлан мэдээлэл хүлээн авах нөхцөлийг хангах.

3.1. Гадаад хамтын ажиллагаа

Онцгой байдлын байгууллага нь байгуулагдсан цагаас Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалд суурилан гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр дэлхийн улс орнуудтай хоёр талын хамтын ажиллагаа тогтоон өргөжүүлж, олон талт хамтын ажиллагаанд оролцож ирсэн.

2015-2022 оны хугацаанд гадаад улс орны ижил төстэй чиг үүрэгтэй 16 байгууллагатай шинээр хамтын ажиллагаа тогтоосон. Гадаад хамтын ажиллагаатай байгууллага 2015 онтой харьцуулахад 32 хувиар өссөн үзүүлэлтэй.

2022 оны 12 дугаар сарын байдлаар ОБЕГ-тай гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 10-аад орны ижил төстэй чиг үүрэг бүхий байгууллага, 20 гаруй дэлхийн болон бүс нутгийн хэмжээний олон улсын байгууллагатай харилцаа хамтын ажиллагаатай ажиллаж байна.

Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр гадаад харилцааны хүрээнд гарсан томоохон өөрчлөлтөөс жишээ татъя. Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын “Хил орчмын ой, хээрийн түймэртэй тэмцэх талаар хамтран ажиллах тухай” хэлэлцээрийг 1999 онд байгуулснаар хоёр улсын онцгой байдлын салбар дахь хамтын ажиллагааны эхлэл тавигдсан ба тус хэлэлцээрийг 2022 оны 02-р сард шинэчлэн байгуулав. Хэлэлцээр байгуулагдсанаас хойш хоёр улсын хил орчмын бүсэд ой, хээрийн түймэрт хяналт тавих, хамтарсан дадлага, сургууль зохион байгуулах, туршлага солилцох, харилцан тусламж үзүүлэх механизмыг бий болгох зорилгоор 2011 онд Монгол Улсад “Хил орчмын ой, хээрийн түймэртэй тэмцэх талаар хамтран ажиллах Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг хэрэгжүүлэх нарийвчилсан журам”-ыг мөрдөн ажиллаж байна.

Мөн НҮБ-ын төрөлжсөн байгууллага, Монгол дахь НҮБ-ын суурин төлөөлөгчийн газартай нягт хамтран ажиллаж байгаа талаар онцолъё. Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах газар, Онцгой байдлын ерөнхий газартай хамтран “Гамшгийн эрсдэлийг бууруулах Азийн сайд нарын бага хурал”-ыг Улаанбаатар хотноо 2018 оны 07 дугаар сарын 03-06-ны өдрүүдэд зохион байгуулсан. “Гамшгийн эрсдэлийг бууруулснаар тогтвортой хөгжлийг хамгаалах нь” уриан дор Ази, Номхон далайн орны 50-аад улс, олон улсын байгууллага, Засгийн газар хоорондын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагууд, шинжлэх ухааны, боловсролын зэрэг байгууллагын нийт 3000 гаруй төлөөлөгч оролцов. Бага хуралд оролцогч улс орнууд гамшгаас хамгаалах чиглэлээр хийгдэж байгаа үйл ажиллагааны ололт, амжилт, тулгарч буй хүндрэл бэрхшээлийн талаар хэлэлцэн, зөвлөмжийг боловсруулж, “Улаанбаатарын тунхаглал”, “Азийн бүсийн төлөвлөгөө 2018-2020”, “Оролцогч талуудын мэдэгдэл” баримт бичгүүдийг батлан гаргасан.

“Гамшгийн эрсдэлийг бууруулах Азийн сайд нарын бага хурал”-ын бэлтгэл ажлын хэсэг болгон “Гамшгийн эрсдэлийг бууруулах олон улсын стратегийн Азийн

түншлэлийн хурал”-ыг НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах газартай хамтран Улаанбаатар хотноо 2017, 2018 оны 04 дүгээр саруудад амжилттай зохион байгуулав. Мөн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргын Гамшгийн эрсдэлийг бууруулах асуудал хариуцсан Тусгай Төлөөлөгч, хатагтай Маргарета Волстром 2015 онд, ноён Роберт Глассер 2017 онд, хатагтай Мами Мизутори 2018 онд тус тус Монгол Улсад айлчилсан.

2017 онд Мексикийн Нэгдсэн Улсын Канкун хотноо зохион байгуулагдсан Гамшгийн эрсдэлийг бууруулах дэлхийн чуулганы үеэр Монгол Улсын Шадар сайд У.Хүрэлсүх (одоогийн Монгол Улсын ерөнхийлөгч)-ыг Онцгой байдлын албыг бэхжүүлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах салбарыг хөгжүүлэхэд жинтэй хувь нэмэр оруулж ирснийг НҮБ-ын зүгээс өндрөөр үнэлж, НҮБ-ын “Манлайлагч-Төрийн түшээ”-гээр өргөмжилсөн байна. Уг өргөмжлөлийг НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын Тусгай төлөөлөгч Роберт Глассер гардуулсан.

Мөн хот, суурин газрын эрсдэлийг бууруулах, хотуудын гамшигтай тэмцэх чадавхыг бий болгох, бэхжүүлэх зорилгоор НҮБ-ын гамшгийн эрсдэлийг бууруулах газраас “Аюулгүй, гамшигт тэсвэртэй хотыг бий болгох нь” санаачилгыг 2010-2020, 2020-2030 гэсэн хоёр үе шаттайгаар хэрэгжүүлж байгаа бөгөөд тус санаачилгад Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот, Эрдэнэт, Дархан хотууд 2016 онд, бусад аймгийн төвүүд 2018 онд нэгдэн орж, засаг захиргааны нэгжийн хувьд бүх хот нь тус санаачилгад нэгдсэн. Мөн 2022 онд “Аюулгүй, гамшигт тэсвэртэй хотыг бий болгох нь 2030” санаачилгын II үе шатанд Монгол Улсын 22 хот бүртгэлээ дахин баталгаажуулсан.

3.2. Дотоод хамтын ажиллагаа, түншлэл

“Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги”-д тусгагдсан ажил, арга хэмжээг бүх салбар, байгууллага, засаг захиргааны нэгжийн оролцоо, судалгаа эрдэм шинжилгээний байгууллага, хувийн хэвшил, олон нийтийн хамтын ажиллагааны дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэхээр тусгасан.

Иймд шийдвэр гаргах түвшинд гамшгийн эрсдэлийг бууруулах талуудын оролцоог нэмэгдүүлэх хүрээнд шинээр байгуулагдсан Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийн яам, агентлагаас гадна судалгаа эрдэм шинжилгээний байгууллагыг төлөөлж Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Стратегийн судалгааны хүрээлэн, Шинжлэх ухааны академи, иргэний нийгмийг төлөөлж Монголын Улаан загалмайн нийгэмлэг, хувийн хэвшил бизнесийн байгууллагыг төлөөлж Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын төлөөллийг багтаан оруулсан. Үндэсний зөвлөлийн ээлжит хуралдаанд талууд оролцож, хуралдаанаас гарах зөвлөмжид гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр өөрсдийн саналыг тусгаж ажиллаж байна.

Мөн түүнчлэн гамшгийн эрсдэлийг бууруулах төрийн зарим чиг үүргийг иргэний нийгэм, хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэх эрх зүйн зохицуулалтыг Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгад тусгасан. Үүний үр дүнд 2022 оны 12 дугаар сарын байдлаар Гамшгийн эрсдэлийн үнэлгээний мэргэжлийн

зөвлөлийн шийдвэрээр нийт 33 хуулийн этгээд гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл олгосон. Өмнө өгүүлсэн (2.1.1)-ээр эдгээр байгууллагууд 2019-2022 оны хугацаанд улсын хэмжээнд 398 аж ахуйн нэгж, байгууллагад гамшгийн нарийвчилсан үнэлгээ хийж, гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулан ажилласан нь сайшаалтай юм.

ОБЕГ нь гамшгаас хамгаалах чиглэлээр хамтран ажиллах дотоодын төрийн бус байгууллага, хуулийн этгээдүүдтэй санамж бичгийн хүрээнд хамтын ажиллагаатай ажиллаж байна. Үүний нэг нь Монголын Улаан загалмай нийгэмлэг юм. МУЗН нь гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед нэрвэгдэгсдэд анхны тусламж болон хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, өөрийгөө болон бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалах, өнгөрснөөс сургамж авч хойшдын үйл ажиллагааг оновчтой зохион байгуулахад иргэд, олон нийтийг сургаж дадлагажуулах, сургалт, сурталчилгаа зохион байгуулах гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгаас хамгаалах үйл ажиллагааны бэлэн байдлыг хангах чиглэлээр Онцгой байдлын байгууллагатай нягт хамтран, Монгол Улсад гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд өндөр хувь нэмэр оруулан ажиллаж байна.

3.3. Төсөл хөтөлбөр

Гамшгаас хамгаалах бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээ (2020)-ээр 2011-2020 оны хооронд буюу Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш ОБЕГ-т нийт 22 төсөл амжилттай хэрэгжсэн.

Төслийн чиглэл:

- гамшгаас хамгаалах удирдлага зохион байгуулалтын чиглэлээр 6,
- техник технологийн чадавхыг бэхжүүлэх чиглэлээр, гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр 11,
- хор уршгийг арилгах чиглэлээр 4,
- сэргээн босгохтой холбоотой чиглэлээр 1 төслийг хэрэгжүүлсэн.

Төслийн төрөл:

- судалгааны төсөл 12 хувь
- хөгжлийн төсөл 88 хувь


Санхүүжилт:

- дотоодын хөрөнгө оруулалттай: 14 хувь
- гадаадын хөрөнгө оруулалттай: 86 хувь

Байрлал: Төсөлд Улаанбаатар хот, 21 аймагт бүхэлдээ хамрагдсан. Үүнээс

- Улаанбаатарт 54 хувь
- хөдөө, орон нутагт 46 хувь нь хэрэгжсэн байна²⁸.

²⁸ Сэржмядаг,Д, Чимэдцэрэн,П, Гамшгаас хамгаалах бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээ, Гамшиг судлалын үндэсний хүрээлэн, 2021 он, х77.



Зураг 19 Монгол Улсын хэмжээнд гамшигаас хамгаалах чиглэлээр хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн хамрах хүрээ (байрлалаар)

2015-2022 онд Монгол Улсад гамшгийн эрсдэлийг бууруулах гадаадын хөрөнгө оруулалттай төсөл, хөтөлбөрийг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Ядуурлыг бууруулах Японы сан, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага, Швейцарийн хөгжлийн агентлаг, Азийн хөгжлийн банк, Америкийн хөгжил, хамтын ажиллагааны байгууллага, Дэлхийн зөн Монгол, Хүүхдийг ивээх сан, Мерси кор гэх мэт олон улсын байгууллага, Бүгд Найрамдах Польш Улс, Бүгд Найрамдах Беларусь Улс, Бүгд Найрамдах Франц Улс, Австри Улс гэх мэт олон улс орнуудтай хамтран хэрэгжүүлсэн.

Монгол Улсын гамшигаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх, эрсдэлийг бууруулах механизмыг боловсронгуй болгох хүрээнд гадаад улс орнууд, олон улсын байгууллагууд нь холбогдох төсөл, хөтөлбөрийг зээлийн болон буцалтгүй тусламж хэлбэрээр хэрэгжүүлж байгаа нь улсын болон орон нутгийн хэмжээнд гамшгийн эрсдэлийг бууруулах чадавхыг бэхжүүлэх, институцийн тогтолцоог бэхжүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулж байна.

4. СЕНДАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ БАРИМТ БИЧГИЙН ЗОРИЛТЫГ ХАНГАХАД ГАРСАН АХИЦ ДЭВШИЛ, ӨӨРЧЛӨЛТ

2016 онд Засгийн газар хоорондын мэргэжилтнүүдийн ажлын хэсэг Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийн дэлхийн зорилтын шалгуур үзүүлэлтийг боловсруулахад Монгол Улс өөрийн саналыг хүргүүлж хувь нэмрээ оруулан ажилласан. НҮБ-ын 71 дүгээр Ерөнхий Ассамблейгаас 2017 оны 02 дугаар 02-ны өдөр Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт батлагдсан юм.

Тус шалгуур үзүүлэлтийн дагуу ОБЕГ боломжит дата мэдээллийг холбогдох яам агентлагийн дэмжлэгтэйгээр бэлтгэж, НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах газрын Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийн явцын хяналтын цахим системд жил бүр тайлагнаж ирсэн.


Энэ цахим системд оруулсан гамшгийн дата мэдээлэл нь Тогтвортой хөгжлийн зорилго (SDG)-ын холбогдох зарим шалгуур үзүүлэлтийн хэрэгжилттэй шууд холбогдоно.

Тайлбар, учирч буй хүндрэл:

Зорилт “А”, “В”, “D”-ын шалгуур үзүүлэлтийг Монгол Улсад бүртгэгдсэн гамшгийг тодорхойлох шалгуур үзүүлэлтэд хүрсэн, хүрээгүй том, жижиг бүх аюулт үзэгдэл, ослын мэдээлэл, түүнээс учирсан хохирлын дата мэдээлэлд суурилан тайлагнаж байна. Аюул үзэгдэл, ослын улмаас амь насаа алдсан хүний мэдээллийг орлогын байдлаар гаргах боломжгүй байна. Цаашид Монгол Улсын Шадар сайдын 2020 оны 22 дугаар тушаалаар батлагдсан гамшиг, аюулт үзэгдэл, ослын бүртгэлийн маягт, зааврын дагуу мэдээлэл цуглуулах, боловсруулах шаардлагатай. Үүний талаар энэхүү тайлангийн 2.1.2 дахь хэсэгт өгүүлсэн.

КОВИД-19 цар тахлын дата мэдээг оролцуулсан байдлаар

Монгол Улсын хэмжээнд 2015-2021 онд тохиолдсон гамшиг, аюулт үзэгдэл, ослын улмаас нийт 3501 хүн нас барж, 693223 хүн бэртэж гэмтэж, өвчилсөн байна. 2005-2014 оны дундажтай харьцуулахад амь насаа алдсан хүний тоо 41 хувь, гэмтэж бэртсэн, өвчилсөн хүний тоо 99 хувиар тус тус өссөн байна (Зураг 20).



Зураг 20. Амь насаа алдсан хүний тоо (2005-2014, 2015-2021 оны дунджаар)

Дээрх тоог 100.000 хүн амд ногдох байдлаар авч үзэхэд амь насаа алдсан хүний тоо 2005-2014 онд дунджаар 7.7 байсан бол 2015-2021 онд 15.1, бэртэж гэмтэж, өвчилсөн хүний тоо 2005-2014 онд 281.78 байсан бол 2015-2021 онд 3160.2 болж тус тус нэмэгдсэн байна (**Хавсралт 7**).

КОВИД-19 цар тахлын үед боловсролын үйлчилгээ, эрүүл мэндийн үйлчилгээ, зам тээврийн үйлчилгээнд тасалдал гарсан.

КОВИД-19 цар тахлын дата мэдээг оролцуулахгүйгээр

2015-2021 онд тохиолдсон гамшиг, аюулт үзэгдэл, ослын улмаас нийт 1514 хүн нас барж, 1876 гаруй хүн бэртэж гэмтсэн байна. 2005-2014 оны дундажтай харьцуулахад амь насаа алдсан хүний тоо 4,6 хувиар нэмэгдэж, гэмтэж бэртсэн, өвчилсөн хүний тоо 63.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна (**Хавсралт 8**).

Зорилт “С” тайлагнахдаа Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас ирүүлсэн гамшгийн улмаас хөдөө аж ахуйд үүссэн шууд хохирлын мэдээллийг оруулдаг. Бусад шалгуур үзүүлэлтийн мэдээллийг гаргах боломж хомс байна.

ОБЕГ сар бүр аюул үзэгдэл, осол, учирсан шууд хохирлын мэдээг ҮСХ-д хүргүүлдэг. Гамшгийн улмаас учирсан эдийн засгийн шууд хохирлын дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-д эзлэх хувийг Үндэсний статистикийн газар (ҮСХ)-аас тооцон гаргадаг болно.

2020 онд дууссан **Зорилт “Е”-г** Монгол Улс бүрэн биелүүлсэн. Үндэсний түвшинд Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний стратегийг 2017 онд, орон нутгийн түвшинд бүх аймаг Гамшгаас хамгаалах төлөвлөгөөгөө 2018-2020 онд шинэчлэн батлуулан хэрэгжүүлж байна. Үүний талаар энэхүү тайлангийн 2.2 дахь хэсэгт өгүүлсэн.

Зорилт “F” хүрээнд энэхүү тайланд гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр олон улсын байгууллага, гадаад улс орноос Онцгой байдлын байгууллагад хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр, түншлэл хамтын ажиллагааны талаар тусгасан.

Зорилт “G”-ийн хүрээнд Монгол Улс гамшгийн зарлан мэдээлэл, эрт сэрэмжлүүлэх хүрээнд иргэд олон нийтэд телевизийн 2 суваг, 6 фм, радио, Улаанбаатар хотын 9 дүүрэгт 50 зарлан мэдээллийн цамхаг болон масс мессэж, албан ёсны цахим хаяг, фэйсбүүк хуудсаар мэдээллийг хүргэж байна.

5. НӨХЦӨЛ БАЙДЛЫН ӨӨРЧЛӨЛТ, ШИНЭ БОЛОН ДАХИН СЭРГЭЖ БУЙ АСУУДАЛ, ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛ

5.1. Уур амьсгалын өөрчлөлт ба гэнэтийн аюулт үзэгдэл

Евразийн эх газрын төвд сэрүүн уур амьсгалын бүсэд орших далайд гарцгүй Монгол улсын хувьд уур амьсгалын хувьсал, өөрчлөлт мэдэгдэхүйц илэрч үүний нөлөөгөөр сүүлийн тавиад жилд Монгол оронд бэлчээр доройтон цөлжих үйл явц идэвхжих, ургамлын зүйлийн бүрдэл цөөрөх, зэрлэг ан амьтдын тархацын бүс хумигдах, тоо толгой нь хорогдох, ой, хээрийн түймрийн давтагдал нэмэгдэх, тал хээрийн бүсэд усны нөөц хомсдох зэргээр байгаль орчны доройтол явагдаж байгаагийн зэрэгцээ уур амьсгалын гамшигт үзэгдэл, түүний дотор ган, зудын давтамж ойртож, эрч хүч нь нэмэгдэж байна²⁹.

1940 оноос хойш Монгол орны нутаг дэвсгэр дээрх жилийн дундаж агаарын температур 2.14°C-аар дулаарчээ. Монгол орны уур амьсгалын өөрчлөлт (УАӨ)-ийн нөхцөл, төлөвийн тухай мэдээлэлийг дэлгэрэнгүйгээр “Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад Монгол Улсын оруулах хувь нэмэр” тайлан (http://www.jcm-mongolia.com/wp-content/uploads/2015/10/INDC_Full-Document_MON_2016.pdf)-аас үзэж болно.

УАӨ-ийн өнөөгийн болон ирээдүйн нөлөөллийн үнэлгээний үр дүнг үндэслэн Монгол орны ус, ойн нөөц, бэлчээр хөрс тэдгээрийн экосистем, нийгэм-эдийн засгийн салбараас хамгийн их өртөх магадлалтай нь мал аж ахуй, газар тариалан, хүний эрүүл мэнд, гамшгаас хамгаалах зэргийг тогтоосон³⁰.

Энэ нь манай орны хувьд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллөөс үүдсэн гамшгийн эрсдэлийг бууруулах, дасан зохицох шаардлага маш чухлаар тавигдах шаардлагатайг харуулна.

Монгол орон дахь УАӨ-ийн нөлөөлөл, түүнээс үүдсэн гамшгийн эрсдэл, эмзэг байдлын өөрчлөлтийг *Хүснэгт 17-д* харуулав. Хүснэгтээс харахад монгол орны нутаг дэвсгэрт уур амьсгалын өөрчлөлт нэгэнт явагдаад эхэлчихсэн байгаа бөгөөд манай орны нутаг дэвсгэрт тохиолддог байгалийн аюулт үзэгдлийн 80 гаруй хувьд /геологийн гаралтай аюулт үзэгдлээс бусад/ нь нөлөөлж, эдгээрээс байгаль, нийгмийн тогтолцоонд сөрөг нөлөөллүүд бий болох нь тодорхой байна. Иймээс уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох, гамшгийн эрсдэлийг бууруулах асуудлыг улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, стратегийн баримт бичигтэй зайлшгүй уялдуулж авч үзэх шаардлага урган гарч байна.

²⁹ БОАЖЯ, Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад Монгол Улсын оруулах хувь нэмэр, 2015, УБ, х.14 http://www.jcm-mongolia.com/wp-content/uploads/2015/10/INDC_Full-Document_MON_2016.pdf

³⁰ БОАЖЯ, Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад Монгол Улсын оруулах хувь нэмэр, 2015, УБ, х.18

Хүснэгт 16 Монгол орон дахь УАӨ-ийн нөлөөлөл, түүнээс үүдсэн гамшигийн эрсдэл, эмзэг байдлын өөрчлөлт

Эрсдэлд хүргэж буй УАӨ-тэй холбоотой үзүүлэлтүүд	Өнөөгийн байдлаар гарсан гол өөрчлөлтүүд	Хамаарах гамшигийн эрсдэл	Цаашид гарах нөлөөлөл, эмзэг байдал
-Дулаан улирлын температур нэмэгдэж, ууршилт ихсэж, хур тунадас буурсан, -Халуун өдрийн тоо нэмэгдэж, үргэлжлэх хугацаа уртассан, -Өвлийн улирлын хур тунадасны хэмжээ нэмэгдэх, -Гангийн давтагдал, эрчим нэмэгдсэн, хуурайшилтай үеийн үргэлжлэх хугацаа уртассан.	-Бэлчээрийн 90 гаруй хувь нь ямар нэг өөрчлөлтөд орсон, -Монгол улсын нутаг дэвсгэрийн 77.8% нь ямар нэг хэмжээгээр цөлжиж доройтсон. -Ган, зудын давтагдал нэмэгдэх хандлагатай ба хамгийн эрчимтэй нь 2002/2003, 2009/2010 онд тохиож, ДНБ-ийг 6%-аас дээш бууруулсан -Ган, зудаас хамаарах том малын зүй бус хорогдол оны эхний малын тоотой харьцуулахад 2% ба энэ утга 1991-2011 оны хооронд жилд 0.25% нэмэгдэж байна.	Ган, зуд, цөлжилт	-бэлчээрийн ургамлын ургац байгалийн бүх бүсэд одоогийнхоос 10-40%-иар буурах, муудах, -Өвлийн улирлын цасны хэмжээ 40-50% нэмэгдэх -Ган, зудаас хамаарах малын зүй бус хорогдол 2050-аад оны үед 9.4% болж нэмэгдэх,
-Дулаан улирлын хур борооны хэмжээ буурч, ууршилт ихэссэн, -Хуурайшилтай үе, гангийн эрчим нэмэгдэж, үргэлжлэх хугацаа уртассан, -Хөрсний гүний температур нэмэгдсэн, -Өндөр уулын бүсийн уур амьсгал дулаарч байна.	-Ойгоор бүрхэгдсэн талбай 1999-2012 онд 4.1%-иар хорогдсон, -Ойн түймрийн давтагдал ихсэж, 1999-2012 онд шатсан талбай 13.3%-иар нэмэгдсэн, -Ойн хортон, хөнөөлт шавьжийн тархалт нэмэгдэж байна.	Ой, хээрийн түймэр Хортон шавьж тархах	-Ойн хөнөөлт, шавьжид өртөх талбай 2050 оны түвшинд 1.4-13 дахин нэмэгдэх магадлалтай, -Ойн түймэрт өртөх талбай 2030 оны үед 512 мян. га-аар нэмэгдэх
-Конвекцийн гаралтай үзэгдлийн эрч хүч нэмэгдсэн, -Орчил урсгалын аномаль нөхцөлийн тохиолдол олширсон. -Хур борооны эрчим нэмэгдсэн.	-Гамшигт үзэгдлийн давтагдлыг сүүлийн 2 арван жилд хувааж харьцуулахад эхний арван жилд 75 орчим гамшигт үзэгдэл ажиглагддаг байсан бол дараагийн 10 жилд энэ тоо даруй 2 дахин нэмэгдсэн, -Богино хугацаанд үргэлжлэх аадар бороо, уруйн үер, нөөлөг салхи, мөндөр, аянга цахилгаан зэрэг үзэгдлийн давтагдал эрчимтэй нэмэгдэж нийгэм эдийн засагт учруулах хохирол 2 дахин нэмэгдсэн, -	Салхи шуурга, Үер, Аадар бороо, аянга	-Агаар мандлын гаралтай аюулт үзэгдлийн давтагдал энэ зууны дунд үе гэхэд одоогийнхоос 23-60%-иар нэмэгдэх, -Аюулт үзэгдлийн эрчим, давтамж ихэссэнээр дэд бүтэц, барилга байгууламж эвдэгдэх
-Дулаан улирлын температур нэмэгдэж ууршилт ихсэж, хур тунадас буурсан, -Хэт халуун, дулааны долгионы үргэлжлэх хугацаа уртассан.	-Сүүлийн жилүүдэд малын шинэ өвчин 26, дахин сэргэж байгаа 8, хүрээгээ тэлж байгаа 6 өвчин тогтоогдсон.	Хүн, малын халдварт өвчин	-Дамжуулагчийн орчны өөрчлөлтөөр дамжих халдварт өвчний тоо олшрох.

Эх сурвалж: БОАЖЯ, УАӨ-ийн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээний хураангуйд үндэслэн боловсруулав.

*Хүснэгт 17 Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, гамшгийн эрсдэлийг бууруулах асуудал
үндэсний хөгжлийн бодлогын баримт бичигт туссан байдал*

Хөгжлийн баримт бичиг	Зорилго	Зорилт	Арга хэмжээ	Хугацаа
<p align="center">“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого 2020</p>	<p>Зорилго 6. Байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийг эрхэмлэн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, байгаль орчны тогтвортой байдлыг ханган үр өгөөжийг нь өнөө болон ирээдүй хойч үе хүртэх нөхцөлийг бүрдүүлж, хүний амьдралын чанарыг сайжруулна.</p>	<p>Зорилт 6.4. Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон эдийн засгийг хөгжүүлж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах олон улсын хүчин чармайлтад хувь нэмэр оруулна.</p>	<p>3.Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, тэсвэрлэх чадавхыг бэхжүүлж, үүсэж болзошгүй эрсдэлийг бууруулна.</p> <p>3.Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй сөрөг үр дагаврыг багасгах, гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний хөтөлбөрийг шинэчилж хэрэгжүүлнэ.</p>	<p align="center">2021-2030</p> <p align="center">2031-2050</p>
	<p>Зорилго 9. Амьдрахад таатай, байгаль орчинд ээлтэй, хүн төвтэй ухаалаг хот болгон хөгжүүлнэ</p>	<p>Зорилт 9.2. Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж, экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан, хүлэмжийн хийн ялгарал багатай ногоон технологи бүхий амьдралын таатай орчинтой хот болно.</p>	<p>6.Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг даван туулах, гамшгийг эрт илрүүлэх, тэсвэрлэн гарах чадавхыг бэхжүүлнэ.</p>	<p align="center">2021-2030</p>

Эх сурвалж: Гамшигаас хамгаалах бодлого, стратеги 2021

Өнөөгийн байдлаар манай улсад УАӨ, гамшгийн эрсдэлийг бууруулахтай холбоотой асуудал үндэсний хөгжлийн бодлогын баримт бичигт тодорхой хэмжээнд тусгалаа олжээ. УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого”-д уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, гамшгийн эрсдэлийг бууруулахтай холбоотой зорилт, арга хэмжээ дараах байдлаар тусчээ (*Хүснэгт 17*).

УАӨ-д дасан зохицох арга хэмжээ нь эмзэг салбаруудын өртөх байдал, эрсдэлийг бууруулж, дасан зохицох чадавхыг дээшлүүлэх ёстой. Энэ утгаараа энэ баримт бичигт УАӨ-д дасан зохицох замаар гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгийг даван туулах чадавхыг бэхжүүлэх асуудал томоохон байр суурь эзэлж байна.

Манай орны хувьд уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой шийдвэрлэвэл зохих олон асуудал байгаа боловч гамшгаас хамгаалах салбарын хувьд уур амьсгалын өөрчлөлтийн хүн ам, эд хөрөнгө, хүрээлэн буй орчин, эдийн засагт үзүүлэх таагүй сөрөг үр дагаврыг байж болох хамгийн бага хэмжээнд барих, учруулж болох хор хохирлыг урьдчилан таамаглах, эрсдэлийг бууруулах, нэгэнт өөрчлөгдөж байгаа уур амьсгалын нөхцөлд улс орны нийгэм, эдийн засгийн үйл ажиллагаагаа зохицуулан зохион байгуулах, улмаар тогтвортой хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хангах явдал тэргүүн зэргийн ач холбогдолтой байх болно.

5.2. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын нөхцөл байдал, хариу арга хэмжээ

Дэлхий дахинд тархаад буй КОВИД-19 халдварын цар тахал нь бидний өнөөгийн нүүр тулж буй гамшиг, аюулт үзэгдэл ослын эрсдэлийг бууруулахад авч хэрэгжүүлж буй арга хэмжээг үр дүнтэй авч хэрэгжүүлэхэд томоохон хүндрэл учруулсан төдийгүй, нийгэм-эдийн засаг, хүн амын аюулгүй байдалд аюул учруулж, урьд өмнө тулгарч байгаагүй олон сорилтыг авчирсан.

Манай улсын хувьд тус халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, халдварыг хумих зорилгоор “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль”-ийг Улсын Их Хурлаар Хурлаас 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр яаралтай горимоор хэлэлцэн баталсан. Тус хуулийг амжилттай хэрэгжүүлж, хуулийн хүчинтэй хугацаа 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болсон.

Тус хуулийн хэрэгжилтийг хангах, цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, халдварын тархалтыг хумих, нийгэм, эдийн засгийн сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр олон тооны эрх зүйн баримт бичгийг хэрэгжүүлсэн³¹. Үүнд:

- | | |
|--|----|
| • Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг | 1 |
| • Монгол Улсын Хурлын тогтоол | 1 |
| • Монгол Улсын Засгийн газраас тогтоол | 51 |


³¹ Монгол Улсын Засгийн газар, УОК-оос Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, халдварын тархалтыг бууруулах чиглэлээр гаргасан шийдвэр, холбогдох эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл, 2022

- УОК-ын тогтоол 18
- УОК-ын албан даалгавар 9
- УОК-ын даргын болон Шадар сайдын тушаал 29

Удирдлага, зохион байгуулалтын хувьд КОВИД-19 цар тахлын хор уршгийг арилгах ажиллагааг Улсын онцгой комисс удирдан явуулсан бөгөөд Гамшгаас хамгаалах улсын төлөвлөгөө (Засгийн газрын 2015 оны 416 дугаар тогтоол)-ний дагуу Эрүүл мэндийн яам хариуцан ажилласан. Мөн УОК-ын даргын шийдвэрээр салбар бүрийн төлөөллөөс бүрдсэн шуурхай штабыг байгуулж ажилласан. Тухайн штабын бүрэлдэхүүн нөхцөл байдлаас шалтгаалан хэд хэдэн удаа солигдсон, сүүлийнх нь УОК-ын даргын 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 58 дугаар тушаалаар байгуулагдсан “Нэгдсэн шуурхай штаб” юм. Тус штабын даргаар ОБЕГ-ын дэд дарга томилогдон ажилласан.

КОВИД-19 цар тахлын хариу арга хэмжээг үнэн бодит мэдээлэл, үнэлгээнд үндэслэн төлөвлөж, үр дүнтэй авч хэрэгжүүлэх зорилгоор Шадар сайдын 2017 оны 08 дугаар тушаалаар батлагдсан “Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн салбар хоорондын мэдээлэл солилцох, хариу арга хэмжээ авах журам”-ын хүрээнд салбар дундын эрсдэлийн үнэлгээг 2020-2022 оны 1 дүгээр сар хүртэлх хугацаанд нийт 27 удаа хийж тухай бүр зөвлөмж гаргаж ажилласан.

КОВИД-19 цар тахлын эсрэг дархлаажуулалтад улсын хэмжээнд иргэд идэвхтэй сайн хамрагдсан. 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн байдлаар зорилтот бүлгийн 1-р тунгийн хамралт 89.6 хувь, 2-р тунгийн хамралт 85.7 хувь, 3-р тунгийн хамралт 53,6 хувь, нийт хүн амын 1-р тун 68,9 хувь, 2-р тун 65,9 хувь, 3-р тун 31,9 хувь тус тус хамралттай байна. Улсын хэмжээнд КОВИД-19-ын эсрэг вакцинд хамрагдсан хүний тоо, насны бүлэг, хүйсийн мэдээллийг *Зураг 17-д* үзүүлэв.



Зураг 21 Улсын хэмжээнд ковид-19-ын эсрэг вакцинд хамрагдсан хүний тоо, насны бүлэг, хүйсээр (2022.10.14-ний байдлаар)
Эх сурвалж: ЭМЯ

КОВИД-19 цар тахалтай тэмцсэн үйл ажиллагаа нь бидэнд олон сургамж өгсөн. Онцолбол,

- гамшгийн үед салбар дундын зохицуулалт, чиг үүргийг илүү тодорхой болгох,
- гамшгаас хамгаалах орон нутаг, албадын төлөвлөгөөг дахин тодотгох, илүү нарийвчилсан байх, дадлага сургууль зохион байгуулж турших,
- эрсдэлийг тооцоолох, эрдэмтэд судлаачдын оролцоог сайн хангах,
- эрсдэлийн харилцаа холбоог ойлгомжтой тодорхой болгох,
- гамшгийн нөөцийн нэр төрлийн жагсаалтад хүний гоц халдварт өвчний үед хэрэглэх бүтээгдэхүүнийг нэмж оруулах,
- улсын албад өөрсдийн нөөцийг бий болгох,
- гамшгийн хор уршгийг арилгах ажиллагаанд хүний эрхийг хамгаалах, хүүхдийн эрхийг дээдлэх, жендэрт суурилсан хүчирхийлэлтээс сэргийлэх, гамшгийн хор уршгийг арилгах ажиллагаанд оролцогчийн аюулгүй байдлыг хамгаалах, гамшгийн сэтгэлзүйн асуудлыг орхигдуулахгүй байх,
- гамшгийн аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, өөрийгөө хамгаалах ойлголт, мэдлэгийг иргэд олон нийтэд олгох,
- Аж ахуйн нэгж, байгууллага гамшгийн үед бизнесийн тасралтгүй үйл ажиллагааны төлөвлөгөөтэй байх.

КОВИД-19 цар тахалтай тэмцэхэд Монгол Улсын иргэд, олон нийт, Засгийн газар, УОК, Онцгой байдлын байгууллага, Эрүүл мэндийн яам болон бусад мэргэжлийн төрийн, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, аж ахуйн нэгж байгууллага хичээл зүтгэл гаргаж ажилласныг энэхүү дунд хугацааны тайланд онцгойлон дурдъя.

Тус цар тахлаас үүссэн хохирлыг арилгах, эдийн засгаа сэргээх хүрээнд “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг батлан 2022 оноос эхлэн хэрэгжүүлж эхлээд байна. Цар тахлын үеийн эдийн засгийг сэргээх “Шинэ сэргэлтийн бодлого” нь дараах үйл ажиллагаанд чиглэсэн 10 хүртэлх жилийн хугацаанд хэрэгжих дунд хугацааны зорилтот хөтөлбөр юм. Үүнд:

- Монгол Улсын эдийн засгийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлэх,
- КОВИД-19 цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах,
- хөгжлийг хязгаарлагч хүчин зүйлийг цаг алдалгүй шийдвэрлэх,
- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх,
- эдийн засаг, дэд бүтэц болон төрийн бүтээмжийг сайжруулах зэрэг болно.

6. ДҮГНЭЛТ

Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийг Монгол Улсад хэрэгжүүлэхэд гарсан ололт амжилт, авсан сургамж, туршлага, учирч буй хүндрэл бэрхшээлийн талаар энэхүү тайланд тусгалаа.

Мөн 2030 он гэхэд Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичигт дэвшүүлсэн зорилго, зорилтыг хангахын тулд нэн тэргүүнд анхаарах асуудлыг Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийн 4 тэргүүлэх чиглэлийн хүрээнд дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

Гамшгийн эрсдэлийн үнэлгээ, мэдээлэл, ойлголтыг нэмэгдүүлэх хүрээнд

- Иргэд, олон нийтийг гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ, гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгааны ажилд оролцуулах, гамшгаас хамгаалах уламжлал мэдлэг ойлголтыг түгээх замаар гамшгийн эрсдэлийг бууруулах мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, гамшгийн эрсдэлийг бууруулахад хэнийг ч орхигдуулахгүй хамруулах. Иргэд олон нийтийн гамшгийн бэлэн байдлын чиглэлээр судалгааны ажлыг өргөтгөх.
- Эрсдэлийн мэдээлэлд суурилсан шийдвэр гаргах, төлөвлөх, санхүүжүүлэх, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгаас учирч болзошгүй хохирлыг бууруулахад гамшгийн эрсдэлийн үнэлгээний үр дүнг чиглүүлэх,
- Гамшгийн ангилсан дата мэдээлэл боловсруулах, түүний ач холбогдлын талаар оролцогч талуудын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх,
- Гамшгийн мэдээллийг боловсруулахад дэвшилтэт технологи нэвтрүүлэх, мэдээллийг иргэд олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй хүргэх.
- Гамшгийн эрсдэлийн мэдээллийн санг хөгжүүлэх, гамшгийн төрөл бүрээр хийгдэж буй үндэсний хэмжээний аюулын зураглалыг дуусгах.

Гамшгийн эрсдэлийг бууруулах засаглал, удирдлага, зохион байгуулалтын хүрээнд

- Олон улсын болон үндэсний хэмжээнд авсан сургамж, ололт амжилтад тулгуурлан гамшгийн эрсдэлийг бууруулах засаглалыг бэхжүүлэх,
- КОВИД-19 цар тахлын дараах сургамжид үндэслэн гамшгаас хамгаалах эрх зүйн баримт бичигт шинэчлэл хийх,
- Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний болон орон нутгийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг олон улс, бүс нутаг, үндэсний болон орон нутгийн гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд оролцох оролцоог нэмэгдүүлэх,
- Хот суурин газрын гамшгийн эрсдэлийг бууруулах асуудлыг системийн түвшинд авч үзэж, хот төлөвлөлтийн бодлого, үйл ажиллагаанд тусгах.

Гамшгийг тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтын хүрээнд

- Гамшгийн эрсдэлийг бууруулах санхүүжилтийн стратеги боловсруулан хэрэгжүүлэх,
- Гамшгийн болзошгүй хохирлыг бууруулахын тулд гамшгийн эрсдэлийг бууруулах улсын болон орон нутгийн төсвийн хэмжээг нэмэгдүүлэх,
- Гамшгийн эрсдэлийг шилжүүлэх чиглэлээр гамшгийн эрсдэлийн даатгалын хуулийн төсөл боловсруулах.


Гамшгийн бэлэн байдал, хор уршгийг арилгах, сайжруулан сэргээн босгох ажиллагааны хүрээнд

- Гамшгийн үед үр дүнтэй, шуурхай хариу арга хэмжээ авахын тулд Гамшгийн шуурхай удирдлагын төвийг байгуулах, техник тоног төхөөрөмжөөр хангах,
- Гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөг бүх шатанд сайжруулах, төлөвлөгөөний дагуу дадлага сургуулилт хийх,
- КОВИД-19 цар тахлын дараах сургамжид үндэслэн төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах, гамшгийн үед бизнесийн тасралтгүй ажиллагааны төлөвлөлт хийхэд хамтран ажиллах,
- Гамшиг, аюулт үзэгдэл, ослын дараа барилга байгууламж, дэд бүтцийн гамшигт тэсвэртэй байдал, бодлого төлөвлөлтийн оновчтой байдал, хүн амын гамшгийн бэлэн байдалд хяналт хийж, сайжруулан барьж байгуулах,
- Гамшгийн үеийн нүүлгэн шилжүүлэх түр байрны зохион байгуулалтыг сайжруулах,
- Эрт зарлан мэдээллийн системийн өнөөгийн байдлыг сайжруулах, хүн бүр гамшгийн эрт зарлан мэдээлэл хүлээн авах нөхцөлийг хангах.
- Улаанбаатар хот дахь хуучин нисэх буудал “Буянт-Ухаа”-д Зүүн хойд Азийн хүмүүнлэгийн тусламжийн төвийг байгуулах.

---oOo---


Хавсралт 1-и. Ангиллын сургалт (2020-2022)

2020-2022 онд зохион байгуулсан ангиллын сургалтын тоо





	Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль	Команд штабын сургууль	Удирдах албан тушаалтны сургалт	ИДС. МСҮТ. Коллеж оюутан. Сурагч	ЕБС ахлах	ЕБС дунд	ЕБС бага	СӨБ	Төрийн болон нутгийн захиргаа. Хуулийн этгээд. Ажилтан	ГХА. Мэргэжлийн анги	Иргэний	Цэргийн дүйцүүлэх албаны	Сайн дурын бүлэг. Хэсэг	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн
■ 2022 он жил	45	57	327	262	457	507	231	363	2654	566	651	20	184	24
■ 2021 он жил	16	34	353	273	207	159	147	110	2723	440	534	31	156	26
■ 2020 он жил	15	24	228	118	206	230	187	118	1738	592	449	28	125	35

2020-2022 онд ангиллын сургалтад хамрагдсан хүний тоо




	Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль	Команд штабын сургууль	Удирдах албан тушаалтны сургалт	ИДС. МСҮТ. Коллеж	ЕБС ахлах	ЕБС дунд	ЕБС бага	СӨБ	Төрийн болон нутгийн зах. Хуулийн этгээд	ГХА. Мэр анги	Иргэний	Цэргийн дүйцүүлэх алба	Сайн дурын бүлэг. Хэсэг	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд
■ 2022 он жил	81022	9704	9995	11769	29586	26030	15600	13100	78587	23302	40173	543	3609	602
■ 2021 он жил	3123	3305	7594	7877	10714	5437	5977	3113	65006	14059	16478	579	2115	463
■ 2020 он жил	9587	3860	8148	10550	18961	20156	16919	4617	43379	23915	47635	659	2807	473

Хавсралт 1-ii. Ангиллын сургалт (2015-2018)




2020-2022 онд ангиллын сургалтад хамрагдсан хүний тоо



	Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль	Команд штабын сургууль	Удирдах тушаалтны сургалт	ИДС. МСҮТ. Коллеж	ЕБС ахлах	ЕБС дунд	ЕБС бага	СӨБ	Төрийн болон нутгийн зах. Хуулийн этгээд	ГХА. Мэр анги	Иргэний	Цэргийн дүйцүүлэх алба	Сайн дурын бүлэг. Хэсэг	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд
■ 2022 он жил	81022	9704	9995	11769	29586	26030	15600	13100	78587	23302	40173	543	3609	602
■ 2021 он жил	3123	3305	7594	7877	10714	5437	5977	3113	65006	14059	16478	579	2115	463
■ 2020 он жил	9587	3860	8148	10550	18961	20156	16919	4617	43379	23915	47635	659	2807	473

Хавсралт 2. Нийслэлийн Гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төвийн сургалтын танхим

<p>Өндрөөс аврах ажиллагааны танхим</p> 	<p>Байр</p> 
<p>Бага насны хүүхдийн танхим</p> 	<p>3D дүрс, хурлын танхим</p> 
<p>Гал унтраах танхим</p> 	<p>Явуулын сургалт</p> 
<p>Газар хөдлөлтийн чичирхийллийг мэдрүүлэх тавцан</p> 	<p>Газар хөдлөлтийн танхим</p> 
<p>Эмнэлгийн анхны тусламжийн танхим</p> 	<p>Утаат орчноос өөрийгөө болон бусдыг аврах дадлагын танхим</p> 

Эх сурвалж: Гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төв, <http://gamshgiinsurgalt.nema.gov.mn>

Хавсралт 3.

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ СЕНДАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭГ МОНГОЛ УЛСАД ХЭРЭГЖҮҮЛЭХ ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ (ЗГ-ын 2017 оны 355 дугаар тогтоол)

Зорилго: Гамшгийн аюул, ертөнгө, эмзэг байдлыг бууруулах, гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, гамшгийн хор уршгийг арилгах, сэргээн босгох үйл ажиллагааг сайжруулж, гамшигтай тэмцэх чадавхыг бэхжүүлэх замаар гамшгийн эрсдэлийг бууруулж, шинэ эрсдэл үүсэхээс сэргийлэхэд энэхүү стратегийн зорилго оршино.				
Тэргүүлэх чиглэл	1. Гамшгийн эрсдэлийг бууруулах бүх нийтийн ойлголтыг гүнзгийрүүлэх, мэдлэг олгох;	2. Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны удирдлагын засаглалыг бэхжүүлэх;	3. Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;	4. Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах, гамшгийн дараах сэргээн босгох, нөхөн сэргээх, шинээр барьж байгуулах үйл ажиллагааг урт хугацаанд төлөвлөн хэрэгжүүлэх.
Зорилт 1	Гамшгийн эрсдэлийг бууруулах талаар иргэд, олон нийтийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх;	Гамшгийн эрсдэлийг бууруулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох;	Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд орчин үеийн дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх;	Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг дээшлүүлж, хүч хэрэгслийн чадавхыг нэмэгдүүлэх;
Үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> ▪ Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх ойлголт, мэдлэгийг олгох сургалтыг зохион байгуулах, сургалт, арга зүйн төвийг байгуулан үйл ажиллагааг бэхжүүлэх; ▪ Монгол Улсын гамшгийн нөхцөл байдлын тайланг жил бүр гаргаж нийтэд мэдээлэх; ▪ “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ 2015-2030”-г хэрэгжүүлэх суурь үзүүлэлтийг тодорхойлох нөхцөл байдлын болон хэрэгжилтийн явцын тайланг тус тус боловсруулах. 	<ul style="list-style-type: none"> ▪ Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг хариуцах үндэсний болон орон нутгийн зөвлөл байгуулах; ▪ Гамшгийн эрсдэлийг бууруулах асуудлыг салбарын бодлогын баримт бичигт тусгаж хэрэгжүүлэх. 	<ul style="list-style-type: none"> ▪ Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр судалгаа хийж, гамшгийг хохирол багатай даван туулах, хохирлын хэмжээг багасгахад чиглэсэн орчин үеийн дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх; ▪ Барилга байгууламжийн хийц, бүтээц, материал, түүхий эдийн чанарыг тодорхойлох, туршилт, шинжилгээ, судалгаа хийх чадавхыг сайжруулах; ▪ Төв, суурин газрын хүн амыг үерийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх бүтцийн арга хэмжээг хэрэгжүүлэх. 	<ul style="list-style-type: none"> ▪ Гамшгаас хамгаалах хүч хэрэгслийн бэлэн байдлыг хангах шалгуур үзүүлэлтийг батлах; ▪ Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог дэмжих;
Зорилт 2	Гамшгийн эрсдэлийг үнэлэх тогтолцоог бий болгож, мэдээллийн сан бүрдүүлэх.	Гамшгийн эрсдэлийг бууруулахад түншлэл, хамтын ажиллагааг бэхжүүлэх;	Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх.	Гамшгийн дараах сэргээн босгох, нөхөн сэргээх, шинээр барьж байгуулах үйл ажиллагааг сайжруулах.

<p>Үйл ажиллагаа</p>	<ul style="list-style-type: none"> Байгалийн болон хүний хүчин зүйл, техникийн гаралтай гамшгийн төрөл тус бүрээр эрсдэлийн үнэлгээ хийх; Гамшгийн мэдээллийн нэгдсэн сан бий болгож хөгжүүлэх. 	<ul style="list-style-type: none"> Аюулгүй, гамшгийг даван туулах чадавхтай хот” олон улсын санаачилгыг дэмжих, өрнүүлэх; Гамшгийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх. 	<ul style="list-style-type: none"> Гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд шаардагдах улсын төсвийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх; Хувийн хэвшлийн байгууллагын гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг нэмэгдүүлэх талаар судалж хэрэгжүүлэх; Гамшгийн эрсдэлээс хамгаалах даатгалын тогтолцоог бий болгох нөхцөлийг бүрдүүлэх. 	<ul style="list-style-type: none"> Гамшгийн эрсдэлийг тооцсоны үндсэн дээр гамшгийн дараах сэргээн босгох үйл ажиллагааг хөгжлийн бодлого, төлөвлөлтөд тусган хэрэгжүүлэх; Барилга байгууламжийг гамшгийн аюул, газар хөдлөлтөд тэсвэртэй байхаар хүчитгэх, сайжруулах, ашиглалтын шаардалага хангахгүй болсон сургууль, цэцэрлэг, эмнэлэг, орон сууц, нийтийн зориулалттай барилга байгууламжийг буулгаж, шинээр барих үйл ажиллагааг урт хугацаанд төлөвлөн хэрэгжүүлэх.
<p>Зорилт 3</p>		<p>Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр үндэсний стандартыг боловсронгуй болгох.</p>		
<p>Үйл ажиллагаа</p>		<ul style="list-style-type: none"> Гал түймэр унтраах, аврах ангийн үйлчлэх хүрээний стандартыг боловсруулж хэрэгжүүлэх; Эрэн хайх, аврах анги, салбар, тэдгээрийн алба хаагчдын ашиглах технк, тоног төхөөрөмж, хамгаалах хувцас, хэрэгслийн стандартыг боловсруулах. 		
<p>Хүрэх үр дүн</p>	<ul style="list-style-type: none"> Гамшгийн эрсдэлийг бууруулах талаар иргэд, олон нийт, төрийн албан хаагчдын ойлголт, мэдлэг нэмэгдсэн байна; Монгол Улсын гамшгийн нөхцөл байдал, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй болсон байна; Гамшгийн эрсдэлийг үнэлэх тогтолцоо бүрдэж, гамшгийн мэдээллийн сан бий болсон байна; Төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын түншлэл, хамтын ажиллагаа сайжирсан байна. 	<ul style="list-style-type: none"> Гамшгийн эрсдэлийг бууруулах эрх зүйн орчин сайжирч, гамшгийн эрсдэлийг удирдах тогтолцоо боловсронгуй болсон байна; Гамшгийн эрсдэлийг бууруулахад холбогдох талуудын оролцоо нэмэгдэж түншлэл хамтын ажиллагаа бэхэжсэн байна; Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр үндэсний стандартууд батлагдаж, үйл ажиллагаанд нэвтэрсэн байна. 	<ul style="list-style-type: none"> Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд зарцуулах хөрөнгө оруулалт нэмэгдсэн байна; Гамшгийн эрсдэлээс хамгаалах даатгалын тогтолцоо бий болох нөхцөл бүрдсэн байна; Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд дэвшилтэт технологи нэвтэрсэн байна. 	<ul style="list-style-type: none"> Орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөлт боловсронгуй болж, бэлэн байдал, хүч хэрэгслийн чадавх нэмэгдсэн байна; Онцгой байдлын байгууллагын чадавх сайжирсан байна; Шинээр баригдаж байгаа барилга байгууламжийн гамшгийн аюул, газар хөдлөлтөд тэсвэртэй байдал хангагдсан байна.

---oOo---

Хавсралт 4-й.

“ХОТУУДЫН ГАМШГИЙГ ТЭСВЭРЛЭХ ЧАДАВХЫГ ОНООНЫ АРГААР ҮНЭЛЭХ” АРГАЧЛАЛААР АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ХЭМЖЭЭНИЙ ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН

Аймгийн гамшгийг тэсвэрлэх чадавхын ерөнхий үнэлгээний дүн

Хүснэгт 1. 21 аймгийн төвийн гамшгийг тэсвэрлэх чадавхын ерөнхий үнэлгээний дүн
/Харьцуулсан байдлаар/


Д/д	Аймаг	Хотын нэр	2018		2022		Харьцуулалт	
			Чадавх Авах оноо 141 /100%/				Зөрүү	
			Авсан оноо	Хувь	Авсан оноо	Хувь	Оноо	Хувь
1.	Архангай	Цэцэрлэг	94	66.6	95	67.4	1	↑ 0.7
2.	Баян-Өлгий	Өлгий	55	39.0	65	46.1	10	↑ 7.0
3.	Баянхонгор	Баянхонгор	92	65.2	85	60.3	-7	↓ -5.0
4.	Булган	Булган	68	48.2	94	66.7	26	↑ 18.4
5.	Говь-Алтай	Алтай	62	44.0	77	54.6	15	↑ 10.6
6.	Говьсүмбэр	Чойр/Сүмбэр	79	56.0	100	70.9	21	↑ 14.9
7.	Дархан-Уул	Дархан	74	52.5	94	66.7	20	↑ 14.2
8.	Дорнод	Сайншанд	89	63.1	76	53.9	-13	↓ -9.2
9.	Дорноговь	Чойбалсан	93	66.0	90	63.8	-3	↓ -2.1
10.	Дундговь	Мандалговь	72	51.1	80	56.7	8	↑ 5.7
11.	Завхан	Улиастай	64	45.4	70	49.6	6	↑ 4.3
12.	Орхон	Эрдэнэт	94	66.7	98	69.5	4	↑ 2.8
13.	Өвөрхангай	Арвайхээр	94	66.7	95	67.4	1	↑ 0.7
14.	Өмнөговь	Даланзадгад	72	51.1	96	68.1	24	↑ 17.0
15.	Сүхбаатар	Баруун-Урт	83	58.9	92	65.2	9	↑ 6.4
16.	Сэлэнгэ	Сүхбаатар	83	58.9	80	56.7	-3	↓ -2.1
17.	Төв	Зуунмод	79	56.0	103	73.0	24	↑ 17.0
18.	Увс	Улаангом	111	78.7	106	75.2	-5	↓ -3.5
19.	Ховд	Ховд хот	51	36.2	96	68.1	45	↑ 31.9
20.	Хөвсгөл	Мөрөн	86	61.0	72	51.1	-14	↓ -9.9
21.	Хэнтий	Чингисхаан	99	70.2	102	72.3	3	↑ 2.1
Дундаж			80.06	57.2	89	63.0	8.9	5.8

Хавсралт 4-й.

Улаанбаатар хотын гамшгийг тэсвэрлэх чадавхын ерөнхий үнэлгээний дүн

Хүснэгт 2. Нийслэлийн гамшгийн тэсвэрлэх чадавхын ерөнхий үнэлгээний дүн
/Харьцуулсан байдлаар, 10 үндсэн чиглэлээр/

Үнэлгээ хийсэн он	2019 он	2022 он
Нийт авбал зохих оноо	590	565*
Авсан оноо	292	295
Чадавх (%)	49.4	52.2
↑ 2.8 хувь өссөн *Улаанбаатар хотын нөхцөлд тохируулан 5 шалгуур үзүүлэлтийг хасаж үнэлсэн		



Хүснэгт 3. Дүүргийн чадавхын ерөнхий үнэлгээний дүн
/Харьцуулсан байдлаар/

Дүүрэг	2018 он		2022 он		Харьцуулалт /зөрүү/	
	Нийт авбал зохих оноо 565					
	Авсан оноо	Хувь	Авсан оноо	Хувь	Оноо	Хувь
Багахангай	252	42.7%	339	60.5%	87	↑ 17.8%
Багануур	360	61.0%	441	74.7%	81	↑ 13.7%
Баянгол	173	29.3%	323	54.7%	150	↑ 25.4%
Баянзүрх	446	75.6%	313	53.1%	-133	↓ -22.5%
Налайх	262	44.4%	339	57.5%	77	↑ 13.1%
Сонгинохайрхан	376	63.7%	223	37.8%	-153	↓ -25.9%
Сүхбаатар	263	44.6%	258	44.9%	-5	↓ 0.3%
Чингэлтэй	253	42.9%	382	64.7%	129	↑ 21.9%
Хан-Уул	248	42.0%	396	68.3%	148	↑ 26.2%
Дундаж	293	49.6%	335	57.4%	42.3	7.8%

---oOo---

Хавсралт 5. Монгол Улсад зохион байгуулагдсан “Говийн чоно” олон улсын сургалт, дадлага сургуулийн жагсаалт, 2015-2022 он

Хугацаа	Байршил	Сэдэв	Оролцогчийн тоо			Оролцсон улс	Оролцсон аймаг, хот
			Монгол	Гадаад	Нийт		
2015.03.24-2015.03.27	Улаанбаатар хот	Газар хөдлөлтийн гамшгийн хор уршгийг арилгах ажиллагаанд цэрэг-иргэний байгууллагын харилцан ажиллагаа	85	15	100	АНУ	Улаанбаатар
2016.04.04-2016.04.08	Улаанбаатар хот, Орхон аймаг	Засгийн газар, орон нутгийн удирдлагын харилцан ажиллагаа	1500	27	1527	АНУ, Япон, Солонгос, Балба	Улаанбаатар хот, Орхон
2017.05.01-2017.05.05	Өмнөговь аймаг	Гамшгийн үе дэх бүс нутгийн удирдлага, харилцан ажиллагаа	390	50	440	Монгол Улс, АНУ, Япон, Балба, Өмнөд Солонгос, Турк, Канад, Унгар, Бангладеш	Өмнөговь, Дундговь, Дорноговь, Говьсүмбэр, Баянхонгор, Өвөрхангай
2018.05.28-2018.06.08	Ховд аймаг	Бүсийн удирдлага зохион байгуулалт, харилцан ажиллагаа	623	27	650	Балба, Шри-Ланка улсын төлөөлөл, Австрали, Канад, Франц улсын Элчин сайдын яам	Ховд, Увс, Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан аймаг, Нийслэлийн онцгой байдлын газрын төлөөлөл
2019.09.16-2019.09.21	Дорноговь аймаг	Орон нутгийн чадавх ба бүс нутгийн удирдлагын харилцан ажиллагаа	941	43	984	АНУ, Авсрали, Канад, Франц, Балба, Турк, Их Британи, Бангладеш, Индонез, Казахстан, Киргизста, Лаос, Шри-Ланка, Тайланд, Тажикистан, Вьетнам	Өмнөговь, Дорноговь, Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Говьсүмбэр, Баянхонгор аймаг, Нийслэлийн онцгой байдлын газар, Багахангай, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргийн онцгой байдлын хэлтэс
2021.09.14-2021.09.24	Архангай аймаг	Газар хөдлөлтийн гамшгийн хор уршгийг арилгах хариу арга хэмжээ	130	24	154	Япон, БНСУ, БНТУ-ын батлан хамгаалахын атташе нар	Өвөрхангай, Баянхонгор, Завхан, Архангай, Булган, Хөвсгөл
2022.09.05-2022.09.10	Баянхонгор аймаг	Газар хөдлөлтийн гамшгийн хор уршгийг арилгах хариу арга хэмжээ	262	48	310	АНУ, Вьетнам, Их Британи, Балба, Тайланд, Шри ланка, Шинэ Зеланд, Бангладеш	Говь-Алтай, Завхан, Өмнөговь, Дундговь, Өвөрхангай



Хавсралт 6

ГАМШГИЙН ҮЕД ТҮР БАЙРААР АШИГЛАГДАХ ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЖИШИГ БАРИЛГЫН МЭДЭЭЛЭЛ

Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлсэн “Улаанбаатар хотын бага, дунд боловсролын сургуулийн барилга байгууламжийг сайжруулах” (The project for the Improvement of Facilities for Primary and Secondary Education in Ulaanbaatar City in Mongolia) төслийн хүрээнд баригдсан 4 ерөнхий боловсролын сургуулийн барилгын мэдээлэл.

Эх сурвалж: “Улаанбаатар хотын бага, дунд боловсролын сургуулийн барилга байгууламжийг сайжруулах” төслийн судалгааны тайлангаас Хүснэгт 2-1, БСШУСЯ, 2018
https://openjicareport.jica.go.jp/pdf/12302170_01.pdf

Table 2-1 Models of School Construction

Model	A: Newly constructed schools incorporating universal design principles with due consideration to inclusive education and disaster preparedness		B: Schools with extended buildings having access-free floors at all levels, including the existing buildings, which serve as a future sub-center to prepare against disasters	
	A-1: Core school in the local communities located in an urban center	A-2: Newly established school with a standard capacity and functions	B-1: Large-scale expansion equipped with ancillary functions	B-2: Relatively small-scale expansion to provide more classrooms
Location	Urban center/Built-up area	Suburbs/rural	Urban center/Built-up area	Suburb/rural
Infrastructure	Available	Unavailable	Available	Unavailable
Needs	Overcrowded facilities resulting from classroom shortage	Shortage of primary and secondary school facilities	Overcrowded facilities resulting from classroom shortage	Shortage of secondary school facilities
Type of work	New construction		Expansion	
Component	A complete suite of components		Classrooms + ancillary functions + the existing buildings, being connected on each floor level	
Nominal capacity	920	720	480	320
considerations	Universal design	Barrier-free, accessible floors at all levels		Barrier-free in the extended areas and access-free at all levels to the existing buildings ⁸
	Inclusive setting	Enhanced functions of and expanded activities in Child Development Center, together with provision of relevant learning equipment		
	Disaster preparedness	Communal center or future sub-center for disaster protection		
Newly constructed school model (A-1, A-2)			Expanded school model (B-1, B-2)	
<p>Barrier-free access to all floor levels Universal designs Disaster preparedness</p> 				

Хавсралт 7

ГАМШГИЙН УЛМААС АМЬ НАСАА АЛДСАН, НЭРВЭГДСЭН ХҮНИЙ ТОО (КОВИД-19 халдварын дата мэдээг оруулсан байдлаар)

(НҮБ-ын Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийн явцын хяналтын тайлан)

Сендайн үйл ажиллагааны хүрээ: дэлхийн зорилт	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2005-2014 оны дундаж	2015-2021 оны дундаж (КОВИД-19 орсон)
Зорилт А 100000 хүн амд оногдох гамшгийн улмаас амь насаа алдсан хүний тоо	6.4	7.3	6.4	6.3	6.1	7.6	65.3	7.7	15.1
Зорилт В 100000 хүн амд оногдох гамшигт нэрвэгдсэн хүний тоо	225.4	295.6	267.9	320.6	218.8	185.3	20607.5	281.7	3160.2

Хавсралт 8

МОНГОЛ УЛСАД ТОХИОЛДСОН АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСЛЫН НЭГДСЭН МЭДЭЭНИЙ ТОЙМ (КОВИД-19 халдварын дата мэдээг оруулаагүй байдлаар)

Д/д		2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	Дундаж		Нийт	
																					2004-2014	2015-2021	2004-2014
1	Тохиолдсон аюулт үзэгдэл, ослын тоо	2338	2724	2659	3070	2759	2468	2976	3544	4045	4443	4926	5426	4381	4194	4373	4990	4006	4053	3268	4489	35952	31423
2	Нас барсан хүн	137	193	187	215	261	247	226	211	226	191	175	198	205	204	205	203	255	244	206	216	2269	1514
3	Өвчилсөн, бэртсэн, түлэгдсэн хүн	282	183	179	253	2593	1402	2413	342	100	203	243	85	61	62	67	153	1301	147	745	268	8193	1876
4	Хорогдсон мал /мян.толгой/	3.7	25.3	14.5	10.8	907	468.6	9736	166	13.0	235.6	15.1	203	1059	539	1417	26.1	80.954	163716	1054	23863	11594.3	167041.35
5	Шатсан гэр, орон сууц	788	1199	1150	1431	987	990	1560	1631	2155	2046	2062	1693	1657	1597	1755	1788	1514	1029	1454	1576	15999	11033
6	Эвдэрч нурсан гэр, байшин	209	80	219	234	889	320	234	150	196	484	193	204	948	516	1485	242	727	1999	292	874	3208	6121
7	Шатсан талбай /сая.га-аар/	0.11	4.3	5.6	1.3	1.02	0.4	1.01	2.1	5.0	5.6	2.9	6.5	3.2	0.58	0.56	0.3	253187	206368	3	65652	29.34	459566.14
8	Учирсан хохирол /тэрбум.төг-өөр/	3.4	5.4	12.5	201	35.1	16.3	534.8	9.6	94.5	21.9	25.2	79.9	43.1	96.7	81.9	35.8	31.3	25991.0	87	3766	959.3	26359.718
9	Аварсан хүн	222	249	286	443	2775	482	1699	2133	685	2032	839	1017	1315	1026	1125	1932	2239	3802	1077	1779	11845	12456
	эд хөрөнгө /тэрбум.төг-өөр/	6.2	7.6	6.8	10.3	10.9	14.3	16.9	22.2	25.7	25.6	22.9	23.4	23.6	21.8	41.9	63.3	114.5	114.5	15	58	169.4	402.9993

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Аюул, ослын мэдээ гаргах арга зүйн судалгаа, Гамшиг судлалын хүрээлэн, 2010
- ADPC, UNISDR (2015) санхүүжилттэй “Монгол Улсын Гамшгийн хохирлын мэдээллийн санг бүрдүүлэх, дүн шинжилгээ хийх чадавхыг сайжруулах төсөл”-ийн тайлан
- Галын аюулгүй байдлын тухай хууль, 2015
- Гамшгаас хамгаалах бодлого, стратеги, Гамшиг судлалын хүрээлэн, 2020
- Гамшгаас хамгаалах бодлогын өнөөгийн байдал, Б.Баянмөнх, 2020
- Гамшгаас хамгаалах төрийн бодлого, хөтөлбөрт хийсэн шинжилгээ, Д.Сэржмядаг, П.Чимэдцэрэн, Гамшиг судлалын үндэсний хүрээлэн, 2020
- Гамшгаас хамгаалах тухай хууль, 2017
- Гамшгаас хамгаалах цагаан ном-2021, Онцгой байдлын ерөнхий газар, 2022
- Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн тайлан, Онцгой байдлын ерөнхий газар, 2022
- “Говийн чоно” дадлага сургуулийн гамшгийн хор уршгийг арилгах чадавхыг бэхжүүлэхэд оруулсан хувь нэмэр, Б.Ууганбаяр, Д.Сэржмядаг, Д.Бат-Эрдэнэ, Гамшиг судлал, инновац сэтгүүл, 2022 №2
- Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад Монгол Улсын оруулах хувь нэмэр, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, 2015
- Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 303 дугаар тогтоол, “Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр”
- Монгол Улсын Засгийн газар, УОК-оос Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, халдварын тархалтыг бууруулах чиглэлээр гаргасан шийдвэр, холбогдох эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл, 2022
- Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 23 дугаар тушаалаар батлагдсан “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийг хэрэгжүүлэх эхний үе шат (2018-2020)-ны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн тайлан (ОБЕГ, 2021)
- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох асуудлыг гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа, тогтвортой хөгжлийн зорилттой уялдуулах нь илтгэл, П.Гомболүүдэв, 2019
- Хөвсгөлд живсэн машин, техник, ачааны байршлын тогтоосон судалгааны таарц, Х.Дашдэндэв, 2021
- Хөвсгөл нуурын ёроолын геодезийн хэмжилт, зураглалын ажлын зарим асуудалд, Л.Бат-Эрдэнэ, Л.Базарзагд, Д.Мөнхцэцэг, 2021
- Preparation Survey Report, Project for the Improvement of Facilities for Primary and Secondary Education in Ulaanbaatar City in Mongolia, 2018